

4 1985

АНАГААХ УХААН

ОРНУУЛИЙГ
ХАМГАЛЛАХЫН
ЗОХИОН
БАЙГУУЛАЛТ

СУДАЛГАА ШИНЖИЛГЭЭ

МЭРГЭЖЛИИН
ЗӨВЛӨЛГӨӨ
ЛЕКЦ, ТОЙМ

ТҮРШЛАГА СОЛИЛЦЬЁ

ХОВОР ТОХИОЛДОЛ

ГАДААД ОРНУУДАД

... ТУС ОРОНД ЖИНХЭН СОЁЛЫН ХУВЬСГАЛ БОЛЖ АРДЫН БОЛОВСРОЛ. ЭРҮҮЛИЙГ ХАМГААЛАХ, ШИНЖЛЭХ УХААНЫ ХӨГЖИЛД ТОМООХОН АМЖИЛТ ОЛЛОО.

ОРЧИН ҮЕИЙН АНАГААХ УХААН ХҮН АМЫН ЭРҮҮЛ МЭНДИЙГ САХИН ХАМГААЛАХ ҮЙЛСЭД ҮЙЛЧИЛЖ БАЙНА.

БНМАУ, ЗСБНХУ-ЫН ЭДИЙН ЗАСАГ, ШИНЖЛЭХ УХААН-ТЕХНИКИЙН ХАМТЫН АЖИЛЛАГААГ 2000 ОН ХУРТЭЛ ХӨГЖҮҮЛЭХ УРТ ХУГАЦААНЫ ПРОГРАММЫН «ХАМТЫН АЖИЛЛАГААНЫ ГОЛ ҮР ДҮН» ГЭСЭН ХЭСГЭЭС

БНМАУ-ын
Эрүүлийг хамгаалах Яамны
Эрдэм шинжилгээ-практикийн
улирад тутмын сэтгүүл

**Орон бүхний пролетари
нар нэгдэгтүн!**

АНАГААХ УХААН

16 дахь жилдээ №4/56/ 1985 он

АГУУЛГА

| | |
|---|----|
| Зорилтот программ, эрүүлийг хамгаалах | 3 |
| Б.Лхагважав, С. Цоодол —Ухамсартай сахилга хүнийг захирч удирдана (эчнээ бага хурлын үргэлжлэл) | 5 |
| Е. И. Чазов —Шинжлэх ухаан, мэргэн бодлөөр баахархана; | 10 |

ЭРҮҮЛИЙГ ХАМГААЛАХЫН ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

| | |
|---|----|
| Ц. Содномил —Тооцоолон бодох техник математик аргыг хэрэглэх нь эрүүлийг хамгаалахын удирдлагыг боловсронгуй болгох хүчин зүйл мөн. | 14 |
|---|----|

СУДАЛГАА ШИНЖИЛГЭЭ

| | |
|---|----|
| М. Сүхбаатар, Н. А. Аксенов —Хүүхдийн уушгыны үрэвслийн үеийн цусны реолог чанарын өөрчлөлт | 18 |
| Н. Мөнхтүвшин —Гуурсан хоолойн багтраа иммуны өвчин | 22 |
| Г. Пүрэвсүрэн, Б. Шаисирбаатар —Зүрхний эмгэгтэй жириэмсэн эмэгтэй чүүдийн төрөх явцын онцлог | 27 |
| Я. Дагвадорж —Хүүхдийн архаг гепатитын шалтгааныг судлах асуудал | 31 |
| П. Янсан —Малчдын өвчлөл, эрүүлжүүлэх асуудал | 33 |
| З. Мэндсайхан, В. Р. Зиц —Залуу хүмүүст тохиолдож байгаа шүүдэст плевритын зарим онцлог. | 36 |

МЭРГЭЖЛИЙН ЗӨВЛӨЛГӨӨ, ЛЕКЦ, ТОЙМ

| | |
|---|----|
| Г. Дэмид О. Батсүх, —Тархи тулгуур эрхтэнэй хавсарсан хүнд гэмтлийн үед мэс засал хийх асуудалд | 40 |
| Б. Гомбо —Хүүхдийн уушги-туурсан хоолойн өвөрмөц бус цочмог үрэвслийн шинэ ангиллын практик ач холбогдол. | 42 |
| Г. Гэндэнжамц —Порфирины өвчин | 46 |
| Д. Лунтан —Бага насын хүүхдийн цочмог бронхитын эмчилгээ | 49 |
| Б. Болдсайхан —Мэдрэлийн эс | 53 |
| Б. Нина Панкипсинаыг найруулан бэлтгэх, хэрэглэх | 56 |
| Б. Жав —Ургийн усны эмболи | 58 |

ТУРШЛАГА СОЛИЛЦЬЁ

| | |
|---|----|
| В. Е. Лапушкин —Сургуулийн хүүхдийг ойрын харалган, түүний дэамжраас сэргийлэх. | 63 |
| Б. Рагчаа, Ц. Ишхано —Элэгний цирроз өвчиний лабораторийн шинж тэмдгүүд | 65 |
| В. Ичинхорлоо, Б. Гоош, К. Анагүл —Мухар олгойн хурц үрэвслийг эрт оношилох шинэ шинж тэмдэг. | 67 |

ХОВОР ТОХИОЛДОЛ

| | |
|--|----|
| Д. Малчинхүү, Т. Оюунбилэг —Мөгөөрс төлжилгүйдэх өвчиний нэгэн тохиолдол | 70 |
| Н. Баасанжав, Т. Дулмаа —Чацархайн судасны түгжэрл | 71 |

ГАДААД ОРНУУДАД

| | |
|---|----|
| Шинжлэх ухаан эрэл хайгуулаа үргэлжлүүлж байна. | 73 |
| МЭДЭЭ | 78 |

Министерство
здравоохранения

МНР

Научно-практический
ежеквартальный журнал

Пролетарии всех стран,
ссоединяйтесь!

МЕДИЦИНА

Выходит с 1970г №4/56/ 1985г

СОДЕРЖАНИЕ

| | |
|---|----|
| Целевая программа и здравоохранение | 3 |
| Б. Лхагважав, С. Цодол —Сознательная дисциплина правит и руководит человеком (Заочная конференция читателей) | 5 |
| Е. И. Чазов —Наука гордится мудростью | 10 |

ОРГАНИЗАЦИЯ ЗДРАВООХРАНЕНИЯ

| | |
|--|----|
| Ц. Содномпил —Использование вычислительной техники и математи- ческих методов—главный фактор усовершенствования управ- ления здравоохранения | 14 |
|--|----|

ИССЛЕДОВАНИЯ

| | |
|--|----|
| М. Сухэ-Батор, Н. А. Аксенов —Реологические свойства крови при ос- тстрой пневмонии у детей | 18 |
| Н. Мунхтувшин —Бронхиальная астма—иммунное заболевание | 22 |
| Г. Пуревсүрэн, Б. Шижирбатор —Особенности течения родов у рож- ениц с сердечной патологией | 27 |
| Я. Дагвадорж —К вопросу изучения этиологических факторов хроничес- кого гепатита у детей | 31 |
| П. Янсан —Вопросы заболеваемости скотоводов и меры по оздоров- лению | 33 |
| З. Мэндсайхан, В. Р. Зий —К вопросу изучения экссудативных плев- ритов у молодых | 36 |

ОБЗОРЫ, ЛЕКЦИИ, КОНСУЛЬТАЦИИ

| | |
|---|----|
| Г. Дэмид, О. Батсух —К вопросу оперативных методов лечения боль- ных комбинированной тяжелой травмой черепа и опорных органов | 40 |
| Б. Гомбо —Практическое значение новой классификации неспецифи- ческих бронхолегочных заболеваний у детей | 42 |
| Г. Гэндэнжамц —Порфириловая болезнь | 46 |
| Д. Лунтан —Лечение острого бронхита у детей раннего возраста | 49 |
| Б. Болдсайхан —Нервные клетки | 53 |
| Б. Нина —Приготовление и применение панкипсина | 56 |
| Б. Жав —Эмболия околоплодными водами | 58 |

ОБМЕН ОПЫТОМ

| | |
|---|----|
| В. Е. Лапушкин —Профилактика миопии и её прогрессирования у школь- ников | 63 |
| Б. Рагча, Ц. Ишханд —Лабораторные признаки цирроза печени | 65 |
| В. Ичинхорлоо, Б. Гоош, К. Анаргул —Новый симптом раннего диагнос- тирования острого аппендицита | 67 |

РЕДКИЙ СЛУЧАЙ

| | |
|---|----|
| Д. Малчиевху, Т. Оюунбилэг —Один случай ахондроплазии у детей | 70 |
| Н. Басанжэ, Т. Дулма —Непроходимость брыжеечного сосуда | 71 |

ЗА РУБЁЖОМ

| | |
|------------------------|----|
| Наука продолжает поиск | 73 |
|------------------------|----|

| | |
|---------|----|
| ХРОНИКА | 78 |
|---------|----|

ЗОРИЛТОТ ПРОГРАММ, ЭРҮҮЛИЙГ ХАМГААЛАХ

МАХН-ын Төв Хорооны Х бүгд хурал хөдөө аж ахуйн болон хүнсний аж үйлдвэр, түүнтэй холбоо бүхий бусад салбарын хөгжлийн өнөөгийн байдалд дун шинжилгээ хийж, хүн амын хүнсний хангамжийг сайжруулах зорилтот программ батлан гаралаа.

Хөдөө аж ахуйг хөгжүүлэх, хүн амын хүнсний хангамжийг сайжруулах зорилтот программ нь МАХН-ын нийгэм эдийн засгийн бодлогын бүрэлдэхүүн хэсэг бөгөөд уг программын үндсэн агуулга нь ард түмний байнга өсөн нэмэгдэж байгаа хэрэгцээг улам бүрэн дүүрэн хангах явдал юм. Үүнд л хөдөө аж ахуйг хөгжүүлэх, хүн амын хүнсний хангамжийг сайжруулах зорилтот программын эдийн засаг, нийгэм улс төрийн ач холбогдол оршиж байгаа юм.

Хөдөө аж ахуйг хөгжүүлэх; хүн амын хүнсний хангамжийг сайжруулах зорилтот программд хөдөө аж ахуйг хөгжүүлж түүний үр ашгийг нь дээшлүүлэх, аж үйлдвэрийг түүхий эдээр, хүн амыг хүнсний зүйлээр найдвартай хангах зорилтыг нийгмийн асуудалтай (нийтийн ахуйн үйлчилгээ, эрүүлийг хамгаалах, ардын боловсрол гэх мэт) нягт уялдаатай шийдвэрлэхээр тусгасан байна. Энэхүү программын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор МАХН-ын Төв Хороо, БНМАУ-ын Сайд нарын Зөвлөл хэд хэдэн тогтоол гаргасны нэг нь „Хөдөөний хүн амын орон сууцны нөхцөл, соёл ахуйн үйлчилгээг сайжруулах зарим арга хэмжээний тухай“ тогтоол юм.

Энэ тогтоолд „Хөдөөний хүн ам малчдыг цаашид эмнэлгийн урьдчилан сэргийлэх арга хэмжээнд бүрэн хамардаг болох, эмнэлгийн нарийн мэргэжлийн тусlamжийг тэдэнд ойртуулах, үйлчилгээний чанарыг сайжруулах зорилгоор сум дундын зарим эмнэлгийг сум дундын нэгдсэн эмнэлэг болгох, сумдын их эмчийн салбарыг сумын эмнэлэг болгон өргөтгөн зохион байгуулах арга хэмжээг жил, таван жилийн төлөвлөгөөнд тусган хэрэгжүүлэх, аймгийн нэгдсэн эмнэлгийг нүүдлийн амбулаторийн тусгай тоноглогдсон автомашинаар хангах, хүн эмнэлгийн урьдчилан сэргийлэх ажилд малчид, орон нутгийн хүн амыг аль болохоор бүрэн хамрах, ариун цэвэр, ахуйн соёлын түвшинг дээшлүүлэхийн тулд хөдөөний нэгдсэн болон сумын эмнэлэгт ариун цэвэр, халдвэр судлалын станц группийг VIII таван жилээс эхлэн байгуулан ажиллуулах, эмнэлгийн түргэн тусlamжийн үйлчилгээнд зайлшгүй тохиолдолд нисэх онгоц ашигладаг болох“-ыг тусгаж заалаа.

Хөдөөний хүн амын эмнэлгийн үйлчилгээг сайжруулах арга хэмжээг хэрэгжүүлэх зорилгоор VIII таван жилээс эхлэн 2000 он хүртэл сум дундын 16 эмнэлгийг 75—100 ортой хөдөөний нэгдсэн эмнэлэг болгон өргөтгөн зохион байгуулж, тэнд нарийн мэргэжлийн тасаг кабинет байгуулж, чих, хамар хоолой, халдварт, арьс өнгө, нүд, эмгэг анатомын зэрэг нарийн мэргэжлийн эмч нар ажиллуулж тойргийн сүмдад нь үйлчлүүлснээр хөдөөний хөдөлмөрчид, малчид тариаланчдад үзүүлэх эмнэлгийн тусlamжийн төрөл, хэлбэр олширч хүртээмж нь сайжрах юм. Үүнтэй уялдуулан сум дундын нэгдсэн эмнэлгүүдэд ариун цэврийн их, бага эмч, лаборант, ариутгагч бүхий Ариун цэвэр халдвэр судлалын салбар станц байгуулан ажиллуулах юм. Ин-

нийг өв
лүүлэх
Үүн
урьдчил
захиалг
хаягдал
нар сай
хүнсний
гүй юм.

Эмн
дүнгээ

Ийм
хотын з
ахуй ба
Үүний э
жимсгэн
бал зох

Сүү
байгали
хэрэглэ
туршлал
хал бай
асуудлы
даалгав
хино.

УХААН

Ма
хам ху
Ан
мэргэж
ажилла
залууж

Хү
сонгос
лэн эр
Алтай
сумын
н. Ган

Эр
мүүжли
дын хе
лэхийн

Эр
эмч, м

гэснээр ариун цэвэр халдварт судлалын тусламж хөдөөний хүн амд улам бүр ойртож, халдварт өвчний голомтод авах арга хэмжээ сайжирч, улс, олон нийтийн ариун цэврийн хяналтын ажил, хөдөлмөрчдийн дунд зохиох ариун цэвэр гэгээрлийн сурталчилгааны ажлын чанар, үр нөлөө дээшлэх юм.

Говийн бүсийн сумд болон 2500-аас дээш хүн амтай Хангайн бүсийн сумдын их эмчийн салбарыг 50 хүртэл ортой сумын эмнэлэг болгож, дотор, хүүхэд, эх барих эмэгтэйчүүд, шүдний эмч ажиллуулна. 1986—2000 онд нийтдээ их эмчийн 120 салбарыг сумын эмнэлэг болгох өргөтгөн зохион байгуулна. Үүнтэй уялдуулан сум дундын нэгдсэн эмнэлэг, сумын эмнэлгийн барилгын нэг маягийн зургийг шинэчлэн гаргаж зориулалтын барилгаар хангах арга хэмжээ авах юм. Үүний зэрэгцээ сумын хүний их эмчийн салбарыг VIII, IX таван жилд багтаан 2—3 их эмчтэй болгох арга хэмжээ авч хэрэгжүүлэх юм.

Сумын эмнэлгүүдэд ариун цэврийн их, бага эмч, ариутгач бүхий ариун цэвэр халдварт судлалын үргэлжилж ажиллуулна. VIII таван жилд багтаан бүх аймгийг нүүдлийн амбулаторийн машинаар хангаж ажиллуулснаар хөдөөний хөдөлмөрчид, малчид тариаланчид, бригад суурь, хэсэг дээрээ лаборатори рентгений шинжилгээ хийлгэж, мэс засал, эх барих эмэгтэйчүүд, шүд, дотор, хүүхэд зэрэг үндсэн мэргэжлийн тусламж авах бодит нөхцөлөөр хангагдах юм. Эдгээр арга хэмжээний зэрэгцээ эмнэлгийн түргэн тусламжийн үйлчилгээнд зориулалтын тоног төхөөрөмж бүхий нисэх онгоц, нисдэг тэргийг өргөнөөр ашиглах болно.

Хөдөө аж ахуйг хөгжүүлэх хүн амын хүнсний хангамжийг сайжруулах зорилтот программд тусгагдсан дээрх арга хэмжээг хэрэгжүүлснээр хөдөөний хүн амын эмнэлгийн үйлчилгээ улам бүр сайжирч, эмнэлгийн үндсэн нарийн мэргэжлийн тусламжийн хүртээмж аймгийн төв, хотын хүн амын үйлчилгээний түвшинтэй адил хэмжээнд хүрэх юм. Хүн амын хүнсний хангамжийг сайжруулахад эмнэлгийн байгууллагууд ч чухал үүрэг гүйцэтгэх болно. Манай хот, хөдөөний эмнэлгийн байгууллагууд туслах аж ахуй хөгжүүлж өвчтөн, яслийн хүүхдийн хоолны материалын нэгээхэн хэсгийг туслах аж ахуйгаасаа хангаж байгаа ажлын дэвшилтэй хэлбэрүүд олон байна.

1984 оны жилийн эцсийн байдлаар Эрүүлийг хамгаалах салбарын 200 гаруй эмнэлэг, урьдчилан сэргийлэх байгууллагууд туслах аж ахуй хөгжүүлж 2,5 мянян толгой мал, 500 гаруй гахай өсгөж, 84,5 га талбайд төмс, хүнсний ногоо тариалж 14,6 тонн мах, 237 тонн төмс, хүнсний ногоо, 70,4 тонн сүүг туслах аж ахуйгаасаа авч ашиглласан нь 150 ортой нэгдсэн эмнэлгийн жилийн хэрэгцээг улсын төвлөрсөн бэлтгэлээс авахгүйгээр хангасантай адил юм. Энэ баримт бол эмнэлгийн туслах аж ахуй хүн амын хүнсний хангамжийг нэмэгдүүлэхэд зохих үр дүнгээ өгч байгаагийн тод жишээ юм.

Цаашид эмнэлгийн байгууллагууд ажилчдынхаа болон өвчтөний хоолны хэрэгцээт материалын дийлэнх хэсгийг туслах аж ахуйгаасаа хангах зорилт тавин ажиллаа шаардлага зүй ёсоор гарч байна. Ялангуяа гал тогоо бүхий эмнэлгүүд өвчтөний хоолыг амт чанар сайтай хийж хаягдлыг багасгах, хоолны үлдэгдэл гарах шалтгааныг таслан зогсоох арга хэмжээ авч өвчтөний хоолны хаягдлыг гарч тэжээх зэргээр зохистой ашиглахад анхаармаар байна.

Практикаас авч үзэхэд өвчтөний хоолны үлдэгдэл гарах хоёр үндсэн шалтгаан байна. Нэг талаас өвчтөний хоолны нэр төрөл цөөн, түүнийг амт чанар муутай хийдгээс, негөө талаас өвчтөний ар гэрээс тэдэнд эргэлт их ирж байгаагаас эмнэлгэгт хоолны үлдэгдэл их гарч байна. Иймээс эмнэлгийн газрууд хүнсний нарийн ногоо тариалах, гарч шувуу үржүүлж туслах аж ахуйгаас авсан бүтээгдэхүүн

нийг өвчтөний хоолонд өргөн ашиглаж нэр төрөл, амт чанарыг дээшлүүлэх нь эн тэргүүний зорилт болж байна.

Үүний зэрэгцээ амралт баяр ёслолын өдрүүдэд өвчтөнүүдээс урьдчилан саналыг нь авч эргэлт ирэх өвчтөнүүдийн хоолыг хоолны захиалганд оруулахгүй тооцож өвчтөний хоолыг бэлтгэвэл хоолны хаягдал эрс багасах бодит боломж байна. Өвчтөний хоолны амт чанар сайжирснаар хоолны хаягдал багасна. Энэ бүхэн нь хүн амын хүнсний хангамжийг сайжруулахад зохих үр дүнгээ өгөх нь дамжигүй юм.

Эмнэлэг дундын нэгдсэн туслах аж ахуй байгуулсан туршлага үр дүнгээ өгч байна.

Иймээс аймаг, хотын эрүүлийг хамгаалах газрууд, аймгийн төв, хотын эмнэлэг, яслийн туслах аж ахуйг нэгтгэн нэгдсэн туслах аж ахуй байгуулан төрөлжсөн хэлбэрээр ажиллуулах нь чухал байна. Үүний зэрэгцээ эмч, эмнэлгийн ажилчдаар төмс, хүнсний ногоо, жимс, жимсгэнэ тариулж ашиглуулах талаар тодорхой ажил зохион байгуулбал зохино.

Сүүлийн жилүүдэд жимс жимсгэнэ, мөөг, халиар, сонгино зэрэг байгалийн өгөөж баялгийг түүж яслийн хүүхэд, өвчтөний хоолонд хэрэглэх, зуны цагт цагаан идээ бэлтгэн ашигладаг сайхан туршлага аймаг, орон нутагт гарч байгааг улам өргөжүүлэх нь чухал байна. Үүнтэй үялдуулж туслах аж ахуйн төлөвлөлт, тайлагнах асуудлыг боловсронгуй болгож, байгалийн өгөөж баялаг ашиглах даалгавар, төлөвлөгөө өгч биелэлтийг дүгнэх журманд шилжвэл зохино.

УХАМСАРТАЙ САХИЛГА ХҮНИЙГ ЗАХИРЧ УДИРДАНА (эчнээ бага хурлын үргэлжлэл)

ЗАЛУУ ЭМЧ, МЭРГЭЖИЛТЭН

Манай улсын эрүүлийг хамгаалах салбарт ажиллагсдын 80 шахам хувийг залуучууд эзэлж байна.

Анагаах ухааны дээд, дунд сургуулийг жил бүр 1300 гаруй эмч, мэргэжилтэн төгсж төв хөдөөний эмнэлгийн байгууллагуудад очиж ажиллаж байгаа нь эрүүлийг хамгаалах салбарт ажиллагсад улам залуужсаар байгааг харуулж байна.

Хүнлэг, ачлалт сайхан чанарыг нь бахархаж эмнэлгийн мэргэжил сонгосон залуу эмч, мэргэжилтнүүд их, бага эмчийн салбараас эхлэн эрүүлийг хамгаалахын бүх цэг салбарт ажиллац байна. Говь-Алтай аймгийн Тонхил сумын их эмч И. Шижээ, Дундговь аймгийн Хулд сумын их эмч С. Орсоо, Хүүхдийн клиникин төв эмнэлгийн их эмч н. Гансүх нарын зэрэг тэргүүний залуу эмч, мэргэжилтэн олон байна.

Эрүүлийг хамгаалах Яам залуу эмч, мэргэжилтний мэргэжил хүмүүжлийг төлөвшүүлэх, ажил дээр нь дадлагажуулан сургах, ахмадын хөдөлмөрч уламжлал, эмнэлгийн ажилтны ёс суртахуун эзэмшүүлэхийн тулд нилээд ажил зохиож байна.

Эрүүлийг хамгаалах байгууллагын удирдах албан тушаалд залуу эмч, мэргэжилтнийг томилж ажиллуулахдаа урьдаар ахмад туршлага-

тай зохион байгуулдагч нарыг тодорхой хугацаагаар дагалдуулан ажиллуулж газар дээр нь зааж зөвлөн, сургаж дадлагажуулж байна.

Төв, хөдөөний эмнэлгийн байгууллагууд шинэ залуу эмч, мэргэжилтнийг аймаг, орон нутгийн ажил амьдралтай танилцуулж, юуг анхаарах, яаж ажиллавал зохицыг зааж зөвлөдөг.

Булган аймгийн эрүүлийг хамгаалах газар шинээр очсон эмч, мэргэжилтнийг аймгийн нэгдсэн эмнэлэгт дадлага хийлгэсний дараа уг ажиллах газарт нь томилдог байхад улсын клиникин төв эмнэлэг залуу эмч, мэргэжилтнийг нарийн мэргэжлийн тасгуудад ээлжлэн ажиллуулж эмнэлгийнхээ аль ч тасагт бие даан ажиллах дадлагатай болсон үед нь мэргэжил дээр нь ажиллуулдаг байна.

Говь-Алтай аймгийн Эрүүлийг хамгаалах газар ажил, мэргэжлийн дадлага, туршлага суугаагүй эмч, мэргэжилтнийг аймгийн нэгдсэн эмнэлэгт сургах ажил хийж байна. Уг хүнд мэргэжлийн ямар дадлага дутаж байгаа чиглэлээр төлөвлөгөө гарган эх барих, судас тариа хийх зэрэг эмчийн хийх ёстой зарим ажилбарыг гардан хийх дадлага эзэмшигүүлээд шалгалт авч ажил дээр нь гаргадаг байна.

Тус аймгийн энэ туршлагыг бусад аймаг, хотод дэлгэрүүлэх нь зүйтэй юм

Дорнговь аймгийн Эрүүлийг хамгаалах газар эмч нарт нарийн мэргэжил эзэмшигүүлэх талаар анхаарч, сургууль төгсөөд З-аас дээш жил тус аймагт ажиллаж байгаа эмч нарт нарийн мэргэжил эзэмшигүүлсэн нь тэдний тогтвортруулж сургууль сайжрах, мэргэжлийн ур чадвар ёсөх, ажлын үр бүтээл гаргахад сайнаар нөлөөлж байна.

Залуу эмч, мэргэжилтнийг ажлаа бүрэн эзэмших сонирхлыг нь бадрааж ажлын амтанд оруулах явдал хамт олны чухал үүрэг юм. Эмнэлэг үйлчилгээний ажлыг зохион байгуулах, өвчнийг танъж мэдэх, зөв оношлох, эмчлэх дадлага эзэмших, ажлын хариуцлага, ёс суртахууны хүмүүжлийг дээшлүүлэхэд ахмад эмч, мэргэжилтний зөвлөмж, туршлага их хэрэгтэй.

Эрүүлийг хамгаалах Яам жил тутам аймаг, хотын эрүүлийг хамгаалах байгууллагуудад ахмад ажилтны зөвлөн туслах үзлэг хийж шалгаж зааварлах, зөвлөн сургах ажлыг зохион байгуулж байна; Ийм үзлэг Улаанбаатар, Дархан, Эрдэнэт хот, Баянхонгор, Хөвсгөл аймгийн Эрүүлийг хамгаалах байгууллагуудад хийсэн бөгөөд үзлэг угтаж эмнэлгүүд тусгай төлөвлөгөө гарган, ажлынхаа амжилтыг ахмадууддаа рапортладаг уламжлал тогтоо. Ахмад болон залуу эмч, мэргэжилтнийг ухаалгаар хослон ажиллуулах, дагалдуулан сургах явдал эмчилгээ үйлчилгээний ажлын чанар, үр дүнг сайжруулахад чухал ач холбогдолтой. Ийм ч учраас эмнэлгийн байгууллагуудад залуу эмч, ажилчдыг халамжлан хүмүүжүүлэх зөвлөл, хэсэг байгуулан тэдний ажиллах журмыг яамнаас батлан мөрдүүлж байна.

Анагаах ухааны дээд, дунд сургуулийн багш, орон нутагт ажиллаж байгаа эмч, мэргэжилтний хооронд багш-шавийн уулзалтыг жил бүр зохиож байгаа нь багш хүн сургаж хүмүүжүүлсэн эмч мэргэжилтнийхээ ажилтай танилцсан, хүн бүрийн ажилд үнэлэлт дүгнэлт өгч цаашид юу хийхийг нь зөвлөж өгдгөөрөө багшийн сэтгэлийг хөдөлгөж, шавийн урмыг сэргээсэн ажил болдог.

Багш хүн, хүний амьдралын турш багш хэвээрээ байдаг болохоор амьдралын цээнд хүрсэн үедээ ч гэсэн багшдаа шалгуулж дүгнүүлнэ гэдэг багш, шавь аль алинд нь их хариуцлага ногддог.

Зарим ахмад эмч, мэргэжилтэнд Эрүүлийг хамгаалах Яамны сайд мэргэжлийн залуу халаа бэлтгэх яамны хүндэт даалгавар гардуулсан юм. Энэ бол эмнэлгийн ахмад үеийнхний нийгмийн өмнө хүлээсэн гавьяат үүрэг болохоор ийм хүндэт даалгавар авсан эмч, эрдэмтэд маань өндөр мэргэжлийн боловсон хүчин бэлтгэх үйлст бүтээлч хувь нэмрээ оруулахаа илэрхийлсэн юм.

Энэ бол ахмадын залуу халааг бэлтгэх, ажил мэргэжлийн холбоог бэхжүүлэх ахмад үеийнхнийхээ мэдлэг, дадлагыг өвлөн авч үлдэх чухал ач холбогдолтой арга хэмжээ юм.

Эмнэлгийн байгууллагуудад ийм ажлыг өргөнөөр зохиож шаардлагатай. Залуу эмч, мэргэжилтнийг амьдралд төлөвшүүлж ажил дээр чи сургахад эмнэлгийн хамт олны улгэр жишээ, нөлөө, тус дэмжлэг ус агаар шиг хэрэгтэй. Хамт олны итгэл найдварыг нэр төртэй бие-лүүлэх өндөр эрмэлзэл залуу хүн бүрт байдаг болохоор тэдэнд тодорхой ажил даалган олolt амжилтыг нь дүгнэх, тогтмол зөвлөж байх нь амьдралц байр сууриа олж нэр хүндтэй ажиллах гол түшиг болно. Гэвч эмнэлгийн байгууллага бүр залуу эмч, мэргэжилтэн наратай жигд сайн ажиллаж чадахгүй байна.

Зарим эмнэлгийн байгууллагад „сургууль төгссөн хойно ажиллах л ёстай“, „юм бүхнийг мэддэг, чаддаг байх ёстай“ гэсэн хөшүүн байдлаар залуу эмч, мэргэжилтэнд ханддаг байна. Энэ нь тэднийг тогтвортсуурьшилтай ажиллахын оронд ажилдаа дургүй болгох, алдаа дутагдал гаргахад хүргэж байна.

Залуу үеийнхээ төлөө анхаарал хalamж тавьж эмнэлгийн бахархах үйлсийг нэр төртэй залгамжлагчид болгон ажил. амьдралд төлөвшүүлэх явдал эрүүлийг хамгаалахын ахмад үе, хамт олны нэр төрийн хэрэг нийгэмд хүлээсэн үүрэг бөгөөд энэ үүргээ хэрхэн биелүүлж байгаагаар байгууллага хамт олны ажил дүгнэгдэх учиртай.

Эмч мэргэжилтэн нарын бүтэц ихээхэн залуужиж шинэ арга бариллаар ажиллахыг шаардаж байгааг эрүүлийг хамгаалахын зохион байгуулагч бүр ухамсарлаж ажлынхаа арга барилыг өөрчлөх ёстай. Ахмад үеийн хувьсгалт дайчин хөдөлмөрч уламжлалаар хүмүүжүүлэхэд цаг ямагт санаа тавьж эмнэлгүүдийн дэргэдэх ахмадын зөвлөл, халамжлан хүмүүжүүлэгчдийн ажлыг тодорхой үр нөлөөтэй болгоход анхаарч, залуу эмч, мэргэжилтнийг хөдөлмөрт хатуужуулж, амьдралд зохих байр суурь олоход нь тусалдаг хүч болгох хэрэгтэй. Залуу эмч мэргэжилтний зөвлөлгөөн семинарыг үе үе зохиож тэдний санал, эрэлт хүсэлтийг авч тодорхой ажил зохион байгуулж байх хэрэгтэй.

Залуу эмч, мэргэжилтэн өчүүхэн алдаа дутагдал гаргасан даруйд хамт олноор хүмүүжүүлэхийн оронд элдвэр сүржигнэн буруутгах түүнтэй ажиллахаас ямар нэг байдлаар зайлсхий, хөндий байх илрэл хандлага нь тэдний урам зоригийг хугалах төдийгүй ажил амьдралд нь ноцтой хохирол учруулдгийг эмнэлгийн удирдлагага ямагт анхаарч ажиллах ёстай. Манай ард түмний „Урмыг нь хугалахаар ууцыг нь...“ гэдэг сайхан зүйр үгийг удирдах зохион байгуулагчдын санаж байвал зохих сайхан уг юм.

Эмнэлгийн байгууллагын ажилтан, ажилчид, цаашид улам залуужиж учраас залуу эмч, мэргэжилтэн бүртэй ажиллах ажиллагааг шинэ шатанд гарган сургаж хүмүүжүүлэх явдал эрүүлийг хамгаалах байгууллагын чухал зорилт бэлж байна.

Эрүүлийг хамгаалах Яамны бологос я хүчин сахиргааны газрын дарга Б. ДЛАГВАЖАВ.

ЭМЧИЙН ЁС СУРТАХУУН, ОРЧИН ҮЕ.

Манай ардын эрүүлийг хамгаалахын хөгжлийн өнөөгийн щар хэмжээ нь нам засгаас ард түмнийхээ сайн сайхны төлөө тавьж байдаг байнгын анхаарал халамж, тус орны социалист байгуулалтын гайхамшигт ололтын нэг тод илрэл болж байна.

Социалист нийгмийн харилцааны хөгжлийн өнөөгийн шатанд эмнэлгийн ажилтны зан байдал, ёс суртахууны үүрэг, ач холбогдол үлэмж өсөж, социалист энэрэнгүй үзэлд тулгуурласан эмчийн ёс суртахууны зарчмыг эмчлэх, урьдчилан сэргийлэх практик ажиллагаанд бүрэн хэрэгжүүлэх нь эмнэлгийн үйлчилгээний чанар, үр ашгийг дээшлүүлэх нэн чухал хүчин зүйл боллоо.

Эмчийн хөдөлмөрийн нийгмийн зохион байгуулалтын хэлбэр, түүний материаллаг хэрэгцээг хангаж байгаа арга нь эмчийн мэргэжлийн ёс суртахууныг тодорхойлогч бодит нөхцөл бөгөөд тухайн нийгэмд ноёрхож буй үйлдвэрлэлийн харилцаа. Эдийн засаг улс төрийн бодлого, үзэл сургал нь түүхэн тодорхой үе дэх эмчийн ёс суртахуунд тусгалаа олж, онцлог шинжийн объектив үндэс болдог.

Хөрөнгөтний нийгэмд эмч нар нь өвчтөнд эрүүл мэндийг нь худалдаж, түүнийг өндөр ашигтай өвөрмөц хэлбэрийн таваар болгогч жижиг худалдаачин, мөлжигчид байдаг. Хүний эрүүл мэндэд хувийн ашиг орлого олох, шан харамж авах, баяжих уг сурвалж болгох үүднээс ханддагаас анагаах ухаан нь өвчтөний хөлс төлөх чадвараас хэмжээ, чанар нь хамаардаг үйлчилгээний хүрээ болон хувирч, анагаах ухааны нийгэм- ёс суртахууны агуулга зөрчилд орж, хүнлэг энэрэнгүй үзэл санаа нь алдагдаж, мэргэжлийн ур чадвараа худалдаж байгаа эмчийн хувийн ашиг сонирхолд өвчтөний эрх ашиг дарагддаг явдал нь капиталист орууд дахь хувийн эмнэлэг, эмч нарын үйл ажиллагааны мөн чанар юм.

Нийгмийн шинэ харилцаанд үндэслэн мэргэжлийн ёс суртахууны үүрэг, мэргэжлийн нэр төрөө мэдрэх мэдрэмж социализмын үед шинэ агуулгатай болж, дээд зэргийн хүнлэг зорилгсо хэрэгжүүлэх бүрэн бололцоо эмч нарын өмнө нээгддэг. Социалист эдийн засаг, улс төрийн харилцаа эмч наарт мэргэжлийн үүргээ ухаасрахад нь нөлөөлж, эмчийн ёс суртахууны зарчим, хэм хэмжээний үйлчлэх хүрээг өргөсгөж, дэвшилтэт агуулгаар баяжуулж, эмчийн үйл ажиллагааг идэвхжүүлж ажлын хариуцлага, ухамсарт хандлагыг өндөржүүлж, хөдөлмөрт ксммунист ёсоор хандах явдлыг төлөвшүүлэх чухал хүчин зүйл болж байна.

Эмчийн ёс суртахууны нүүр царайг илэрхийлэгч гол хэмжүүр бол өвчтөнтэй харьцах харьцаа юм. Өвчтөн, эмчид эрүүл мэнд амь наасаа даатгахдаа ёс суртахууны дээд чанарыг хүсэн хүлээж, эмчийг хүнлэг сайн үйлийн төвлөрөл, энэрэнгүй өрөөн үзэлтэн, шударга, сахилга баттай, авхаалж самбаатай, ажил хэрэгтээ үнэнч хандагч гэж итгэж байдаг. Эмчийн нэр төр, итгэн үнэмшүүлэх хүч нь өвчтөнд ямар ч бэрхшээл саадыг давах хатуужлыг өгдөг. Үүний тулд эмчээс өвчтөнд хандахдаа түүнийг сэтгэл санааны давтагдашгүй ертөнч бүхий хувь хүн, бодьгал чанар гэж үзэж, мэргэжлийн өндөр мэдлэг, эмчлэх ур чадвар, эв дүйн хүчээр өвчтөний сэтгэл санаа, зан байдлын онцлогийг олж илрүүлэн түүнд нөлөөлөх ёс суртахуун, сэтгэл зүйн харилцааны хэлбэр, арга барилыг эмчлэх зорилго чиглэлийг хангах үүднээс сонгон, сэтгэл санааг нь эзэмдэж, зан харьцааны харилцан ашигтай холбоог тогтоох щаардлагатай. Эмч өвчтөний одон талт харилцаанд эмчийн хэлсэн үг онцгой ач холбогдолтой. Тухайн өвчтөний хувийн онцлог, зан араншинд тохируулалгүй хайхрамжгүй, болгоомжгүй хэлсэн ганц үг ч өвчтөнийг өөрөөсөө хөндийрүүлж, анагаах ухаан, эмнэлэгт үл итгэх байдалд оруулж, эмнэлгийн байгууллага, эмч нарын нэр хүндийг сэвтээх, өвчтөний эрүүл мэндийг хохироох, тэрээр эрүүл мэндээ „бариачийн авралд“ даатгах байдалд хүргэж болох юм.

Эмчийн ёс суртахууны хувиран өөрчлөгдөшгүй зарчим, шаардлагуудын зэрэгцээ нийгмийн дэвшил, анагаах ухааны хөгжлийн тодорхой шатны онцлогоор нөхцөлдсөн шинэ шаардлагууд дэвшигдэн гарч байдаг байна. Анагаах ухаан, түүний практикийн томоохон ололт бүхэн анагаахын ёс зүйн шинэ шаардлагыг төрүүлж, эмчийн мэргэжлийн болоод нийгмийн идэвх нь анагаах ухааны хөгжлийг даган урагшилж байдгаас шинжлэх ухаан, ёс суртахууны холбоо улам бэхжиж, эмчийн зан суртахууны хэм хэмжээг шинжлэх ухааны үндэслэж, анагаах ухааны мэдлэгийн өндөр төвшинг ёс суртахууны шаардлагаар баяжуулан дэмжих үйл явц өнөөгийн онцлог болж байна.

Орчин үед эмч нар ард түмний материаллаг аж байдал, соёл, боловсролын төвшин эрс дээшилсэн, анагаах ухаан, эрүүлийг хамгаалах байгууллагаас нийгмийн амьдрал, хөгжил дэвшилд гүйцэтгэх үүрэг өссөн, эмнэлгийн байгууллагын нэр хүнд, үйлчилгээний чанар үр нөлөөг үнэлэхэд эмч, ажилтны соёлч боловсон байдал, зан суртахууны төлөв нь нэн чухал үзүүлэлт болж, эмчийн мэргэжил олон төрлөөр ялгаран нарийч анагаах ухаан хурдан явцтай өсөж байгаа нөхцөлд ажиллаж байна. Энэ байдал нь эмчийн хөдөлмөрийн агуулга хэлбэрт нөлөөлж, мэргэжлийн ёс суртахууны шинэ шаардлагыг дэвшигүүлж байна.

Анагаах ухааны ялгаран төрөлжилт, техникжилт нь хөгжлийн зүй ёсны гарцаагүй үр дүн, орчин үеийн онцлог нь мөн юм. Үүнтэй холбоотой тодорхой нарийн мэргэжлийн эмч, ямар ч өвчнөөр өвчилсөн өвчтөнд эмнэлгийн зохих тусlamжийг цаг хугацаанд нь үзүүлж байх мэргэжил ёс суртахууны шаардлага чухлаар тавигдаж байна. Түүнчлэн аливаа нарийн мэргэжлийн эмч өвчтөнийг үзэхдээ зөвхөн өөрийн мэргэжлийн хүрээнд явцууран, хүний биеийн „нэг хэсэгт“ бий болсон эмгэг өөрчлөлтийг бүхэл бүтэн бие маход, тодорхой хувь хүнээс „таслан“ авч онцгойдлон анхаараад бие маход, түүний үйл ажиллагааны түгээмэл хэлхээ холбоо, бүхэл нэгдмэл чанарыг мартаж болохгүй. Мэргэжил ялгаран нарийссанаас эмчийн хувьд өвчтөнд үйлчлэх үүрэг нь олон нарийн мэргэжилтний дунд уусан тодорхой эзэнгүйдэх, эсвэл өвчтөнийг бие биерүүгээ түлхэх байдлаар чирэгдүүлэн хохироож, цаг алдсанасаас өвчний тавиланд хортойгоор нөлөөлөх байдалд хүрвэл энэ нь эмчийн ёс суртахуун, нийгмийн өмнө хүлээсэн үүргээ ноцтой зөрчсөн хэрэг болох юм. Эмчийн мэргэжил ялгаран нарийссанаас өвчтөний хувь заяаны төлөө хүлээх хариуцлагыг олон мэргэжлийн эмч нар хуваах ёстой мэт ойлголт гарч, хариуцлагыг хамт олонд тохох нь эмчийн хувийн хариуцлагыг буруу үнэлэх ноцтой хор уршигт хүргэнэ.

Орчин үед анагаах ухаанд өвчтөнийг шинжлэн судлах; эмчлэхэд техник аппарат хэрэгсэл өргөн нэвтэрч байгаа нь эмнэлгийн практикт лаборатори, техник шинжилгээний үүргийг хэт туйлшуулан үзэж, өвчтөнийг элдэв аппаратын тусlamжтайгаар гарган авсан математик үзүүлэлтүүдийн механик нэгдэл мэт үзэх хандлагад хүргэх ёсгүй. Өвчтөнийг тодорхой хувь хүний хувьд тухайлсан үзэх, нэг бүрчлэн анхаарах сонгодог уламжлал, өвчний эмнэл зүйн явц хүмүүст өвөрмөц байдлаар илрэх онцлогийг тооцох, хамгийн гол нь өвчтөнтэйгээ харилцан ярилцаж, зовлон шаналгааг нь хуваалцаж, сэтгэл санааны дэмжлэг үзүүлэх, зайлшгүй биечлэн үйлчлэх ажиллагааны ач холбогдлыг бууруулж болохгүй юм.

Социалист эрүүлийг хамгаалахын жанжин шугам, гол зарчим урьдчилан сэргийлэх чиглэлийн ач холбогдол ихээхэн өсөж байна.

МАХН-ын XVIII их хурлаас ард түмний эрүүл мэндийг хамгаалах чухал арга болсон урьдчилан сэргийлэх ажлыг хүчтэй болгохыг эрүүлийг хамгаалах салбарын гол зорилт гэж заасан билээ. Намын энэ заалтыг хэрэгжүүлэх гол зам нь нийт хүн амд эрүүл аж төрөх ёсыг хэвшигүүлэх, анхдагч урьдчилан сэргийллийг өрнүүлэх явдал бөгөөд

үүнтэй холбоотой өвчтөн төдийгүй эрүүл хүмүүс эрүүлжүүлэн сэргийлэх ажиллагааны объект болж байна. Энэ учраас урьдчилан сэргийлэх үйл ажиллагаа аль ч мэргэжлийн эмчийн ёс суртахууны агуулга болж ирлээ. Түүнчлэн эмчийн мэргэжлийн үйлчилгээний хүрээнд тодорхой өвчтөн, эрүүл хүн төдийгүй нийгэм бүхэлдээ хамрагдах явц өрнөж байна. Нийгэм-экологийн эрүүл саруул нөхцөлийн төлөө эмчийн тэмцэл нь үүгээр нөхцөлдөнө. Эмч анагаах ухааны нийгмийн асуудалд ухамсартай хандаж энэ үндсэн дээр мэргэжил ёс суртахууны үүргээ билүүлэх нь эмчээс нийгэмд хандах хандлагын чиг шугам мөн.

Орчин үед эмнэлгийн ажилтуудын хоорондын харилцааг зохицуулдаг үндсэн зарчим-хамтак ёсны роль өсөн нэмэгдэж байна. Энэ бол өвчтөний эрүүл мэндийг сэргээж, бэхжүүлэхийн төлөө тэмцэлд хамтран ажиллаж, нэгдмэл байх, өвчтөний ашиг сонирхлын үүднээс бие бие хүндэтгэх, нөхөрслөөр хамтран ажилдах явдалд үндэслэдэг.

Нэр алдар хөөцөлдөх, мэргэжил нэгт нөхдийн зөвлөлгөөг үл сонсох, өвчтөний дэргэд нөхдийн иэр хүндэд харш байдал гаргах, нөхрийн алдааны талаар дуугүй өнгөрөх зэрэг хамтак ёсны гажуудлын илрэлийг ёс суртахууны үүднээс шүүмжлэн эвлэршгүй тэмцэж, тухай бүр арилгаж байх ёстой. Хамтак ёсны зарчим нь анагаах ухааны техникижт эрчимжиж, эмчийн мэргэжил ялгаран нарийссанаар үүсэж буй зарим сөрөг үр дагавартай амжилттай тэмцэж, мэргэжлийн алдаанаас сэргийлэх хамгийн чухал хэрэгсэл юм.

Империализмын буруугаар дайны аюул өсөн нэмэгдэж байгаа орчин үед хүний амь нас, эрүүл мэндийг хамгаалахад чиглэсэн хамгийн хүнлэг энэрэнгүй мэргэжлийн төлөөлөгчид болохын хувьд эмч нар дайны аюулын эсрэг тэмцлийн тэргүүн эгнээнд байж, шинжлэх ухааны мэдээ баримтыг ашиглан зэвсэглэлээр хөөцөлдөх цөм, хими, бактериологийн зэвсгийг бүтээх явдалтай холбогдон хүмүүсийн амь нас, эрүүл мэндэд заналхийлж байгаа бодит аюулыг илчлэн харуулахын төлөө тэмцэх явдал бол эмчийн энэрэнгүй үзэл, ёс суртахууны чанарын зайлшгүй шаардлага болон тавигдаж байна, Түүнчлэн хөрөнгөтний нийгмийн захиалгаар төрөн гарч байгаа, хүнлэг бус, арьс өнгөөр ялгаварлан гадуурхах үзэл, дайнч номнол, хөрөнгөтний нийгмийн ялзрал, мөхлийг хаацайлах зорилгоо, биолог, анагаах ухаан, генетикийн шинжлэх ухааныг ашиглахыг санаархсан үзэл суртлын хорлон сүйтгэх ажиллагааг илчлэн, няцаахад эмч нарын оруулах хувь нэмэр чухал байрыг эзэлж байна.

**Улсын ариун цэвэр, халдварт судалалыг байцаан шалгах
газрын ажилтан С. ЦООДДОЛ**

ШИНЖЛЭХ УХААН, МЭРГЭН БОДЛООР БАХАРХАНА

АКАДЕМИЧ Е. И ЧАЗОВ

Шинжлэх ухаан гэдэг бол өвчинеэс урьдчилан сэргийлэх, эмчлэх арга хэргэслийг аяндаа бий болгож байдаг эд шид биш. Шинжлэх ухаан гэдэг нь хөдөлмөр, тэр тусмаа олон үеийн эрдэмтдийн уйгагүй, нэр тих хөдөлмөр билээ. Нэг шинэ эм буюу энгийн хийцтэй хирнээ оношлогооны зориулалттай шинэ аппаратын цаана, маш одон эрдэмтэн, эмч нарын хөдөлмөр байгаа юм гэдгийг уншигчид маань ойлгоосой. Тэдгээр хүмүүсийн амьдралын зам дандаа сарнай цэцгээр бүрхмэл байдаггүй гэж итгэгтүн.

Зарим нэг хүн хэдийгээр үл итгэх байдлаар ханддаг ч гэсэн анагаах ухааны ололт, амжилт маргашгүй юм. Энэ бол хэдэн арван зуун мянгаар аврагдсан амь нас, энэ бол эмнэлэг эрүүл мэндийг нь эргүүлж өгсний ачаар нийгэмдээ дахин

хөдөлмөрлөж, хувь нэмрээ оруулах боломжтой бэлсөн түм буман хүний баяр жаргал билэв.

Гэвч харамсалтай нь зарим өвчиний эмчилгээнд бид хүчин мөхөсдөж байгаа-гаар эрүүл мэндээ, зарим үед амь наасаа аврахын төлөө өвчтөн өөрөө юмуу төрөл төрөгсдөөс нь бүхнийг хийх гэсэн эсны эрмэлзэл нь зарим хүнийг „уламж-лалт бус эмчилгээний аргын“ төлөөлөгчид гэгдэгчдэд очиход хүргэж байна. Үүний цаанаа чухам юу нуугдаж байдгийг хэн ч мэдэхгүй. Яңз бүрний бацаа алганы хээгээр мэрэглэгчид, цус гаргалгүйгээр мэс засал хийгчид, төрөл бүрний домч зэрэг элдэв мэхлэгчид „уламжлалт бус арга“ гэдгээр бамбай хийж байна.

Иймэрхүү төрлийн „оточ“ нартай би няг бус удаа тааралдаж байсан бөгөөд харин бидний хүчин мөхөсдөх үе, зарим эмч нарын гаргасан алдаа юмуу өвчтөний хувь заяанд хайхрамжгүй хандсан цалгар назгай байдлыг тун овжин ашиглаж чаддаг нь надад ямарг гайхаш төрүүлдэг байлаа. „Уламжлалт бус аргын“ ихэнх төлөөлөгчид өвчтэй хүний сэтгэл зүй маш сайн эзэмдэж өөрийнхөө зорилгод чадамгай ашиглаж сурсан байдал: Гэвч хэзээ нэг цагт бид жишээ нь хорт хавдар, судас хатууралт, сэтгэл мэдрэлийн зарим өвчинтэй наidvэрттай тэмцэж чадах сайн зүйл олсон хойно „уламжлалт бус эмчилгээний арга“ үл мөргүй ажилдаггүй юмаа гэхэд үндэс ёзоорооро өгөрч гандана гэдэгт эргэлзэх зүйл. үй.

Ид шидтэй бурхны хөрөг, „гэгээн“ хүч чадал, „арнун“ булаг шалд, элдэв шившэгэнд хүмүүс итгэн шүтсээр л байсан. Энэ шүтгэлт хүмүүс тэдгээрний үгээр бол тус нэмэр болж байсныг түүх шашдираас ч олж мэдэж боло.

Үүнтэй холбоотойгоор 1964—65 оны үед гарсан „соронзон“-гийн ид шидийн тухай шуугиан над санагдаж байза. Ялангуяа японы соронзонт бугуйчнууд барааг л өвчин бүхнээс анагаах ид шидтэй мэт цуурхаж байв. Намайг дотор өвчин судлалын хүрээлэнгийн захирал байх үед. Японы соронзонт бугуйч үйлдвэрээдэг пүүсний эзэн нэг удаа уулзаж билээ. Цахилгааны ердийн механикийн мэргэжилтэй тэр хүн бугуйчны үйлдвэрлэлээс бага зэрэг хөрөнгөжик чаджээ. XVIII зууны сүүлчээр тэр үед нэлээд нэrd гарсан эмч Месмер гэгч амьтын соронзон зүйн тухай өөрийн онолоо гаргасан боловч соронзонгийн ид шидийн талаархи шуугиан эдүгээ нэгэнт үеэ ёнгөрөсөн гэдгийг би түүнд хэлж улам хөрөнгөжихөөр горьдож байсан урмыг нь хугалсан юм.

Ихэнх эрдэмтэд, эмч нар Месмерийн онолыг няцаасан ч гэсэн түүний алдар цуу өргөн тархаж сэтгэл мэдрэлийн хямрал, ядаргаатай өч төнчөөн хүн Европын өнцөг булан бүрээс тусламж эрэлхийлэн түүнрүү тэмүүлж байжээ. Месмерийг ивээгчид түүний бүр Мюнхений академийн гишүүнээр сонгож амжжээ. Энэ даштамд хэлэхэд, соронзонгийн ид шидийг байдлаараа талархан дэмжигчдийн нөхөн би болон бусад эрдэмтэд биеэрээ мэдэрсэн билээ. Тухайлбал „шице дэвшилт чиглэлийг дэмжих“, „прээдүйн эмчилгээний үндсийг судлал“ гэх мэт э; мэлзэлтэй хүмүүс энэ талаар багагүй ярьдаг байсан бөгөөд тэдгээрийг өнөөгийн анагаах ухааны төлөөлөгчид бид хэдийгээр анагаах ухаанд олон зүйл тодорхойгүй байгаа ч гэсэн хүлээн зөвшөөрч чадаагүй юм.

Одоо соронзонт бугуйчны тухай бүр дурсахаа больжээ. Гэвч түүх давтагдааар байна. Нэг янзын төөрөгдлийн халааг нөгөө нь залган авч байна. Эмийн ургамал“, „ардын эмнэлэг“ гэдэг нэрийн дор элдэв хууран мэхлэгчид багагүй дөвчигнэх боллоо. Нөгөө талаар, анагаах ухаан төрөл бүрийн ургамал, өвснөөс ялгаж авсан олон янзын бодисыг эмчилгээнд өргөн хэрэглэдэг тухай бодит баримтыг санаатай буюу санаамсаргүйгээр бүрхэгдүүлэх хандлага их байна. Гэтэл бүх эмийн бэлдмэлийн 40 орчим хувийг ургамлын гаралт түүхий эдээр үйлдвэрлэж байна. Түүнчлэн ургамлын эмчилгээний чанарыг судлах үүрэг бүхий олон арван тэнхим, лаборатори хийгээд эмийн ургамал судлалын бүх холбоотын хүрээлэн манайд ажиллаж байна. Дээр дурдсан хэрэг явдал бас ёс суртахууны талтай хэлэх хэрэгтэй. Яагаад ч юм, эмийн ургамал буюу ардын эмнэлгийн нэр цуугаар алдар нэр олж авсан хүмүүсээс, миний л мэдсэн соанскоор бол нэг нь ч эрдэмт дэд хандаж: над нийм ер бусын өвслийн цуглуулга байна, та нар шинжкийн судалж үзээч, хэрэв үнэхээр сайн эм байх юм бол хүмүүсийн сайн сайхны тулд үйлчлэг гэх мэтээр хэлиг байсангүй.

„Мөнхөд залуужуулах, шингэн“, „хандмал“, „цугл/улга“, „рашаан“ гэх мэт янз бүрийн нэр томъёо бүхий зүйлүүдээ наймаа арилжааны өндөр үнэд хүргэжээ. „Огонёк“ сэтгүүлийн 1980 оны долдугаарт Сохи хотын оршин суугч С. Е. Чернышовын санаачилсан шинэ эм „Чипспсор“ хэмээх шидэти шингэнний тухай тэмдэглэл нийтлэгдсэн. Олон зуун хүн түүнээс тусламж эрэлхийлэх болж, тэр ч дуртай нь аргагүй тусалж байжээ. Энэ шидэти эм 120 рублийн үнэтэй нэгэн янзын булингартай шингэн л байсан гэнэ. Асуудлын гол нь энэ луйварчин өтгөөд өвчинд шаналсан олон хүнээс рублийг мянгаар нь авснаар зэгсохгүй, тэдний эрүүл мэндийг хохироосон байлаа. Бөөр орлогч аппарат залгахаар бэлтгэж байсан Светланаг бөөрний тасгаас авч гарахыг Чернышев билэнд ятгасан. Эмч нар ихээхэн дургүйцэж байсан ч гэсэн түүний хэлснээр бид охинoo гаргаж авсан юм. Үүний дараа Чернышов билэнд нэг жижгэвтэй шилтэй шингэнгүй хэрэглэх зааврын хамт өгч 100 рубль болон бэлэг сэлт авсан. Нөгөө шингэнийн бүтэй сарын турш охиндоо өгсөн боловч огт сайжирсангүй харин бие нь бур муудаж ирлээ. Аргаа барагд уйлан хайлан байж охинoo дахин эмнэлэгт хэвтүүлсэн боловч нэгэнт оройт-

сон байлаа.“ гэж арван есхэн настай охинь эхийн бичсэн захильтыг хэн ч тайван унших аргагүй биз. Хөвлэлд хэт хөөргөж бичсэн ид шидтэй шингэн нь үнэн чанартаа мацестын рашаан, дарсны спирт, түүхий шохой, хоолны давсны холимог байсан бөгөөд түүнийг архи нэрдэг аппаратаар нэрж хотой өвсний хандмалаар өнгийг нь хувиргажээ. Өөрпийгээ „ард олныг эмчлэгч“ (демопат) гэж нэрлэсэн өнэхүү залт тэтгээд шүүхээр шийтгэгдсэн юм.

Тийм тохиолдолд анагаах ухааны төлөөлөгчид болох биднийг ч зэмлэх нь зүйд нийцнэ гэнэ. „Ард олныг эмчлэгч“ домч нарын тухай мэдэх мөртөө биднийг амаа жимийсээр байна гэлцэнэ.

Тэр бүү хэл чи үхширсэн заншил дууриагч, ардын саруул мэргэн ухааныг үл тоомсорлон, „Ардын эмнэлгийн“ хөгжилд саад тогтор хийгч этгээд гэж буруушаахыг нь яана. Би ташаарч ч байж болох юм. Гэвч огт хэрэггүй болох нь хожим анагаах ухаан болон практикаар нотлогдсон эмчилгээний „шинэ аргуудын“ талаар сонинд ишаалт өгч өгүүлэл нийтэлж байсныг ердөө санахгүй байна.

Мөнөөхөн „оточ“ нар анагаах ухааны „цгаан толбыг“ ашиглан эмчилгээний уламжлалт бус арга гэдгээ шинжлэх ухааны үндэс суурьтай болгохыг оролдож байгаа нь намайг, бусад эрдэмтдийн адил онцгой түгшээн зовоодог юм. Харамсалтай нь өнөө хүртэл бид хүний бие махбодын нөөц боломжийг бүрэн мэдэхгүй байна.

Гэвч эрдэмтэй өөрсдийн хүч, мэдлэгийг дайчлан, уураг, тархины нууцыг тайлах, бие махбодын нарийн үйл ажиллагааны жамыг бүрэн илрүүлэхийг хичээж байтал, хүний биений цаглашгүй нөөц боломжийн тухай шинжлэх ухааны нээлтүүд болон олон үеийн туршид дамжин ирсэн „далдын“ хүчинд бишрэх явдлыг овжин ашиглагч хүмүүс бий болсоор л байна.

Месмер эмчилгээгээ хийж үед баян хуур хөгжмөөр тоглодог байсныг орчиж үеийн „шидэт“ бариачид дууриахгүй нь мэдээж хэрэг. Тэд өөрсдийн сонирхолд зохицуулан физик, биологи, философиийн шинжлэх ухааныг ашиглахыг оролдон, „Шинжлэх ухааны нээлээд өндөр түвшинд“ ажиллах болжээ. Үнэндээ тэд шинжлэх ухааныг ч биш, зөвхөн түүний нэр хүнд, шинжлэх ухааны төлөөлөгчийн нэр төрлиг л ашиглахыг эрмэлзэж байна. „Ер бусын бариачдын“ хувьд харамсалтай нь, тэдний биенд ямар нэгэн ер бусын цахилгаан гүйдэл байгааг орчлон өртөнцийн эрчим хүчиний маш өчүүхэл хэлбэлзлийг ч андахгүй мэдрэх чадалтай орчин үеийн нэг ч аргаар цлрүүлэгээгүй байна.

Тархи, зүрхний эсүүд өөрийн „гүйдэлтэй“, өөрийн цахилгаан чадавхитай байдаг нь аль хэдийнээ нэгэнт тогтоогдсон учир тэр үзүүний дахин нээхийн хэрэг юу байх билээ. Өнөөдөр бид эсийн цахилгаан чадавхийн хэмжээг тэднийгүй түүний үүсэх жамыг сайн мэддэг боллоо. Тархи, зүрхний цахилгаан бичлэг зэрэг оношлогооны сонгодог аргууд ч үүн дээр үндэслэгдэн бий болсон юм. Цаашидаа магад хүний бие махбодын, ялангуяа уураг тархины физик химийн цоо шинэ үзэгдлүүд нээгдэх болно. Гэтэл ер бусын бариачид, хорт хавдар, зүрхний шигдээс зэрэг олон төрлийн ноцтой өвчнийг өөрийн гарцаагаар эмчилж чадаж байгаа мэтээр өөрсдөө төдийгүй, зарим сэтгүүлцид, тэрч байтугайг эрдэмтэд батлах гэж оролдог нь шинжлэх ухаанд харш төдийгүй гэмт хэрэг үйлдээд дөхөж очиж байгаа явдал юм. Үүний уршгаар, элдэв тус горилсон засим өвчтөн өөрт нь хийж буй эмчилгээний аргын мөн чанарыг сайтар ухааралгүй эмчилгээгээ хаяж, улмаар юм мэдэхгүй мөртлөө хомхой санааны үү „эс „оточ“ болсон үл бүтэх хүмүүсийн урхинд орж хөрөнгө мөнгө төдийгүй, эрүүл мэнд, амь наасаа золносонд гаргах явдал байна.

Москвагийн нэг томоохон дээд сургуулийн захидал бөөрний нь ажиллагаа муудаж „хиймэл бээр“ гэдэг аппарат залгах эмчилгээ хийлгэж бийсныг би санаж байна. Тэгтэл түүнийг „шидэт бариач“ ятгаж айх юмгүй, эмчилгээний өвөрмөц аргаар бөөрний тань ажиллагааг сэргээж чадна гэж амлажээ. Үнд нь өвчтөн итгэж, „хиймэл бөөрний“ тусламжтайгаар хийлгэх ээлжит эмчилгээ ээ тасалсан байна. Шөнө нь өвчтөнийн авчрахад ухаан алдчихсан, юу ч хийгээд измэргүй болсон байв. Элдэв төрлийн „—оточ“ нар өвчтэй хүний хувь заяанд туйлын харлуулагагүй хайхрамжгүй хандаж, зүйрлэн хэлвээс, түүний амьдраалаар тоглож байдаг нь миний сэтгэлийг ямагт цооодог. Баяжихын их хүстээ, өөрийн үйл ажиллагааг „гоц зүйл“ гэж зарлан тухажгалах гэсэн зарим хүмүүсийн цадиггүй тэмүүлэх нь чиний өмнө хүн байна, чи түүний амь наасыг харнууцах бетсийг гэсэн амьд ухамсыг нь алж орхигдог бололтой. Зарим өвчтөний сэтгэл зүйн тал нь ч их хачирхалтай санагддаг. Мөнөөхөн „шидэт“ бариачийн эмчилгээ өөрт нь тус болохгүйгээр барахгүй хор болчихоор биднээс тусламж эрэлхийлж ирсэн хэн ч болов бариачдаа зэвүүцэлгүй байлаа. Тэд бариачид очсондо аль болохо яр мэлзэж нууна. Хэрэв тиймэрхүү байдал эмнэлгийн газарт гарсан бол бидний тухай хичнээж гашуун үг урсгах байсан бол ю!

Гэлээ ч гэсэн би өвчтэй хүмүүсийн хамгийн багаар буруутгах болно. Яагаад вэ гэзвэл, тэд аврал тус эрсэн хүмүүс. Харин аврал горилсон хүний итгэлийг хортойгоор ашиглана гэдэг бол хүний зовлон зүдгүүр, юм мэлхүүгийн байдлыг далимдуулан ашиг олох гэсэн ердийн ойлголтоор хязгаарлагдахгүй бөгөөд бүр хамгийн багаар бодоход туйлын ёс бусын хэрэг мөн.

Хилеры буюу гараараа цусгүй хагалгаа хийдэг хүмүүс „иүцгэн гараараа цус гаргахгүйгээр мэс заслын хагалгаа хийдэг гэгддэг хүмүүсийг филиппиннд хилерууд гэж нэрлэдэг байна“ гэж чухам хэн болоо талаар „Литературная газета“ сонины асуултанд ЗСБНХУ-ын ардын жүжигчин, алдарт илбэчин А. Акопяны өгсөн харин мийний сэтгэлд их нийцдэг юм. Дашигда хэлэхэд, сдоо шидэв барначдагч далдын, „уламжлалт бус“ эмнэлгийн алдар хүнд бий болж, ердийн эмч өмчилж, чадаахгүй өвчинийг л эмчилж чадна гэж цуурхаж байлаа.

Хилеруудийн тухай жуулчдын авсан кино зургийг сэтгүүлчид болон Москвагийн их сургуулийн багш, оюутнуулад узуулжээ. Гэтэл зарим үзэгчид хилеруудын тухай шинжлэх ухааны эрүүл саруул байр суурьнаас дүгнэж уг хэлсэн эмч, анагаах ухааны эрдэмтдийг „нөмрөгнийхөө нэр төрийг“ хамгаалахыг эрмэлзээн, хуучынг баримтлагсад гэж зэмслэн буруушаажээ. За тэгээд А. Акопян олон улсын уралдаанд нэг илбэчин үзэгчдийн нүдэн дээр туслагч хүүхнээ цахилгаан хөрөөгөөр хоёр таллан хуваахад „цус“ нь ниймдүүгаар эгнээ хүртэл үсэрч, дараа нь хоёр хэсгийн нийлүүлэхэд хүүхэн босоод явчихаж байсан тухай яриад хилеруудын ажиллагааг гэгч нь сайн илбэчин хийчих тийм л нэг илбэ юм гэж билээ. Харамсалтай нь хүн бүр А. Акопян шиг бодохгүй юм даа.

Гэвч энэ бол анагаах ухааны бас нэг сүл талыг харуулж байгаа юм. Ерөөсөө бидний хүчин мөхөсдэж, тодорхой үр дүнд хүрч чадахгүй юм уу хэн нэгэн эмчийн мэдлэг чадвар дутах, эсвэл цалгар назгай байдлаар, заримдаа эмч хүний өвчтөнд хандах зөв хандлага дутаснаас өвчтөн анагаах ухаанд итгэл алдаж, хомхой зальтай „оточ“ нарын гарг амархан орчиж болох тул бид тухай бүрд нь учрыг яв цав олж байх ёстой.

Иймд яз бүрийн эмч, домч, хууран мөхлэгчидтэй тэмцэх хамгийн сайн хэрэгсэл бол анагаах ухааны ололт амжилт мөн. Мэдээж зүрхний шигдээс өвчиний хурц үед юм уу уушгини Үрэвсэлтэй өвчтөн юуны өмнө барнаачид очих болов уу даа. Ийм тохиолдолд зөвхөн эмч ба эм тус болно гэдгийн бүгд мэднэ.

Анагаах ухаан гэдэг бол зөвхөн зааврын дагуу сохроор ажиллаж бодогч гүйгээрээ бусдаас ялгаатай. Тийм шинжлэх ухаан, тийм мэргэжил юм. Харин техникт бол хялбар бөгөөд инженер хүн шинжлэх ухаанаар боловсруулсан технологийн загвар, зааврыг яг баримтлан ажилласнаар онцгой үр дүнд хүрч чадна. Гэвч анагаах ухаанд ийм боломжгүй бөгөөд яагаад вэ? гэвэл, түүний үндсэн зарчим нь өвчин биш өвчтэй хүнээс шалтгаалдагт оршино. Хэрвээ өнөөдөр анагаах ухаанд өвчин авсан мянга орчим, өвчилсний шинж тэмдгүүд зүүн мянга орчим мэдэгдээд байгааг тооцоолоод үзвэл нэг өвчиний үе дэх эмчилгээний нарийн загварыг олон зуу, мянган хувилбараар боловсруулчих ямар ч боломжгүй билээ. Энд гагтын анагаах уханы бүх ололтыг ашиглаж чадах, тэхдээ бүр тодорхой нэгэн өвчтөнд тааруулан хэрэглэж чадах эмч хүний мэргэжлийн үр чадвар илрэч байх учиртай. Ийм учраас тусгай программаар хөдөлдөг хиймэл хүн-аппарат лутгаа адил зөвхөн заавраар ажил хийдэг дуурин тоглогч болсон эмчээс плүү аймшигтай юм анагаах ухааны хувьд, өвчтэй хүний хувьд байхгүй билээ.

Анагаах ухаан бол ер бусын мэргэжил бөгөөд эмчид хүн өөрийн хамгийн үнэтэй, наандин зүйл болох амь нас, эрүүл мэндээ даатгадаг билээ. Энд зөвхөн өвчтөн төдийгүй түүний ойр дотныхны хувь заяаны асуудал хамарагдах нь олонтоо байдаг. Өвчтөн өөрийнхөө хувь заяаг даатгасан тэр хүндээ л итгэж найдах ёстой. Харин таны зовлон шаналгаанд хайнга хандаж, таны өвчиний учир зүйг олох талаар ямар ч арга хэмжээ авахгүй байгаа, таны дургүйцлийг хүргэсэн эмчид та хувь заяагаа даатгах уу даа.

Хэрэв энэ асуудал өөрөөс тань шалтгаалах бол тийм эмчид очихгүй байхыг эрхэмлэх нь зөв. Мэдлэгийн хажуугаар эмч хүнд зохих зан араншин, авьяас дүй чухам юм. Хэрэв анагаах ухааныг эхнээсээ өцсөстээ хүртэл зөвхөн загвар, заавраар хийх ажил гэж үздэг эмчтэй хувь тайллан тань учруулж, таны зовлон шаналгаа тэр эмчийн хувьд ямар ч падгүй байх юм бол мэдээжээр та анагаах ухаанд итгэл алдаж, улмаар эмчтэйгээ түр тар хийх болно.

Тодорхой бус шалтгаанаар өвчтэй хүн физикчдийн гарг орох өдөр ирж болох юм. Физикчид өвчтөнөөс юуны ч тухай асуухгүйгээр шууд цус авч, ямар нэг тогтмол хэмжигдхүүнүүд гаргаж, нэгийг нь нөгөөгөөр үржүүлж, дараа нь логарифмын таблиццайт харьцуулж үзээд цорын ганц үрэл өгч эмчлэх болно. Гэлээ ч гэсэн хэрэв би өвдөх юм бол нүүргийн настай хашир ямар нэгэн эмчид л очих болно. Тэрээр нүднийхээ булангаар намайг ажиглаж, гэдснийг минь дарж үзэж, нусны хуучивтар алчуураа далан тушаад минь тавьж чагнаж үзэх болно. Тэгээд матигар гаансаа зууж ханиалган байж эрүүгээ арчих зуураа надруу дөлгөөнөөр мишээн харахад нь өвчин минь намдаад ирэх шиг болно... Мэдээж хэрэг, би цинжлэх ухааныг шагшин магтана. Цээнэ мэргэн ухааныг ч бас баахархана“ гэж А. Сент-Экзюпери, эмчийн тухай гайхамшигтай сайхнаар дурслэн хэлснийг онцлон тэмдэглэхийг хүсч байна.

„Медицинская газета“ сонины 1984 оны хорин дөрөвдүгээрээс Б. Оргил орчуулав.

ЭРҮҮЛИЙГ ХАМГААЛАХЫН ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

Ц. СОДНОМПИЛ

ТООЦООЛОН БОДОХ ТЕХНИК МАТЕМАТИК АРГЫГ ХЭРЭГЛЭХ НЬ ЭРҮҮЛИЙГ ХАМГААЛАХЫН УДИРДЛАГЫГ БОЛОВСРОНГУЙ БОЛГОХ ХҮЧИН ЗҮЙЛ МӨН

АСПИРИНТ

Орчин үед удирдлага гэдэг нь нийгэм, эдийн засаг, хууль эрх, сэтгэл зүй, техник технологийн болон бусад асуудлуудыг багтаасан олон талтай, иж бүрэн ойлголт юм.

Иймээс удирдлагад тооцоолон бодох электрон машин (ТБЭМ), эдийн засаг-математикийн болон загварчлалын аргыг өргөн хэрэглэх техник-зохион байгуулалтын дорвitoй арга хэмжээ авч хэрэгжүүлэх, эдийн засгийн төрөл бүрийн хөшүүргийг чадамгай ашиглах явдал шаардлагатай болжээ.

Тус оронд социализмын материал техникийн баазыг амжилттай байгуулж, улс ардын аж ахуйн төрөл бүрийн салбар эрчимтэй хөгжиж байгаа өнөөгийн нөхцөлд эрүүлийг хамгаалахын удирдлагын системийг боловсронгуй олгох асуудал нэн чухал байна.

ЗХУ болон бусад орны эрдэмтдийн (В. В. Венедиктов 1982; П. И. Калью 1975; В. И. Кант 1982; Е. Н. Шиган 1982; В. М. Тимошин 1978; 1983; Г. Гаргов 1983 гэх мэт) үзэж байгаагаар орчин үед шинжлэх ухаан-техникийн дэвшил болон үйлдвэржилт, материаллаг боллоод соёлын амьдрал төвлөрөх процесс эрчимтэй хөгжиж, үүнтэй хамт өндөр нарийн мэргэжлийн тусlamж үзүүлэх эмнэлэг-урьдчилан сэргийлэх байгууллагуудын тоо үлмж өсч байгаа нь хүн амд үзүүлэх эмнэлгийн тусlamж, түүний материаллаг баазыг бэхжүүлэхэд чухал ач холбогдолтой хүчин зүйл болохын зэрэгцээ эрүүлийг хамгаалах байгууллагуудын өмнө шинэ шинэ зорилтууд урган гарч, тэдгээр зорилтыг амжилттай шийдвэрлэхэд орчин үеийн тооцоолон бодох техник, эдийн засаг-математикийн аргыг өргөн хэрэглэх явдал зайлшгүй шаардлагатай болжээ. Тооцоолон бодох электрон машиныг (ТБЭМ) ашиглах, хөгжүүлэх асуудал Кибернетикийн шинжлэх ухааны хөгжилтэй салшгүй холбоотой юм.

ЗХУ-ын эрдэмтэн А. И. Бергийн (1972) тодорхойлсноор кибернетик гэдэг нь тодорхой зорилготой, зөв удирдах (юуны өмнө нарийн зохион байгуулалтай, динамик системийн) тухай шинжлэх ухаан юм.

Кибернетикийн шинжлэх ухааны тусlamжтайгаар судалдаг тэрхүү системүүдэд дараах ерөнхий зүй тогтол зайлшгүй байх ёстой. Үүнд:


1. Юуны өмнө судалж буй процессын тухай анхны баримт сэлттэй байх бөгөөд түүнийг хамгийн ерөнхий байдлаар томъёолон „мэдээлэл“ гэж нэрлэдэг байна. Ямар нэгэн системийг удирдахад мэдээлэл зайлшгүй чухал. Ийнхүү мэдээлэл гэдэг бол кибернетикийн шинжлэх ухааны хамгийн чухал, үндсэн гол ойлголтуудын нэг юм.

2. Удирдлагын ямар ч шатанд мэдээллийг хүлээж авч, дамжуулах, хадгалах, боловсруулах асуудал зайлшгүй байна. Кибернетикийн системийн үйл ажиллагааны үндэс нь дараах элементүүдийн харилцан үйлчлэл юм. Үүнд:

Зорилго бз программ, удирдах систем ба удирдлагын объект, тэдгээрийн динамик холбоо (шууд ба урвуу) эдгээр болно. Бид даацах зургаар кибернетикийн системийн хамгийн түгээмэл бүдүүвчийг харууллаа.

Зураг—1

Кибернетикийн системийн хамгийн түгээмэл бүдүүвч



Үнээс үзэхэд тус орны эрүүлийг хамгаалахын удирдах систем нь кибернетикийн нийтлэг систем мөн. Кибернетикийн шинжлэх ухаан төрөл бүрийн системийг судлахдаа мэдээллийн онол, өндөр хүчин чадалтай тооцоолон бодох электрон машины онол, өөрийгөө зохицуулах онол (теория саморегуляций)-уудад тулгуурлаж иржээ.

Аливаа системийг кибернетикийн шинжлэх ухааны үүднээс судлахаа гэдэг нь эцсийн эцэст уг системийн үйл ажиллагааг хамгийн зохистой удирдаж, зохион байгуулна гэсэн уг юм. Кибернетикийн шинжлэх ухаан нь мэдээллийг боловсруулахдаа математик аргуудыг өргөн ашиглаад бөгөөд түүний үр дүнд өндөр хүчин чадалтай тооцоолон бодох электрон машины тусламжтайгаар уг мэдээллийг боловсруулах ажлыг автоматаа боломжтой болдог байна.

Орчин үед эрүүлийг хамгаалахын удирдлагад математик аргыг өргөн ашиглах байна. Математик арга гэдэг нь аливаа юмс үзэгдлийг судлахад математикийн төрөл бүрийн тэгшитгэлийн тусламжтайгаар уг юмс үзэгдлийн мөн чанарыг загварлан томьёолохыг хэлдэг байна.

Ер нь Эрүүлийг хамгаалахын зохион байгуулалт удирдлага төлөвлөлтөд хэрэглэгдэж байгаа математик аргуудыг дотор нь:

1. Зохистой төлөвлөлтийн аргууд
2. Үзэгдэл юмсын үнэн магадтайг онолын талаас нотлох аргууд гэж ангилдаг байна.

—Зохистой төлөвлөлтийн аргуудад шугаман болон динамик программаачлалын аргууд ордог байна.

—Үнэн магадтай нотлох аргуудад төрөл бүрийн математик загварчлалын аргууд (ижилтгэн загварчлал, статистик туршилт, ажилбар судлал гэх мэт) ордог байна. Эдгээр аргыг эрүүлийг хамгаалахын практикт өргөн нэвтрүүлэхэд математикийн мэргэжлийн боловсон хүчний туслалцаа зайлшгүй шаардлагатай бөгөөд эрүүлийг хамгаалахын зохион байгуулагч, математикч нар хамтран ажилласнаар амжилттай хэрэглэх боломжтой юм.

Ийнхүү эрүүлийг хамгаалахын удирдах системийг боловсронгуй болгох хамгийн шинэ, гол үндсэн хандлага бол өндөр хүчин чадалтай математик аппарат бүхий ТБЭМ хэрэглэх, удирдах системийн мэдээллийн хангамжийг сайжруулах асуудал бөгөөд эдгээрийн үндсэн дээр удирдлагын автомат систем (УАС) боловсруулах явдал мөн. Гэвч УАС байгуулах гэдэг нь маш нарийн, үлэмж нусэр ажил юм. Иймээс УАС байгуулах ажлыг юуны өмнө одоо хэрэглэгдэж байгаа удирдлагын арга мэдээллийн байдал, удирдлагын системийг шинжлэх

ухааны үндэслэлтэй судлах ажлаас эхлэх нь зүйтэй юм. Мөн уг системд хүнд хүчир ажлыг механикжуулах талаар ямар таахиц олсон зэрэгийг системийн онолын үүднээс нарийн судалсан байх шаардлагатай юм. Энэ талаар зөвлөлтийн эрдэмтэн О. В. Козлова, С. А. Ленская (1971) нар удирдлагыг механикжуулах, автоматжуулах асуудлыг Зшаттайгаар боловсруулсан нь манай нөхцөлд тохируулан судалж хэргэлүүштэй юм. Энэхүү зарчим нь:

1. Эхний шат-бүртгэх, тооцох ажлыг төрөл бүрийн жижиг тооны машиныг ашиглах замаар хэсэгчлэн механикжуулах,

Энэ шат нь мэдээллийг шуурхай боловсруулах ажлыг цаашид боловсронгуй болгоход чухал үүрэг гүйцэтгэдэг байна.

2. 2 дахь шат-удирдлагыг нэлээд өргөн хэмжээгээр механикжуулах. Энэ шатанд бүртгэлийн ажлыг механикжуулахын зэрэгцээ норматив-төлэвлөлтийн асуудлыг хэсэгчлэн механикжуулж, энэ ажилд тоо-дох-шивэх машиныг ашиглахаас гадна ТБЭМ ашигладаг байна. Энэ шат нь цаашид удирдлагын техникийн баазыг боловсронгуй болгох үндсийг тавьдаг байна.

Эдгээр хоёр шат нь манай орны эрүүлийг хамгаалахын удирдлагын практикт ямар нэгэн хэмжээгээр нэвтэрч байгаа гэж үзэж болох юм.

3. 3 дахь шат-удирдлагыг иж бүрэн механикжуулах ажлыг автоматчилахтай хослуулах ба удирдлагын автомат систем (УАС) байгуулах зэрэг болно.

ЗХУ-болон социалист бусад орнуудад одоо энэхүү 3 дахь шатны асуудлыг амжилттай цийдвэрлэж байна. Жны; ЗХУ-ын эрүүлийг хамгаалах яаманд „Медстат“-Эрүүлийг хамгаалахын статистик үзүүлэлт тайлангийн удирдлагын автомат системд (УАС) оруулсан, „Сан эпид“ ариун цэвэр, халдварт судлалын асуудлыг шийдвэрлэх УАС-д „ГАПУ“ Эм хангамж, түүний хуваарилалт, зарцуулалт нөөцийн асуудлыг зохицуулах УАС „Планфин“-төлөвлөгөө-санхүүгийн талаархи УАС „Кадр“-боловсон хүчний талаархи УАС, „АСКИД“-тогтоол шийдвэрийн биелэлтэнд хяналт тавих УАС зэргийг амжилттай нэвтрүүлж байна.

Удирдлагын автомат систем гэдэг нь удирдлагын үйл ажиллагааг хамгийн үр дүнтэй гүйцэтгэх нөхцөлийг хангаж байгаа техник хэрэгсэл ба онол арга зүйн нийлбэр цогц юм. Дээр өгүүлсэн онол, арга зүйн зарим асуудлууд болон тус орны эрүүлийг хамгаалахын удирдах систем, түүний мэдээллийн хангамжийн байдлыг судалсаны үндсэн дээр орчин үеийн тооцоолон бодох машин, математик аргыг хэрэглэж, эрүүлийг хамгаалахын удирдлагын боловсронгуй болгоход зохион байгуулалтын дараах зарчмуудыг баримталж болох юм гэж бид санал болгож байна. Үүнд:

1. Эрүүлийг хамгаалахын бүх алба, байгууллагуудын удирдлагын үйл ажиллагааг нэгэн зэрэг автоматацах шаардлагагүй бөгөөд (тийм боломжгүй юм) эхлээд хамгийн чухал шаардлагатай, тэгэхдээ удирдлагын автомат систем нэвтрүүлэхэд хөрөнгө хүч болон техникийн талаар нэмэлт арга хэмжээ төдийлөн шаардахгүй тийм салбарыг сонгох хэрэгтэй юм.

Тухайлбал Эрүүлийг хамгаалах яаманд гүйцэтгэлийн хяналт шалгалтыг сайжруулах, хүмүүсийн хариуцлагыг дээшлүүлэх, гаргаж байгаа шийдвэрийг боловсронгуй болгох зорилгоор хяналт шалгалтын автомат систем нэвтрүүлж болох юм. ЗХУ-ын туршлагаас үзэхэд энэ системийг нэвтрүүлэхэд зохион байгуулалт, техникийн баазын талаар нэмэлт арга хэмжээ төдийлөн шаардахгүйгээр одоо гүйцэтгэж байгаа хяналтын системийг төгс боловсронгуй болгохын зэрэгцээ удирдлагын үйл ажиллагааг хөнгөн шуурхай болгох үр дүнтэй нь нотлогджээ.

2. Автоматчиллыг эрүүлийг хамгаалахын удирдах төв байгууллагад (Эрүүлийг хамгаалах яамны түвшинд) орон нутгийн байгууллагууд

Саймаг, хотын эрүүлийг хамгаалах газрын түвшинд) нэвтрүүлэх дараалын асуудлыг өөрийн орны эрүүлийг хамгаалахын болон орон нутгийн онцлогийг сайтар судалж, холбогдох байг ууллагуудтай тохиролцсоны үндсэн дээр шийдвэрлэх.

3. Автоматчиллыг заавал ТБЭМ-тай болсон нөхцөлд нэвтрүүлнэ гэхгүйгээр эрүүлийг хамгаалахын тулгамдсан зорилтыг шийдвэрлэх үндсэн дээр бусад байгууллагуудын ТБЭМ-ийг хамтарч ашиглах зарчмыг баримтлах. Жны: Эрүүлийг хамгаалах УАС-ийг нэвтрүүлэхэд статистикийн тэв газар, Улсын төлөвлөгөөний комисс, ус цаг уурыг удирдах газар зэрэг ТБЭЛЛ-тай байгууллагуудтай гэрээ хийх журмаар хамтарч ашиглаж болох юм.

4. Автоматчиллыг эрүүлийг хамгаалахад нэвтрүүлэхдээ улс ардын аж ахуйн бусад салбар, социалист бусад орнуудад УАС-ийг нэвтрүүлж байгаа арга туршлагыг судалж, өөрийн орны нөхцөлд хэрэгжүүлэх.

5. УАС-ийг нэвтрүүлж байгаа эхний үед инженер-техникийн боловсон хүчин, мэргэжлийн байгууллагуудын туслаалцааг дээд зэргээр ашиглахын зэрэгцээ өөрийн боловсон хүчинийг идэвхтэй бэлтгэж эрүүлийг хамгаалахын ажилтнуудыг тооцоолон бодох техникийн үндсийг эзэмшиүүлэх ажлыг шуурхай зохион байгуулах. Эдгээр зарчмыг бид хараахан төгс боловсруулахад үндэс болох болов уу гэж үзэж байна. Бид цаашид энэ зарчмыг улам боловсронгуй болгох зорилт тавьж байна.

М. СҮХБААТАР, Н. А. АКСЕНОВ

ХҮҮХДИЙН УУШГИНЫ ЦОЧМОГ ҮРЭВСЛИЙН ҮЕИЙН ЦУСНЫ РЕОЛОГ ЧАНАРЫН ӨӨРЧЛӨЛТ

ЛЕНИНГРАД ХОТЫН ХӨДӨЛМӨРИЙН ГАВЬЯАНЫ УЛААН ТУГИЙН
ОДОНТ ХҮҮХДИЙН АНАГААХ УХААНЫ ДЭЭД СУРГУУЛЬ

Уушги нь цус бүлэгнэхэд оролцох хүчин, мөн түүний эсрэг хүчин, бүлэн задлах бодисоор баялаг (3,4,10,11) төдийгүй гепарин нөөцлөгдхөх, (12) серотонин, адреналин, норадреналин, гистамин зэрэг биологийн идэвхт бодисуудын хэмжээг тохируулах (7) гол үүрэгтэй.

Уушгины цочмог үрэвслийн үед хялгасан судас тэлж өргөсөх, түүний нэвчилт ихсэх (13), цусны урсгал удааширч стаз болох зэрэг өөрчлөлт нь зүрхний ачааллыг ихэсгэдэг. Мөн периспирац замаар халуурах, амьсгдаах зэрэг шингэн алдсанаас цус өтгөрнө.

Цусан дахь хүчилтөрөгчийн хэмжээ буурч, нүүрсхүчлийн хэмжээ ихэссэн (8), хүчил шүлтийн тэнцвэрт байдал, ус эрдсийн солилцоо өөрчлөгдхөх нь (10) цусны реолог чанар, бичил эргэлтэнд нөлөөлдөг (5,18).

А. С. Еремеева, И. А. Чернявская (1978), Н. Д. Ширяев, Л. С. Ходасевич (1978) нар, уушгины цочмог үрэвслийн хүндэрч нас барсан хүүхдүүдэд эмнэлзүй-эмгэгбүтцийн харьцуулсан судалгаа хийхэд (14) судсанд бүлэгнэлт ихсэх, бүлэн үүсэх, цусархаг хам шинж гарах, реологийн өөрчлөлт нь ихэвчлэн далд байгааг анхаарч цаашид гүнзгийрүүлэн судлах хэрэгтэйг тэмдэглэжээ.

Уушгины цочмог үрэвслийн үед уургийн харьцаа алдагдан альбумин багасч, глобулин (5), фибриноген (6) зэрэг том молекулт уураг ихсэх нь цусны реолог чанар, бичил эргэлтэнд нөлөөлөх нэг шалтгаан болно. Түүнчлэн захын цусанд ялтсан эсийн тоо багасах, түүний адгез, агрегац чанар өөрчлөгдхөх нь бичил эргэлт болон цус бүлэгнэхэд чухал ач холбогдолтой (9,16) юм.

Бид цусны реолог чанарыг судлах зорилгоор уушгины цочмог үрэвсэлтэй 45 хүүхдэд динамик ажиглалт хийллэ. Бүх өвчтөний 28 нь голомтот болон сегментийн гуурс уушгины, 17 нь уушги гялтангийн үрэвсэлтэй байсныг нас хүйсээр нь ангилбал ой хүртэлх 7, 1—3 настай 14, 4—7 настай 11, 7-оос дээш настай 13, эрэгтэй 27, эмэгтэй 18 байв.

Өвчтөний онош, зовиур зэрэг нь бодит үзлэг, туслах шинжилгээгээр батлагдсан. Шинжилгээг хэвтэх үед (1—2 хоногт), явц дунд (10—14 хоногт) болон эдгэрэх үед хийсэн.

Бүх өвчтөнд цус, биохимийн үзүүлэлтээс (нийт уураг, уургийн бүлэг, С—реактив уураг, сиаловын хүчил, В—липопротеин) гадна цусны фибриногеныг Р. А. Рутбергийн (1966) аргаар, захын цусанд ялтсан эсийн тоог Брехерийн аргыг засварласан Г. А. Одессовагийн (1971) аргаар Фазова-контрастны микроскоп дээр тодорхойлсон. Өвчтөнд динамикт нь электрокоагулограмм хийж гарсан үзүүлэлтүүдийг хэвийн үзүүлэлттэй (2, 5, 15) харьцуулав.

Үүшгүүны цочмэгт үрэвсэлтэй хүүхдийн биохимийн үзүүлэлт

Xүснэгт I

| Үзүүлэлтүүд | Хэвлэвийн Уед $M_0 \pm m_0$ | Хэвлэх Уед $M_1 \pm m_1$ | P_{0-1} | Явц дунд $M_2 \pm m_2$ | Гарах Уед $M_3 \pm m_3$ |
|-----------------------------------|--------------------------------|-----------------------------|-----------|---------------------------|----------------------------|
| Ажиглалтанд авсан хүүхдийн тоо=II | | 45 | | 45 | 45 |
| Нийт уураг (г/л) | 70,4±3,8 | 67,73±0,82 | | 70,63±0,91 | 71,0±0,85 |
| Альбумин | 50,0±2,15 | 43,10±0,83 | <0,2 | 47,15±0,54 | 49,11±0,44 |
| Альфа-1 глобулин | 6,0±1,15 | 8,17±0,22 | <0,7 | 7,11±0,19 | 6,42±0,14 |
| Альфа-2 глобулин | 12,1±1,4 | 17,02±0,42 | <0,5 | 14,75±0,46 | 13,29±0,29 |
| Бета-глобулин | 13,0±1,6 | 13,14±0,18 | | 13,10±0,23 | 13,02±0,26 |
| Гамма-глобулин | 19,0±1,4 | 18,52±0,48 | | 18,00±0,52 | 18,26±0,43 |
| C-реактив уураг(мм) | 1,0 | 2,05±0,12 | <0,01 | 1,52±0,09 | 1,35±0,04 |
| Сиалозын хүчил (ед) | 20,0±2,1 | 35,30±1,06 | <0,001 | 26,91±0,62 | 23,55±0,46 |
| B-липпротеин (ед) | 30—40 | 57,80±1,36 | <0,001 | 46,30±1,27 | 38,61±1,28 |

Үүшиг, галтганийн цочмог үрэсэлтэй хувхийн биохимиин үзүүлэлт

Хүснэгт 2

| Үзүүлэлтүүд | Хэвийн Үед $M_0 \pm m_0$ | Хэвтэх Үед $M_1 \pm m_1$ | P_{0-1} | Явч дунд $M_2 \pm m_2$ | Гарах Үед $M_3 \pm m_3$ |
|----------------------|-----------------------------|-----------------------------|-----------|---------------------------|----------------------------|
| Өвчтөний тоо=II | | 17 | | 17 | 17 |
| Нийт уураг (г/л) | 70,4±3,8 | 64,70±1,09 | | 69,62±0,66 | 71,90±0,43 |
| Альбумин (%) | 50,0±2,15 | 38,1±1,14 | <0,001 | 42,79±1,18 | 46,82±0,43 |
| альфа-1 глобулин | 6,0±1,15 | 9,40±0,39 | <0,5 | 7,31±0,28 | 6,84±0,09 |
| альфа-2 глобулин | 12,1±4,4 | 19,35±0,54 | <0,001 | 15,00±0,69 | 13,69±0,21 |
| Бета-глобулин | 13,0±1,6 | 13,42±0,28 | | 13,22±0,25 | 13,32±0,15 |
| Гамма-глобулин | 19,0±1,4 | 19,64±1,09 | | 18,76±0,67 | 19,04±0,36 |
| C-реактив уураг (мм) | 1,0 | 2,64±0,19 | <0,001 | 1,6±0,13 | 1,6±0,04 |
| Сиаловын хүчин (ед) | 20,0±2,1 | 37,1±2,43 | <0,001 | 26,5±0,76 | 24,5±0,50 |
| B-липопротеин (ед) | 30—40 | 62,76±3,71 | <0,001 | 48,00±1,14 | 41,85±1,69 |

Хүснэгт 1-ээс харахад уушгины цочмог үрэвсэлтэй хүүхдэд хэвтэх үед альбумин багасч ($P<0,2$), альфа—1 ($P<0,7$), альфа—2 глобулин ($P<0,5$), С—реактив уураг ($P<0,01$), сиаловын хүчил, В—липопротеин ($P<0,001$) ихсэж байна.

Биохимийн өөрчлөлт нь өвчний хэлбэр, өвчтөний хүнд, хөнгөнөөс шууд хамаарч байв. Ялангуяа хэвтэх үед биеийн байдал хүнд байсан уушги гялтангийн үрэвсэлтэй 17 өвчтөнд енэ хэлбийлт тодорхой илэрч байнсныг хүснэгт 2-т харуулав.

Хүснэгт 2-оос үзэхэд биохимийн үзүүлэлтээс альбумин багасч ($P<0,001$), альфа—1 ($P<0,5$), альфа—2 глобулин, С реактив уураг, сиаловын хүчил, В—липопротеин ($P<0,001$) тод, тогтвортой ихсэж байна.

Уушгины цочмог үрэвсэлтэй өвчтөний цусанд фибриноген ихсэж ($P<0,1$), захын цусанд ялтсан эсийн тоо багасаж ($P<0,001$), электрокоагулограммд T_1 , T_2 , Т үзүүлэлт богинооч ($P<0,01$), $T_{\text{рф}}$ ($P<0,001$) уртсаж байв.

Өвчтөний цусны шинжилгээнд цагаан цогцос 31,4% ихсэж, цагаан цогцсын томъёоны хэлбийлт зүүн тийшээ (42,5%, улаан цогцсын тунах хурд 89%) ихссэн байна.

Дүгнэлт: 1. Уушгины цочмог үрэвслийн үед биохимийн үзүүлэлтээс альбумин багасах, альфа—1, альфа—2 глобулин, С—реактив уураг, сиаловын хүчил, В—липопротеин ихсэх нь өвчний хэлбэр, өвчтөний хүнд хөнгөнөөс хамаарч эрт илрэх өөрчлөлтийн нэг юм.

2. Эдгээр өөрчлөлтөөс гадна цусанд фибриноген ихсэж, захын цусанд ялтсан эсийн тоо цөөрөх, электрокоагулограммд T_1 , T_2 , Т үзүүлэлт богиносох, $T_{\text{рф}}$ уртсах нь цусны бичил эргэлтийн хямрал цус бүлэгнэлтийн ихсэлтийг харуулах гол үзүүлэлт юм.

АШИГЛАСАН ХЭВЛЭЛ

1. Актуальные вопросы бронхолегочной патологии у взрослых и детей. Чита, 1978.
2. Н. А. Алексеев, Н. А. Аксечев и др. Функциональная активность тромбоцитов у здоровых детей. ВОМД, 1975, 6, 12—16.
3. Г. В. Андреенко Фибринолиз (биохимия, физиология, патология) М. Медицина, 1979.
4. В. П. Балуда и др. Лабораторные методы исследования системы гемостаза. Томск, 1980.
5. Г. М. Воронка, и др. Изменение реологических свойств крови при пневмонии. В кн: О пневмониях у детей раннего возраста. Кишинев, 1976.
6. В. В. Гецеул Изменение свертывания крови при острых бронхолегочных заболеваниях у детей раннего возраста. Пед, 1981, 11, 59—60.
7. О. А. Гомазков и др. Механизмы повреждения, резистентности, адаптации и компенсации. Ташкент, 1979, ч. 1.
8. Диагностика нарушений микроциркуляторного кровообращения и методы их коррекции у больных с заболеваниями легких. Метод. рекомендац, 1982.
9. А. П. Зильбер Клиническая физиология в анестезиологии и реаниматологии. М. 1984.
10. А. П. Зильбер Клиническая физиология для анестезиолога. М. 1976.
11. Д. М. Зубайров Биохимия свертывания крови. М. 1978.
12. В. П. Казначеев, А. А. Дзизинский Физиология и патология транспилярного обмена. М., 1975.
13. М. Б. Коган Сердечно-сосудистые расстройства при острой пневмонии у детей и их патогенетическая терапия. Док. дисс. 1980.
14. В. И. Лысенко Гемокоагуляционные нарушения и методы их коррекции. Автореферат на соиск. канд. мед. наук, Харьков, 1981.
15. В. А. Макович. Некоторые показатели свертывающей и антисвертывающей системы крови острых пневмониях у детей раннего возраста. Челябинск. 1973.
16. А. В. Папаян, Н. П. Шабалов Геморрагические диатезы у детей. Л, 1982.
17. Современные методы диагностики, лечения и профилактики острых и хронических неспецифических заболеваний легких. Всеросс. науч. практическ. конф. Красноярск, 1979.
18. А. М. Чернух и др. Микроциркуляция. М, 1975.

РЕОЛОГИЧЕСКИЕ СВОЙСТВА КРОВИ ПРИ ОСТРОЙ ПНЕВМОНИИ У ДЕТЕЙ

М. Сухэ-Батор, Н. А. Аксенов

В динамике у 45 детей больных острой пневмонией (у 25 вирусной и вирусно-бактериальной и у 20 бактериальной этиологии) в возрасте от 3 месяцев до 14 лет проводились биохимические исследования и изучение некоторых показателей гемокоагуляции. Исследования проводились при поступлении (1—2 день), в динамике (10—14 день), и перед выпиской (реконвалесценция).

В результате исследований отмечалось, что при любых формах пневмонии имеются явления диспротеинемии, приводящие к относительному увеличению содержания в плазме макромолекулярных белков и относительному уменьшению содержания альбуминов на фоне нормальных и субнормальных цифр общего белка. Так же увеличивается содержание (статистическая достоверность $P<0,001$) С реактивных белков, сиаловых кислот и В-липопротеинов.

Выявлена прямая зависимость сдвига биохимических показателей от формы и степени тяжести пневмонии, особенно при плевропневмонии.

Кроме того исследования показали, что в остром периоде, особенно при плевропневмонии, уровень фибриногена ($P<0,01$) повышается, а количество тромбоцитов снижается ($P<0,001$). При электроагулографических исследованиях обнаружены увеличение коагулирующей (показатели T_1 , T_2 , T , ускорены, $P<0,001$) способности крови и депрессия фибринолиза (показатель T_{RF} , $P<0,001$).

Н. МОНХТУВШИН

ГУУРСАН ХООЛОЙН БАГТРАА ИММУНЫ ӨВЧИН

АНАГААХ УХААНЫ ДЭЭД СҮРГҮУЛЬ

Гуурсан хоолойн багтраа (ГХБ) өвчин хангалттай судлагдсан гэх болдовч энэ өвчиний шалтгаан, эмгэг жасам, илрэх шинж тэмдгийг бүрэн тусгасан нэгэн мөр тодорхойлолт онөө хэр алга байна.

Энэ өвчиний мөн чанар бол уушгины амьсгалын жижиг гуурсууд нарийсдаг явдал юм. Харин чухамхуу яагаад ингэж нарийсдагийг бид одоо болтол бүрэн тайлбарлаж чадаагүй байгаа юм.

Дархал судлаачид гуурсан хоолойн багтрааг иммуны өвчин, тухайлбал, харшилын огцом хэлбэрийн улмаас шигүү мөхлөгт эсийн (ШМЭ) ялгаруулсан гистамин мэтийн биошэвхт бодисууд (медиаторууд) амьсгалын гуурсыг нарийгагадаг гэж нотлоодог, (6,11)

Эмгэг физиологичд вегетативын мэдрэлийн системийн тэнэмэл мэдрүүл, холинд мэдрэг (холинэрг) хүлээн авуурыг тогтолцоож амьсгалын гуурсын гилгэр булчинг байнгын агшилтанд оруулнаас болдог гэж үздэг.

1948 онд Оолквист (7), гуурсын гилгэр булчингийн мембрان дээр а ба β адрен мэдрэг (адренэрг) хүлээн авуур нээсний дараахан Шентивани (12) энэхүү β-адренэрг хүлээн авуурын тогтолцоонд хориг үүсэх нь гуурсан хоолойн багтраа үүсэх нөхцөл мөн гэсэн онолыг дэвшүүлжээ.

Гуурсан хоолойн багтрааны шалтгаан олон янз бөгөөд амьсгалын замын халдварт өвчинүүд, ургамлын тоос, амьтны гаралттай бүтээгдэхүүн, эмийн бодис, нийлэг эдлэл, хоол хүнсний зүйл, энгэсэг үнэртэн. Үсний будаг мэт харшил төрүүлэх чанар нь нотлогдсон шалтгаанаас үүсэж байна гэж үзэхээс гадна нар, салхи, хүйтэн агаар, биеийн хүчиний хөдөлмөр, химиин бодис, үйлдвэрийн утаа, сэтгэл санаан хямрах, заримдаа уурлааж уцаарлахад хүртэл өөрөөр хэлбэл ердийн физик, хими, сэтгэл санааны хүчин зүйлийн нөлөөгөөр багтраа хөдөлдөг нь түүний тухай цэгцтэй ойлголт боловсруулахад бэрхшээлтэй болгож байгаа юм. Энэ байдлаас үүдээж зарим эрдэмтэд, жишээ нь, нэрт эмгэг физиолог, академич А. Д. Адо (2). „Иммуны бус гуурсан хоолойн багтраа“ гэсэн нэр томъёо гаргасан. Иймээс гуурсан хоолойн багтраа бол нээ онол баримталж тайлбарлах аргаагүй биологийн олон механизмын оролцдог эмнэл зүйн туйлын нарийн нийлмэл үзэгдэл бололтой.

Клиникийн онцлог байдлаар, атопийн (этгээд харшилын), хэлбэртэй, халдварт-харшилын хэлбэртэй гэж хөёр хуваадаг. Атопийн хэлбэр нь тодор-

хой харшил төрүүлэгчтэй холбоотой хөдлөх ба энэ хэлбэрийн үед бие маш-бодод харшилын огцом хэт мэдрэг урвал, өөрөөр хэлбэл иммуны нэг төрлийн эмгэг ўрвал явагддаг нь эргэлзээгүй нотлогдсон юм. Иммуны үндсэн 4 төрлийн эмгэг ўрвал байдаг. (8).

1. Анафилаксийн буюу атопийн урвал
2. Эс хордуулах буюу эс хайлцуулах урвал
3. Иммуонокомплексийн дархан бүрдлийн өвчин
4. Иммуны эсүүд хэт мэдрэгжих урвал

Нэгдүгээр төрлийн иммуны эмгэг ўрвалын үед хүний биед харшил төрүүлэгч ороход түүний хариуд өөрийн эд эс дээр суумтгай шинжтэй IgE, IgG₄ бүлгийн эсрэг биеийн молекул үүсдэг байна. IgE (реагин), IgG₄ бүлгийн молекулүүд нь шигүү мөхлөгт эс (ШМЭ), суурьсаг (базофил) эсүүд дээр суумтгай чанартай юм. Эдгээр эс уүшиг, амьсгалын замын эрхтнүүдийн холбогч эдэд хангальтай их хэмжээгээр агуулагдаж байдаг.

Харшил төрүүлэгч (ХТ) дахин нэвтрэхэд эсрэг биеийн молекул түүнтэй нэгдэх болоч энэ процесс эсийн гадаргууд явагдах учраас эсийн мембранны бүтэц, ферментийн систем хүчтэй гэмтэж түүний мөхлөг дотор агуулагдаж байсан гистамин, гепарин, MPC—А (аажсум сэдээгч бодис—А), ЭХФ—А (эозинофил мөлхүүлэгч фактор—А) серотонин, ацетилхолин мэтийн медиаторууд их хэмжээгээр ялгаран цусанд орж тэдгээр нь богино хугацаанд амьсгалын гуурсыг аглаах, цусны судас тэлүүлж хаван үүсгэх, салс ялгаруулах нөлөө үзүүлжсэг багтраа үүсгээдэг байна. (Хүснэгт 1).


Халдварт-харшилын хэлбэртэй уушгини багтрааны үед реагишууд биш харин ердийн хамгаалач эсрэг бие үүсдэг. Тийм учраас энэ хэлбэртэй багтраа болоход иммуны эмгэг ўрвал онцын ач холбогдолгүй харин парасимпатик мэдрэл голдох үүрэгтэй гэсэн ойлголт нэлээд дэлгэрсэн байна.

Гэвч эдгээр эсрэбийес иммуно-комплекс (дархан бүрдэл) үүсгээдэг билээ. Иммуны комплексийг том залгиур эсүүд залгиж уусган задалж биеэс цэвэрлэж байдаг. Харшил өвчтэй хүмүүст энэ процесс алдагдаж иммуны комплексууд цусны хялгасан судасны хананд шуугээн сууж улмаар хавсаргын тогтолцоог идэвхжүүлж тэр нь мөнөөх л эд эс гэмтээгч медиатор ихээр ялгарч иммуны эмгэг ўрвал үүсгээдэг байна.

Яз бүрийн ХТ-ийн хариуд дээрх эсрэгбиецээс гадна бас харшилын аажсум хэт мэдрэг ўрвал өөрөөр хэлбэл иммуны эсүүд хэт мэдрэгжих ўрвал үүсдэг нь мөн нотлогдсон билээ. Хэт мэдрэгжсэн лимфоцитууд иммуны бусад эс тухайлбал, том залгиур эсийг идэвхжүүлэгч бодисууд (лимфокайн) ялгаруулдаг ба тэр нь цаашид саарамсаг болон суурилаг эсийг цочроож медиаторыг их ялгаруулдаг байна. Эдгээр баримт бол гуурсан хоолдийн багтрааны 70—80%-ийг эзэлдэг халдварт-харшилын хэлбэртэй иммунопатологийн 2, 3, 4-р төрлийн ўрвалууд нөхцөлдүүлж буйн нотолгоо даруй мөн. (Хүснэгт 1).

Вегетатив мэдрэлийн тогтолцоо ямар нэг үүрэггүй болж байна уу? гэсэн асуулт яяндаа гарч байна. Вегетатив мэдрэлийн симпатик, парасимпатик хоёр хэсийн хүлээн авуур; ШМЭ ба уушгини амьсгалын гуурсын гилгэр булчингийн эс дээр аль алино нь байдаг байна.

Хүснэгт 1



Симпатик мэдрэлийн адрендэрг хүлээн авуурыг β-гэж тэмдэглэх ба тэр нь химийн бүтцийн хувьд аденициклиза фермент ажсээ. Мембрани энэ фермент адреналини нөлөөгөөр идэвхжихдээ эсийн доторх АТФ хүчлээс цАМФ (цагираг аденоzin монофосфат) үүсэх ўрвалыг түргэсгээдэг байна. цАМФ-ны

хөөр суурьт катионууд Ca^{++} , Mg^{++} -ийн оролцоотойгоор ШМЭ дотор бол мединатор ялгараахыг багасгах, гөлгөр булчингийн эс дотор бол түүний ашилтыг сүлруулах үйлилгээтийг ажээ цАМФ цаашдаа аденилфосфодиэстазын нөлөөнд идэвхгүй 5-АМФ болж хувирдаг байна.

Парасимпатик мэрдэлийн холинэрг хүдээн авуурыг ч-гээж тэмдэглэх ба тэр нь химийн бүтцийн хувьд гуанилциклизаа фермент ажээ. Энэ фермент ацетилхолины нөлөөгөөр идэвхжихдээ ГТФ (гуанозинтри фосфат)-ыг цГМФ (цагираг гуанозин монофосфат) болгож хувирдаг байна. цГМФ нь ШМЭ дотор бол медиатор ялгараахыг ихэсгэдэг, гилгэр булчингийн эс дотор бол түүний ашилтыг нэмэгдүүлэх үйлилгээтийг юм. цГМФ дараа нь гуанилфосфодиэстазын нөлөөнд идэвхгүй 5-ГМФ болж хувирдаг байна.

Эрүүл хумүүст энэ хөөр мэрдэлийн харилцан тэнцвэртэй байдал ШМЭ-ийн медиатор ялгараахаа гуурсан хоолдийн ашилтыг хэвийн байдал тохицуулж байдаг гол хүчин зүйл юм.

Гэтэл иммуны эмгэг урвалын дунд үүссэн медиаторууд нэг талаас шууд гилгэр булчинг аглаа, хаван үүсгээж багтраа болгохоос гадна, нёгөө талаас энэ хөөр мэрдруулийн тэнцвэртэй байдлыг алдагдуулж тухайлбал, в—адренерг тогтолцооны үйл ажиллагаанд хориг саад учруулдаг байна. Ялангуяа удмын шинжсээрээ харшил өвчинд нэмүү өртөх хумүүст ингээж багтрааны хөөрдэх механизм-вегетатив мэрдэл, дотоод шүүрлийн тохицуулга алдагдах механизмыг сэдрээж орхидогт иммуны эмгэг урвалуудын бас нэг хортой тал оршино. Нэгэнт тэнцвэртэй байдал эвдэрсэн нөхцөлд парасимпатик мэрдэл давуутай идэвхжисж харшлын болоод харшлын бус элдэв нөлөөнд ихээхэн цочромтгой болдог байна. Нар салхи, халуун хүйтэн агаар, утсаа ба бусад физик химийн шалтгаан, сэтгэл санаа додглохоос багтраа хөдөлдөг нь үүгээр тайлбарлагдана.

Иммунопатологийн медиаторууд ба вегетатив мэрдэлийн тохицуулгын өөрчлөлтөөс болж уушгины эд гэмтэхээс гадна хүний биеийн шингэнний зохицуулгын бусад систем идэвхжисж өвчний улам даамжуулна. Эдгээр уургийн бодисууд дотроос хавсарын тогтолцоо, цус булагнуулэх систем, фибрин хайлуулах систем, кинин системийн харилцан үйлчлэхийн учрыг эмчилгээний тактик боловсруулаадаа сайтар бодолцох хэрэгтэй. Чухам ямар медиатор, шингэнний зохицуулгын аль систем илуу хямарсныг баримталж агуяа оролдлого саяхан гарав. Гэвч өвчиний шинж тэмдэг, хэлбэр, үе шатыг харгалзан А. Д. Адо, П. К. Булатов (1969) нарийн хөөр хувваадаг ангиллыг баримтлах боломжтой гэж үзнэ.

Уг ангилалд багтрааны атомийн хэлбэр (A), халдварт-харшлын хэлбэр (I) хөөринг тус бүр хөөр шат: угдээлийн шат (I), багтраны байдал (II) гэж, угдээлийн шатыг хөнгөн, дунд, хүнд гэж гурван үе болгон I_A₁₂₃, II₁₂₃ гэж тэмдэглэдээ. Бас багтрааны урьдал үе-предастма (5) гэж тусгайлах нь бий. (шуухинаа, хамар битүүрэх, нус нуулис гоожих, гуурсан хоолойн цочмог архаг үрэсэл, амьсгаа бачуурах маягтай цочмог, архаг хатгалгаа, цусанд ба цэрэнд эзинофил олшрох г. м.).

Өвчиний клиник шинж тэмдгийн хувьд гэвэл багтраа ид хөдөлж байгаа үед оношлоход төвөгтэй биш билээ. Харин чухам юунаас болсон, ямар хэлбэрийн багтраа бодохыг оношлоход ихээхэн төвөгтэй. Тэр тусмаа үүнийг тодохой оношлохгүй бол таамгаар хагас дутуу. эмнэх болно. Үүнээс үндэслэн дотрын эмч нар ГХБ-ны дархалын механизмын талаар зохих мэдлэг эзэмших шаардлага урган гарч байгаа юм.

ИММУНЫ ОНОШ ЗҮЙ,

1. Онош зүйн хамгийн эртний уламжлалт арга-асууж мэдэх (анамнез) арга багтрааны иммуны онош зүйд чухал ач холбогдолтой.
1. Гэр бүл, удам төрөлд байсан харшил өвчин.
 - а) Аав, авга ах, эгч, өвөө, эмээ нарт
 - б) Ээж, ногац ах, эгч, өвөө, эмээ нарт
 - в) Төрсөн ах, эгч дүү нарт
 - г) Хүүхдүүдэд нь
2. Үүний эмнэх харшлын өвчин тусаж байсан эсэх
3. Тарилга хийлгэхэд урвал өгдөг эсэх (хээээ? хэдийд? ямар тарианд)
4. Таарч тохирилоггүй эм, тарша (ямар эм хэзээнээс таарахаа болжсон)
5. Жилийн аль улирал, байгаль, цаг уурын ямар нөхцөлд багтраа хөдөлдөг (өвөл, зүн, хавар, намар, халуун, хүйтэн, хуурай, чийглэг)
6. Биеийн хүчиний хөдөлмөр, сэтгэл санааны нөлөө
7. Амьсгалын цочмог халдварт өвчинтэй (томуу, гүйлсэн булчирхайн үрэвсэл, ханиад, хатгаа гэх мэт) холбоотой эсэх.
8. Сарын тэмдэг, хүүхэд хөхүүлэх, жирэмслэх, төрөхтэй холбоотой эсэх
9. Голдуу хээээ, хаана хөдөлдөг буюу хүндэрдэг (өдөр, шэнэ, гэртээ, ажил дээрээ, гудамжинд, хотод, ой модонд, хээр гадаа, г. м.)
10. Таарч тохирилоггүй хоол унд (талх, ногоо, жимс, загас, сүү тараг мах, өндөг, самар, бал, чихэр, бялтуу, архи дарс, шар айраг, ундаа гм)

11. Таардаггүй оо энгэсэг, ус, тос түрхлэг, шороо тоос, цэцэг навч, ногооны үнэр
12. Гэр орны байдал (гэрийн тавилга, ор дэр дэвсгэр ямар хийцтэй, хивс-тэй эсэх, муур нохсий, загас тэжээдэг эсэх).
13. Ажлын нөхцөл, амьдралын туршид түүний өөрчлөгдсөн байдал зэргийг сайтар лавлан асуух хэрэгтэй.

II. Арьсны сорил. Шууны алга талын арьсыг өнгөц зүсч (скарификация) таамнаж буй ХТ-ийг дусаагаад 20 минут, 12, 24, 48, 72 цагийн дараа харж оношилно. Энэ аргаар атомийн хэлбэрийн багтрааны шалтгааны бараг 90%-ийг оношилж болно.

III. Иммунологийн лабораторийн шинжилгээ.

- a. Иммуны өөрчлөлтийг илрүүлэх өрөнхий шинжилгээ
 1. Цусны ийлдсийн иммуноголбулины булгүүдийн хэмжээг тодорхойлох,
 2. Гуурсан хоолойн угаадас доторхи IДА-ийн хэмжээ
 3. Гуурсан хоолойн угаадас доторхи том залгиурын идэвх
 4. Е—РОК (Т—лимфоцитын тоог олох)
 5. ЕАС—РОК (В—лимфоцитын тоог олох)
 6. Иммуны комплексийг илрүүлэх
 7. Серотонин, ацетилхолин, гистамин, кинин, калликрейн, простогландини хэмжээг тодорхойлох.
- b. Иммуны өөрчлөлтийг илрүүлэх тусгай шинжилгээнүүд
 1. Суурьсаг эсийн мөхлөг задрах урвал
 2. Сааралыг эс гэмтэх урвал
 3. Прауснитц-Кюстнерийн сорил
 4. Шеллийн сорил
 5. Хавсарга холбох урвал
 6. Шууд бус цус наалдуулах урвал
 7. Том залгиурын мөлхөлтийг саатуулах (МИФ) сорил
 8. Бласттрансформацийн урвал
 9. ІДБ-гийн хэмжээг радиомимун аргаар тодорхойлох
 10. РАСТ (радио-иммуно-аллергссорбцийн тест)
 11. Харшлын маркерыг шинжилж тогтоо ох

Шинжлэх ухааны хэгжлийн хэрээр улам өргөжисж байгаа иммунологийн лабораторийн шинжилгээнүүд, өвчтөний биеийн байдлыг хянах, багтрааны харшлын мөн чанарыг танин мэдэх, эмчилгээний арга болзвсруулахад үнэтэй хувь нэмэр өгч байна. (1, 3, 4, 9, 10).

Иммуны ямар ч шинжилгээ хийгээд харшлын шалтгаан нь олдлоггүй багтрааны тийм тохиолдол ховор боловч байдаг. Жишээ нь: хүүхдэд туссан вирусин халдварт (томуу г. м.)-ын үед зарим бөхчүүдэд барилдах үед хөвөлдөг багтрааны учрыг бүрэн тайлбарлах чадаагүй л байна.

Ер нь аахилсан болгон багтраа биш, бараг 25 өвчиний үед багтрааны шинж тэмдэг гардаг гэдгийг ГХБ гэсэн онош тавих болбол үргэлж санаж байгууштай.

ИММУН ЭМЧИЛГЭЭ

ГХБ үүсч хөгжсихөд иммун механизмын үүрэгтэй тул түүний эмчилгээнд иммун эмчилгээ чухал үүрэгтэй.

1. Зайлуулж эмнэх. Харшил үүсгэгч хүчин зүйлийг өвчтэй хүний орчиндоос зайлуулах, хэрэв боломжгүй бол нутаг солих.

2. Хэт мэдрэгжлийг бууруулах. ХТ-ийг ялган авч ариутгаад бага тунгаас сэгэн уг хүнд зориуд тарьж эхлэхэд өвчин хөдлөхийн оронд харин тэсвэрлэх чанартай болдог.

3. Халдвартыг эмнэх. Ам хамар залгиур, шүдний архаг өвчин, залгиур, мөгөөрс, гуурсан хоолойн архаг үрэвэслэл, уушгини архаг үрэвслийг эмнэх (антбиотик, сульфаниламидин бүлэг).

4. Холинолитик, (холин тайлах) эмүүд

| | |
|---------|------------|
| Атропин | Платифилин |
|---------|------------|

| | |
|----------|---------|
| Астматол | Солутан |
|----------|---------|

| | |
|-------------------------|------------|
| Белладонна (гуга хатан) | Фубромеган |
|-------------------------|------------|

5. Симптомиметик (симпатик төст үйлчилгээний) эмүүд

| | |
|-----------|--------------|
| Адреналин | Оксипреналин |
|-----------|--------------|

| | |
|---------|-----------|
| Эфэдрин | Изоэтарин |
|---------|-----------|

| | |
|-------------|---------------------|
| Изопреналин | Гексапреналин г. м. |
|-------------|---------------------|

6. Гистамины эсрэг эмүүд

| | |
|---------|---------------|
| Тавегил | Гистаглобулин |
|---------|---------------|

| | |
|----------|----------|
| Диазолин | Димедрол |
|----------|----------|

| | |
|-----------|-----------|
| Супрастин | Пипольфен |
|-----------|-----------|

7. Адреналины агонист эмүүд

| | |
|---------------------|-------------|
| Алупент (астмопент) | Сальбутамол |
|---------------------|-------------|

| | |
|---|--|
| <i>И задрин (новодрин)</i> | <i>Изопротеренол</i> |
| <i>эустиран</i> | |
| <i>Бриканил</i> | <i>Простогландин</i> |
| <i>Метапрел</i> | <i>Простогландин</i> |
| 8. Медиатор ялгараахыг зогсоох эмүүд | эмүүд |
| <i>Теофиллин</i> | <i>ДНХГ (динатрий хромогликат)-интал, ломудал, кромолин натрий</i> |
| <i>Простогландин</i> | <i>Тиоксантен (доксантразол)</i> |
| <i>Преднизолон</i> | <i>Оксоксантен (АН 77 25)</i> |
| <i>Дизтилкарбамазин</i> | <i>Нитроиндандион (нивимедон)</i> |
| <i>Дифторофосфат, цитохалазин, колхицин</i> | <i>Задитен (кетотифен)-бензоциклогептатиофен</i> |
| 9. Теофиллин, ШМЭ дотор аденилфосфодиэстэрэзын идэвхийг дарангийлж цАМФ-ын хэмжээг нэмэгдүүлдэг. | |
| 10. Агшилт тавиулах эмүүд | |
| <i>Эуфиллин</i> | <i>Но-шпа</i> |
| <i>Антастман</i> | <i>Папаверин</i> |
| <i>теофиллин</i> | |
| 11. Иммуныг дарангуйлах эмүүд | |
| <i>Делагил</i> | <i>Преднизолон</i> |
| <i>Индометацин</i> | <i>Имуран</i> |
| <i>Плаквенил</i> | <i>Азатиоприн</i> |
| 12. Иммун заслын (иммунокоррекция) эмүүд | эмүүд |
| <i>Левамизол (декарис)</i> | <i>Метилурацил</i> |
| <i>Тимактивин</i> | <i>Продигиозан</i> |
| <i>Диуцифон</i> | <i>Пирогенал</i> |
| <i>Нуклейнат натрий</i> | <i>Сальмозан</i> |
| <i>Цус соруулах (гемосорбция) арга</i> | |
| <i>Плазмофорезийн арга</i> | |
| <i>Лимфоцитофорезийн арга</i> | |
| 13. Канины эсрэг эмүүд | |
| <i>Трасилол</i> | <i>Аминокарбоны хүчил</i> |
| <i>Контикал</i> | <i>Продектин</i> |
| 14. Простогландины эсрэг эмүүд | |
| <i>Аспирин</i> | <i>Индометацин</i> |
| 15. Серотонин, гистамины саатуулуур (ингибитор) | |
| <i>Фенкарол</i> | <i>Стугерон</i> |
| <i>Гомокломин</i> | <i>Бикарфен</i> |
| <i>Сандостен</i> | <i>Ахонон</i> |
| 16. Цэр ховхлох эм | |
| <i>Калий иод, натрий иод</i> | <i>Трипсин</i> |
| <i>Бромгексин</i> | <i>Химотрипсин</i> |
| <i>Бисолтон</i> | <i>Дезоксирибонуклеаз г. м.</i> |
| <i>Содын утлагда</i> | <i>Ферментээр утаж юмуу хөвүүлж угаах (лаваж)</i> |
| 17. Эмийн бус эмчилгээ | |
| <i>Нил яган туяа ба импульс шарлага</i> | <i>Зүү: шу-фу R27 сюань-цизи I21 гэ-шу V17 цзу-сань-ли Е36</i> |
| <i>Биеийн тамир эмчилгээ</i> | <i>шэнь-тан V44 пи-шу V20</i> |
| <i>Цахилгаан хэт дууны давтамж</i> | <i>да-чжуй T14 шан-лянь G19</i> |
| <i>Рашаан сувилал</i> | <i>Хэ-Гу G14 шуй-ту E10</i> |
| | <i>фэй-шу V13 синь-шу V15</i> |
| | <i>(их эмч Д. Билэгтийнхээр)</i> |
| 18. Бусад: сэтгэл санаа засал, бумба, бигнүүр, шинээн, тайвшруулах, гепарин, инсулин, хаван хэхэх, хүчил шүлтэйн тэнцвэр барих, гуурсан хобойг хөвүүлж угаах, унтуулах, зурх судасны дутагдлыг эмнэх, зохиомол амьсгал г. м. | |

Өвчиний ямар үед эмчилгээний ямар арга сонгож авахыг эмч тухай бүр шийдэх бөгөөд эмч өвчиний хөврүүн бүтээлч холбооноос үр дүн шууд хамаарах юм.

АШИГЛАСАН ХЭВЛЭЛ

1. В. Н. Абрисимов. «Бронхиальная астма и реактивность бронхов» Тер. архив. 1981. 4. 135.
2. А. Д. Адо. «Патофизиология бронхиальной астмы» Клин. Мед. 1984. 6. 5.
3. В. П. Сильвестров, А. В. Карапулов. «Антибактериальная и иммуномодулирующая терапия заболеваний органов дыхания» Тер. архив 1983. 3.
4. Я. О. Ольшанский. «Некоторые иммунологические показатели у больных инфекционно-аллергической бронхиальной астмой» Тер. архив. 1983. 3. 10.

5. Г. Б. Федосеев. «Клинические аспекты бронхиальной астмы» Новые аспекты бронхиальной астмы. Симпозиум. Москва, 1981.
6. М. А. Юнусов. «Иммунология и бронхиальная астма» Знание. Серия медицина. 1983, № 11.
7. Ahlgqvist R. P. «A study of the adrenotropic receptors». Am. J. Physiol. 1948 v. 153, p. 586.
8. Coombs R. R. A. Geil P. G. H. «The classification of allergic reactions underlying disease» —Clinical aspects of Immunology. Blackwell Scient. Publ. Oxford, 1963, p. 317.
9. Craps L. «Ketotifen in the oral prophylaxis of bronchial asthma» a review—Pharmacotherapeutic, 1981, v. 3, p. 18—35.
10. Jaeger L. «Лекарственная терапия бронхиальной астмы»—Новые аспекты бронхиальной астмы. Симпозиум. Москва, Сандоз 1981.
11. Oeling A. «Иммунологические аспекты патогенеза бронхиальной астмы»—Новые аспекты бронхиальной астмы. Симпозиум Москва, Сандоз 1981.
12. Szentivanyi A. «The beta adrenergic therapy of the atopic abnormality in bronchial asthma» J. of Allergy. 1968, v. 42, p. 203.

БРОНХИАЛЬНАЯ АСТМА-ИММУННОЕ ЗАБОЛЕВАНИЕ

Н. Мунхтувшин

В статье представлены успехи, достигнутые за последние годы в изучении иммунологических механизмов бронхиальной астмы; анализирован взаимосвязь нейрогуморальных и иммунологических механизмов нарушений регуляции выработки медиаторов тучными клетками и регуляции бронхиального тонуса; приводится новое в диагностике и лечении бронхиальной астмы.

Г. ПҮРЭВСҮРЭН Б. ШИЖИРБААТАР

ЗҮРХНИЙ ЭМГЭГТЭЙ ЖИРЭМСЭН ЭМЭГТЭЙЧҮҮДИЙН ТӨРӨХ ЯВЦЫН ОНЦЛОГ

ЭХ НЯЛХСЫГ ХАМГААЛАХ ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ ХҮРЭЭЛЭН
АНАГААХ УХААНЫ ДЭЭД СУРГУУЛЬ

Зүрх судасны өвчтэй эмэгтэйчүүдийн жирэмсний болон төрөх үед гарч болох хүндэрэл, эх хүүхдийн өвчлөл эндэгдлээс урьдчилан сэргийлэхэд зүрхний өвчний хэлбэр, цусны эргэлтийн алдагдлын хүнд хөнгөний байдал, хэрлэг өвчний идэвхжлийн зэргийг зөв оношлох нь онцгой ач холбогдолтой юм. (2).

Эрд эмтдийн судалгаанаас үзэхэд жирэмсэн эмэгтэйчүүдийн дотор бэлиг эрхтний бус (экстрагениталь) өвчин 0,5—10 % тохижолдож, энэ өвчний үед перинаталь эндэгдэл 55,3 % хүрч байгаа ба 62,2 %-ийг зүрх судасны өвчин эзэлдэг ажээ. (5). Ялангуяа цусны эргэлтийн II, III зэргийн алдагдал бүхий хэрлэгийн гаралтай зүрхний олдмол гажигтай эмэгтэйчүүдийн ургийн 32 % нь перинаталь үедээ энддэг нь онцгой анхаарал татаж байна. (2).

Бид зүрх судасны өвчтэй жирэмсэн эмэгтэйчүүдийн төрөх явцын онцлог, нярайн байдлыг төрсний дараах 7 хоногт судаллаа. Судалгаанд зүрх судасны өвчтэй 67 эхчүүд хамрагдсан бөгөөд тулгар эх 24(35,8 %), давтан төрөгч 43(64,2 %) байлаа.

Судалгаанд хамрагдсан эмэгтэйчүүдийн 32,8 % нь ревмокардит ба миокардит, 32,9 % нь зүрхний олдмол гажиг, 23,9 % нь төрөлхийн гажиг, 10,4 % нь зүрхний хагалгаа хийлгэсэн эмэгтэйчүүд байлаа.

Судалгаанд хамрагдсан эмэгтэйчүүдийн 19/28,3 %)-д нь цусны эргэлтийн алдагдал илэрсний 5/7,4 %) нь зүрхний хэрлэг өвчний идэвхжилтэй байсан юм.

Зүрхний өвчтэй эмэгтэйчүүдийн төрөх явцыг удирдахдаа эх барихын талаас хавсарсан эмгэг бэйгээгаа эсэхийг сайтар анхаарч төрүү-

Хүснэгт I
Жирэмсэн эмэгтэйчүүдийн зүрхний өвчний бүтэц

| Зүрхний өвчинүүд | | Тоо | Хувь % |
|-------------------------------|---|-----|--------|
| Ревмокардит | Идэвхжилтэй | 4 | 5,9 |
| | Идэвхжилгүй | 14 | 20,9 |
| Миокардит | Идэвхжилтэй | 1 | 1,5 |
| | Идэвхжилгүй | 3 | 4,5 |
| Олдмол гажгууд | Хоёр хаваст хавхлагын дутмагцил | 7 | 10,5 |
| | Зүүн тосгuur ховдлын нүхний нарийсал | 8 | 11,9 |
| | Гол судасны хавхлагын дутмагшил | 3 | 4,5 |
| | Гол судасны нүхний нарийсал | 1 | 1,5 |
| | Хоёр хаваст хавхлага, гол судасны хавхлагын хавсарсан гажиг | 3 | 4,5 |
| | Тосгuur хоорондын таславчийн цоорхой | 10 | 14,9 |
| | Ховдол хоорондын таславчийн цоорхой | 2 | 3,0 |
| | Артерийн битүүрээгүй цорго | 3 | 4,5 |
| | Уушгины артерийн нарийсал | 1 | 1,5 |
| | Хоёр хаваст хавхлагын нүхний нарийслыг томруулах хагалгаа | 4 | 5,9 |
| Зүрхний хагалгаа ны байдал | Артерийн битүүрээгүй цоргыг боох хагалгаа | 2 | 3,0 |
| | Ховдол хоорондын таславчийн цоорхой оёх хагалгаа | 1 | 1,5 |
| Бүгд | | 67 | 100 % |

лэх төлөвлөгөө зохиов. Хоёрдугаар хүснэгтэд судалгаанд хамрагдсан эхчүүдийн зүрхний өвчинтэй хавсарсан эх барихын эмгэгүүдийг үзүүлэв.

Цусны эргэлтийн алдагдал, хэрлэгийн идэвхжил, тэдгээрийн хүнд хөнгөний байдлаас, бид зүрхний өвчтэй жирэмсэн эмэгтэйчүүдийг бүлэгт хуваан, бүлэг тус бүрд тохируулан төлөвлөгөө зохиож төрөлтийг удирдав (3). И бүлэгт зүрхний хэрлэг өвчиний идэвхжилгүй, цус-

Зүрхний өвчинтэй хавсарсан эх барихын эмгэгүүд

| Эх барихын эмгэгүүд | Тохиолдол | Хувь % |
|------------------------------------|-----------|--------|
| Төрөх хүчний сулрал | 6 | 8,9 |
| Ургийн ус цагаас өмнө ба эрт гарах | 9 | 13,4 |
| Нэфропати | 11 | 16,4 |
| Эклямпс | 1 | 1,5 |
| Уйтан аарцаг | 5 | 7,4 |
| Илүү тээлт | 4 | 5,9 |
| Өгзөг түрүүлэлт | 2 | 2,9 |
| Дутуу тээлт | 5 | 7,4 |
| Бүгд | 43 | 63,8 |

ны эргэлтийн алдагдалгүй зүрхний ээнэгшсэн гажигтай 36(57,7 %), II бүлэгт цусны эргэлтийн H_1-H_{11a} зэргийн алдагдалтай боловч жирэмсний үед хийсэн бэлтгэл эмчилгээнд сайжирсан 17(25,7 %), III бүлэгт цусны эргэлтийн H_1-H_{11a} зэргийн алдагдалтай, хэрлэгийн A_1 зэргийн идэвхжилтэй, зүрхний булчинд тэжээлийн (дистрофи) өөрчлөлт гарсан 10(14,9 %), IV бүлэгт цусны эргэлтийн $H_1-H_{11a}-H_6$ зэргийн алдагдалтай хэрлэгийн A_1-A_{11} идэвхжил бүхий зүрх судасны дутагдалд орж байсан 3(4,5 %), V бүлэгт цусны эргэлтийн $H_{11b}-H_6$ зэргийн алдагдалтай, уушги хавагнаж байсан 1(1,5 %) VI бүлэгт зүрх судасны үйл ажиллагааны цочмог дутагдлын улмаас уушги хавагнасан эмэгтэйчүүдийг хамааруулсан боловч ийм өвчтөн байгаагүй.

Зүрх судасны эмгэгтэй эмэгтэйчүүдийг жирэмсний 37—38 долоо хоногтой үед нь төрөх тасагт хэвтүүлж бэлтгэл эмчилгээ хийж, төлөвлөгөө зохион түүний дагуу төрөлтийг удирдан явууллаа.

Төрөх үед цусны эргэлтийн дутагдал гүнзгийрэхээс сэргийлэх үндсэн аргуудын нэг нь төрөлтийг өвчингүй болгох явдал юм. Энэ зорилгоор дроперидол 0,25 %-ийн 2,0—4,0 (биеийн 1 кг жинд 0,1—0,13 мг) мөн 1 %-ийн промедолын уусмалыг 1,0—1,5, төрөлтийн нэгдүгээр үед тус тус тарьж шаардлагатай үед 4 цагийн дараа давтан хийлээ. Цахилгаанаар өвчин намдаах (электро-анальгези) аргыг 10 тохиолдолд хэрэглэв. Төрөлтийн II үед төрөх замын булчингийн эсэргүүцлийг сурлуулах, өвдөлтийг намдаах зорилгоор бүх тохиолдолд (Pseudodus-m) уусмалаар хэсгийн мэдээ алдуулалт (новакаины) хийлээ.

Зүрхний эмгэг бүхий эмэгтэйчүүдийн төрөлтийн нэг онцлог нь эх ургийн талаас гарах хундрэлтэй холбоотой элдэв төрлийн эмчилгээ, гардах туслалцаа, мэс ажилбарыг байнга шаарддаг болох нь харагдлаа. Судалгаанд хамрагдсан 67 эмэгтэйд ямар нэг эмийн эмчилгээ, хийсний гадна 36 тохиолдолд эх барихын ажилбар, гардах туслалцаа үзүүлсэн байна. Үүнд: 'Эх барихын хавчуур—24(35,8 %), ваакуумэкстракци—1(1,5 %), кесарево хагалгаа 2 (2,9 %), ургийг хөлнөөс нь татаж төрүүлэх ажилбар 2(2,9 %) эмэгтэйд тус тус хийсэн ба бүх эмэгтэйн 2,9 %-д ураг эвдэх ажилбар хийж, 7,5 %-д умайн хөнлийг гараар шалгах, ихсийг гардах ажиллагаа хийлээ.

Эдгээрээс гүйцэд 62 (93,9 %), дутуу 4(6,1 %) хүүхэд төрсөн ба амьгүй төрөлт 2, ихэр төрөлт 2 байлаа.

Бид ургийг төрмөгц, мөн төрсний дараах 5 минутад АПГАР-аар үнэлж тэдгээр нь эхийн цусны эргэлтийн дутагдалтай хэрхэн уялдаж байгааг авч үзэв. (Хүснэгт 3).

Хүснэгтээс үзэхэд I бүлэгт хамарагдах эмэгтэйчүүдээс төрсөн 36(91,6), II бүлгийн 17 нярайгаас 9(52,9 %)-ийг 8—10 баллаар үнэлсэн байхад III, IV, V бүлгийн эмэгтэйчүүдээс төрсөн нярайн ихэнхийг

Хүснэгт 3
**Эхийн цусны эргэлтийн алдагдал, нярайн АПГАР-ын үнэлгээний
 хамаарал**

| Бүлэг | тоо | Төрөх үеийн АПГАР-ын үнэлгээ | | | | 5 минутын дараах үнэлгээ | | | |
|-------|-----|---------------------------------|-----|-----|------|-----------------------------|-----|-----|------|
| | | 1—3 | 4—5 | 6—7 | 8—10 | 1—3 | 4—5 | 6—7 | 8—10 |
| I | 36 | 1 | — | 2 | 33 | — | 1 | — | 35 |
| II | 17 | — | — | 8 | 9 | — | — | 2 | 15 |
| III | 9 | — | 4 | 5 | — | — | — | 4 | 5 |
| IV | 3 | 3 | — | — | — | — | — | 3 | — |
| V | 1 | — | 1 | — | — | — | — | 1 | — |
| VI | — | — | — | — | — | — | — | — | — |
| Бүгд | 66 | 4 | 5 | 15 | 42 | — | 1 | 10 | 55 |

1—3 ба 4—6 баллаар үнэлсэн байна. Өөрээр хэлбэл эхийн цусны эргэлтийн гажуудал гүнзгийрэх тутам хүүхдийн биеийн, байдал хүндэрдэг болох нь харагдаж байна.

ДҮГНЭЛТ

1. Зүрхний өвчтэй жирэмсэн эмэгтэйчүүдийн дотор халдварт-харшлын үүсэлтэй зүрхний үрэвсэлт өвчинүүд (ревмокардит, миокардит) түүнээс үссэн олдмол гажиг 65,7 % тохиолдож байгаа нь эдгээр өвчний шалтгааныг судлан аль болохоор эрт илрүүлж төгс эмчлэн, хэрэв жирэмсэлбэл түүнийг үргэлжлүүлэх тухай асуудлыг цаг тухайд нь шийдвэрлэж байх шаардлагатай байна.

2. Зүрхний өвчтэй эмэгтэйчүүдийн дотор жирэмсний болон төрөлтийн хүндрэл 63,8 % тохиолдож байгаа нь эрүүл хүмүүсийнхээс 23,8 %-иар их байна.

3. Цусны эргэлтийн алдагдлын зэрэг, хэрлэг өвчний идэвхжил ихсэх тусам ургийн АПГАР-ын үнэлгээний нийлбэр багасч байгаа нь дээрх тохиолдолд ургийн хүчилтөрөгчийн архаг дутагдлын эсрэг, умай ихсийн цусны эргэлтийг сайжруулах бурдмэл (комплекс) эмчилгээг хийх шаардлагатай болохыг гэрчилж байна.

4. Цаашид амаржих газрын дэргэдэх зүрх судасны кабинетийн ажиллагааг өргөтгэн зүрх судасны мэргэжлийн эмч, аппарат тоног төхөөрөмжөөр ханган оношлогоог төгөлдөржүүлж төрөлтийг удирдах аргыг улам боловсронгуй болгох нь чухал.

5. Клиникийн I амаржих газрын нөхцөлд зүрх судасны хүнд өвчтэй хүмүүсийг төрүүлэхэд зориулсан мэдээ алдуулалт, эрчимт эмчилгээний бүрэн үйлчилгээтэй оношлогооны нарийн аппаратаар тонлоглогдсон төрөх өрөөг бий болгох шаардлагатай байна.

АШИГЛАСАН ХЭВЛЭЛ

1. А. З. Валентинова. Риск беременности и родов у больных с митральными пороками сердца. Дисс. канд. мед. наук М. 1974

2. И. А. Генник Н. И. Генник. И. Д. Лановой. Течение беременности, родов и состояние новорожденных у женщин с пороками сердца. Вопр. охр. мат и детс. 1984. № 9 48—49

3. А. А. Мингалеев, Г. Н. Дмитриева, В. А. Копылова. Течение беременности, родов и послеродового периода при ревматических пороках сердца. Методические рекомендации Казань 1976. 40.

4. Г. С. Самойлова, С. С. Павлова—Использование дроперидола и промедола во время родов у больных с пороками сердца. Вопр. охр. мат. и детс 1973 № 2 16—20

5. Особенности организации медицинской помощи роженицам с выраженной сердечной недостаточностью. В кн: "Организация акушерско-гинекологической помощи в РСФСР М. 1980. 46—50.

ОСОБЕННОСТИ ТЕЧЕНИЯ РОДОВ У РОЖЕНИЦ С СЕРДЕЧНОЙ ПАТОЛОГИЕЙ

Г. Пурэвсүрэн, Б. Шижирбатор

Авторами проведены анализ течения родов у 67 рожениц с сердечной патологией. Из патологий сердца наиболее часто встречаются такие заболевания инфекционно-аллергической этиологии как ревмокардит, миокардит и приобретенные пороки сердца. У 63,8 % сердечных больных беременность сопровождается с той или иной акушерской патологией. У 53,7 % больных во время родов были использованы различные акушерские операции и пособия.

Я. ДАГВАДОРЖ

ХҮҮХДИЙН АРХАГ ГЕПАТИТЫН ШАЛТГААНЫ АСУУДАЛД

АСПИРАНТ

Австралий эсрэг төрөгчийг ($\text{HB}_s \text{ Ag}$) илрүүлж (8) В-гепатитын вирустэй холбоотой болохыг тогтоосон нь (9, 11) энэ талын судалгаанд шинэ хуудсыг нээсэн билээ.

$\text{HB}_s \text{ Ag}$ тээгч (клиникийн хувьд эрүүл хүмүүс) одоо дэлхийд 200 сая орчим байгаа ба Ази, Африк, газрын дундад тэнгисийн эрэг орчмын хүн амын дунд харьцангуй олон байна. (12) Манай судлаачдын материалаар, шинжилгээний мэдрэг байдлаас шалтгаалж вирус тээгчид 9,8—21,6% буюу өндөр түвшинд байжээ. (1.7).

В-гепатитаас шалтгаалсан элэгний архаг өвчинүүд нь $\text{HB}_s \text{ Ag}$ бие махбодод байгаа эсэхээс хамаарч өвчний явц, эмнэл зүй, эмчилгээ эрс ялгаатай болохыг тогтоолоо (2, 3).

Зарим судлаачид „эрүүл“ вирус тээгчдэд дархлааны өөрчлөлт (4), морфолог өөрчлөлт (5) гардаг зүй тогтолтойг зааж байна. Мөн $\text{HB}_s \text{ Ag}$ тээгчид ихтэй бүс нутагт (Ази, Африк, Газрын дундад тэнгисийн эрэг орчмын улс орнууд) элэгний анхдагч өмөнгөөр өвчлөх нь мэдэгдэхүйц олон байгаа зэрэгт тулгуурлан В-гепатитын вирус элэгний анхдагч өмөн хоёр холбоотой гэж үзэж байна. (6).

В-гепатит хурц эхэлснээс хойш таван долоо хоногоос $\text{HB}_s \text{ Ag}$ -арилахгүй бол архагших хандлагатай байдаг ажээ. (10).

Ийнхүү $\text{HB}_s \text{ Ag}$ -ыг судлах нь элэгний янз бүрийн өвчнийг ялган оношлох, эмчлэх төдийгүй нийт хүн амын дунд элэгний өвчинд өртөмтгийг хүмүүсийг тогтооход практикийн чухал ач холбогдолтой юм:

Судалгааны арга ба материал: Хурц хэлбэрийн вируст гепатитаар өвчлөөд диспансерын хяналтанд болон гэрээр байгаа бас биохимийн шинжилгээ нь өөрчлөлттэй 1—16 насны 220 хүүхдийн ийлдсэнд $\text{HB}_s \text{ Ag}$ -ыг угтвар цахилгаан ялгалтын ба гель тунадасжуулах аргаар Анагаах ухааны дээд сургуулийн эрдэм шинжилгээний төв лабораторид тодорхойлсон юм. Үүнийг мэдрэг чадвар багатай боловч, хуурамч дүн гарцахгүй найдвартай арга гэж үздэг билээ. Шинжилгээнд хамрагдсан өвчтөнийг өвчин эхэлснээс хойших хугацаагаар авч үзвэл 6 сар хүртэл 99; 6 сараас 1 жил хүртэл 55; нэг жилээс илүү хугацаатай 66 хүүхэд байв.

Ихэнх судлаачид үрэвсэлт өвчин 6 сар үргэлжилбэл архагшдаг гэдэг боловч зарим нь 3 сар, зарим нь 1 жил болж архагшдаг гэж үздэг. Хэрэв нэг жил болоход клиник-биохимийн өөрчлөлт засраагүй бол арга гепатит гэж үзэх бүрэн үндэстэй.

HBs Ag ИЛЭРСЭН БАЙДАЛ

| | бүх хүүхэд | HBs Ag (+) | HBs Ag (+) хүүхдийн хувийн жин |
|-----------------------|------------|------------|--------------------------------|
| 6 сар хүртэл | 99 | 38 | 38% |
| 6 сараас 1 жил хүртэл | 55 | 35 | 64% |
| 1 жилээс дээш | 66 | 54 | 81% |

Бидний судалгаанаас үзвэл үрэвсэлт процесс 1 жилээс дээш үргэлжилж байгаа буюу элэгний архаг үрэвсэлтэй, диспансерын хяналтанд байгаа, биеийн ерөнхий байдал харьцаангуй хөнгөн хүүхдийн 81% нь В-гепатитын вирус агуулж байгаа буюу түүнээс шалтгаалж өвчилсөн байна.

Бидний шинжилгээний аргын мэдрэг чадвар хэдийгээр бага боловч манай нөхцөлд хүүхдийн элэгний архаг үрэвсэл үндсэндээ В-гепатиттай холбоотой байж болох тал харагдаж байна.

А-ч биш В-ч биш вирусээр үүсгэгддэг гепатит их архагших хандлагатай (40—50%-д) (13) байдаг баримт, хүн амын дунд HBs Ag агуулагч 20% гаруй байгаа судалгааны материал зэргийг харьцуулан үзүүлж, хүүхдийн дунд манай нөхцөлд А-ч биш В-ч биш гепатитын өвчлөл их биш байна. Гэхдээ гепатит үүсгэгч хоёр вирус хоёулаа хамт агуулагдах тохиолдол байж болох юм.

АШИГЛАСАН ХЭВЛЭЛ

1. Р. Арслан. Автореф. дисс. канд. УБ. 1978.
2. А. Ф. Блюгер, Х. М. Векслер. Советская медицина. 1973. 8. 79—85.
3. А. Ф. Блюгер. Вирусный гепатит. Рига. 1978.
4. Т. В. Голосова. Вкн: Медицинская вирусология. М. 1977.
5. О. Я. Карташова, Л. А. Салдава, В. К. Залцмане, Л. А. Терентьева, Е. В. Низгольд, Л. П. Брнедел. Вкн: Вирусные гепатиты. Рига. 1981. 114—117.
6. Л. Дж. Мельник, Ф. Б. Холлингер Г. Дрисман Вкн: Вирусные гепатиты. М. 1978. 12—17
7. Л. И. Трофимова, Э. Пуревздава, С. О. Вязов. Вкн: Итоги и перспективы изучения вирусных гепатитов в МНР. Улан-Батор. 1980. 54—59.
8. B. S. Blumberg. N. M. Ridell. J. Clin. Invest 1963. 42. 367—375
9. B. S. Blumberg. B. J. S. Gertstley. D. A. Hungerford. London. W. T. Sutnuk A. J. Amm. Int. med. 1977. 66. 924—931
10. Careoda F, De Franchis R, D. Aminto Monforte A, Vecchi M, Rossi E, Primignani M, Pajla M, Dioguardi N, Lancet 8. 14. 1982. 358—360.
11. Prince A. M. Proc. Nat. Acad. Sci. 1968. 60. 814
12. Viral vaccines and antiviral drugs. Technical Report Series 693. Wld Hlth. Org. Geneva. 1983.
13. Zuckermann A. J. Bull. Wld. H.Lth. Org. 56. 1. 1—20

К ВОПРОСУ ИЗУЧЕНИЯ ЭТИОЛОГИЧЕСКИХ ФАКТОРОВ
ХРОНИЧЕСКОГО ГЕПАТИТА У ДЕТЕЙ

Я. Дагвадорж

У 220 детей, находящихся под наблюдением гепатологического диспансера, с изменениями клинико-биохимических показателей, исследовано HBs Ag по методом двойной иммуноффузии в геле по Уохтерлонги встречного иммуноэлектрофореза. По сроку давности перенесения острого гепатита больные разделены на 3 группы:

1. до 6 месяцев 99 детей
2. от 6 месяцев до года 55 детей
3. свыше года 66 детей

В 1—й группе из 99 детей у 38 (38%) во 2—й у 35 (64%) в 3—й у 54 ребенка (81%) наблюдался положительный результат HBs Ag.

Учитывая малую чувствительность и высокую специфичность методов исследования, основным этиологическим фактором хронического гепатита у детей в условиях МНР является вирусный гепатит В.

Авторы также указывают на возможную ситуацию низкой заболеваемости детей гепатитом ни А—ни В в нашей стране.

П. ЯНСАН

МАЛЧДЫН ӨВЧЛӨЛ, ЭРҮҮЛЖҮҮЛЭХ АСУУДАЛ

АНАГААХ УХААНЫ ХҮРЭЭЛЭН

ЗХУ-ын Н. А. Семашкогийн нэрэмжит Бүх Холбоотын нийгмийн эрүүл ахуй, эрүүлийг хамгаалахын зохион байгуулалтын институттэй хамтран Анагаах ухааны хүрээлэнгээс тус улсын хүн амын өвчлөл, байгаль цаг уурын янз бүрийн бус дэх малчдын хөдөлмөр ахуй нөхцөл, эрүүл мэндийг судлан эмнэлэгт үйлчилгээг боловсронгуй болгох асуудлаар эрдэм шинжилгээний хамтын судалгаа хийж байна. Судалгаанд б аймаг, 17 сум хамрагдлаа,

Судалгааны зорилго: Тус улсын хүн амын өвчлөлийг байгаль цаг уурын бус, эмнэлэгт үйлчилгээний шатлааар тогтоон эмнэлгийн хэргээний хэтийн норматив боловсруулах, малчдын эмнэлэгт үйлчилгээний арга хэлбэрийг боловсронгуй болгох, тэднийг эрүүлжүүлэх арга хэмжээг боловсруулах юм.

Судалсан байдал: Энэ зорилгыг хэрэгжүүлэхэд сум, аймгийн хүн амын өвчлөлийг эмнэлэгт үзүүлсэн байдааар, эмч нарын бүрдмэл үзлэгийн материалаар тус тус судлав.

Хөдөөний хүн амын эмнэлэгт үзүүлсэн байдлыг нэг жилд эмнэлгийн анхан шатны бичиг баримтаар бүртгэсэн материалаас үзэхэд 1000 хүн амд дунджаар 576,0—710,0 өвчлөл ногдох байна. Өвчлөл судаллын II шатны ажил болох эмч нарын бүрдмэл үзлэгийг судалгааны бааз газруудад 13 мэргэжлийн эмч, лаборатори, флюор, зүрхний бичлэг, нүдний бацусны даралт, бие бялдрын хөгжилт, нийгэм эрүүл ахуйн судалгаагаар явууллаа.

Хүснэгт I

Судалгааны бааз, зарим сумын хүн амын өрөнхий өвчлөлийг
эмч нарын бүрдмэл үзлэгийн материалаар тооцож үзвэл

| № | Сумын нэр | Үзлэгт хамрагдсан хүний тоо | 1000 хүн амд ногдох өрөнхий өвчлөл |
|---|-------------------------------------|-----------------------------|------------------------------------|
| 1 | Хэнтий Дархан (1981) | 1273 | 1482,1 |
| 2 | Булганы Орхон (1982) | 1923 | 1112,0 |
| 3 | Өмнөговийн Ханхонгор (1983) БҮГД | 2000 5196 | 1360,0 1294,4* |

*Үзлэгээр илэрсэн хурц ба архаг өвчнийг нэгтгэж тооцов.

Өвчлөлийг эмч нарын бүрдмэл үзлэгийн материалаар судлах нь хүн амын „жинхэнэ“ буюу „нуугдмал“ өвчлөлийг тодорхойлох боломжтой юм. Өөрөөр хэлбэл эмнэлэгт үзүүлэх үед илрээгүй өвчинг илрүүлнэ. Тийм өвчлөлд анализ хийж „илрүүлэлтийн зэрэг“ гэсэн үзүүлэлт гаргана (1). Хүн амыг эмнэлэгт үзүүлснээр бүртгэсэн буюу эмч нарын

бүрдмэл үзлэгээр илэрсэн нийт өвчлөлийг тооцож гаргана. Хүснэгт 1-ээс үзэхэд эдгээр сумын хүн амын ерөнхий өвчлөл эмч нарын бүрдмэл үзлэгийн материалыар үндсэндээ ойролцоо (1000 хүн амд 1112,0—1482,6) байна. Энэ нь Зөвлөлт казак улсын Урал мужийн мал аж ахуй эрхэлдэг Тайпак районы хүн амын өвчлөлтэй нэг түвшинд (Душманов С. Х. 1000 хүн амд 1222,6, 1979) (Б. Дэмбэрэл, П. Янсан 1000 хүн амд 1294,4 1983) байгааг харуулж байна.

Эмч нарын бүрдмэл үзлэгт Эрүүлийг хамгаалах Яам, Улаанбаатар хот, улсын чанартай эмнэлгүүдийн ерөнхий мэргэжилтэн, зөвлөх эмч, эрдэмтэд, нарийн мэргэжлийн эмч нар оролцож, клиник-биохими, скрининг шинжилгээ, флюр, ЭКГ-аар онош тодруулснаар өвчлөлийг үнэн зөв, бүрэн тогтоох бололцоо олголоо. Үзлэгт орсон нэг хүнд дунджаар 1,3 өвчний тохиолдол ногдож байгаа нь өвчлөл бүрэн илэрснийг харуулж байна.

Эмч нарын аливаа урьдчилан сэргийлэх үзлэг нь өвчлөлийг илрүүлэхийн зэрэгцээ, эрүүлжүүлэх арга хэмжээг хэрэгжүүлэх өргөн утга агуулгатай нэгдмэл цогцолбор зорилттой байна.

Сүүлийн жилүүдэд анагаах ухааны эрдэм шинжилгээний байгууллага, диспансер төв, клиникин ба аймаг хотын эмнэлгүүдээс хүн амд хийж байгаа урьдчилан сэргийлэх, бүрдмэл, зориудын үзлэг ихэссэн боловч, төв орон нутгийн эмнэлгийн байгууллагаас үзлэгээр илэрсэн өвчлөлийг эрүүлжүүлэх ажил хангалтгүй учраас өвчлөл тодорхой буурахгүй, улмаар түүний нийгэм эдийн засаг, эрүүлийг хамгаалахын үр ашгийг тооцоход бэрхшээлтэй байна.

Хүснэгт 2

Үзлэгийн үед эрүүлжүүлэх талаар авсан зарим арга хэмжээ

| Сумын нэр | Үзлэгт орсон хүний тоо | газар дээр нь авсан арга хэмжээ | | | | | | | | | |
|----------------------------|------------------------|---------------------------------------|--|--|--|--|-----------------------|---|--|---|--|
| | | Эмнэлэгт хэвтүүлэн эмчилсэн хүний тоо | амбулаторийн хэлбэрээр гардан эмчилсэн хүний тоо | эмчилгээ зааж зөвлөлөө өгсөн хүний тоо | хяналтанд авч сумын эмнэлэгт хүлээлгэн өгсөн хүний тоо | рецептээр газар дээр нь өгсөн эм (төгрөгөөр) | хийж өгсөн нүдний шил | УБ хот явуулж эмчилүүлэх, шинжлүүлэхээр шийдсэн хүний тоо | аймгийн нэгдсэн эмнэлэгт эмчлүүлэх хүний тоо | Тайлбар | |
| 1. Хэнтий Дархан | 1273 | 16 | 123 | 1196 | 55 | 12,585 | = | 34 | 32 | нүдний-шилний үйлчилгээ очоогүй, шил хийлгэх шаардлагатай хүн 187 байв. | |
| 2. Булганы Орхон | 1923 | 13 | 84 | 1623 | 105 | 4000 | 96 | 24 | 55 | | |
| 3. Өмнөговийн Ханхонгор | 2000 | 27 | 190 | 1596 | 234 | 3500 | 182 | 25 | 30 | | |
| БҮГД | 5196 | 56 | 397 | 4415 | 394 | 20085 | 278 | 83 | 117 | | |
| Хувь | 86,3 | 1,0 | 7,6 | 84,9 | 7,5 | = | 8,9 | 1,5 | 2,2 | | |

Бид өвчлэл илрүүлэлтийн зэрэгцээ хүн амын эрүүлжилтийн ажлыг сум орон нутагт хэрхэн зохион байгуулах асуудлаар зарим практик арга хэмжээ авч, цаашид боловсронгуй болгох, үр дүнг тооцох зорилт тавьж байна. Бүрдмэл үзлэгийн мөрөөр сумын хүн амыг эрүүлжүүлэх арга хэмжээг үзлэгийн үед, үзлэгийн дараа гэсэн хоёр шатаар зохион байгуулж байна. Нэг суманд бүрдмэл үзлэгийг дунджаар 14—15 хоногт багтаан хийж байв.

Сумын нийт хүн амаас ажил сургууль, цэрэгт яваа хүмүүсийг хасч тооцвол үзлэгт хамрагдсан 90%, үүнээс эмчилгээ, зөвлөлгөө заасан 84,9%, газар дээр нь эмчилсэн 7,6% байна. Шүд амны хөндийн хурц үрэвсэл, арьсны идээт хурц үрэвсэл, жижиг шарх буглаа, эмэгтэйчүүдийн савны хүзүүний улайлт, төрөл бурийн кольпит зэрэг өвчний гол төлөв тус газар нь эмчлэн эрүүлжүүлж байна. Үзлэгийн дараах эрүүлжүүлэх арга хэмжээг сумын, аймгийн, улс хотын эмнэлгийн хүрээнд эмчлэх гэсэн гурван хэсгээр зохион байгуулж байна. Гурван сумын хүн амын үзлэгээс үзэхэд 1000 хүнээс 320 орчим буюу $\frac{1}{3}$ хувь нь эмчилгээ зайлшгүй хийлгэх шаардлагатай байв. Үүнээс 70 гаруй хувь нь сумын, 20 шахам хувь нь аймгийн, 10 орчим хувь нь улс хотын эмнэлгийн хүрээнд эмчлүүлэх хүмүүс байлаа.

Зүрхний төрөлхийн ба олдмол гажиг, хэвдар, гэмтлийн дараах зарим байдал, засал хийж эмчлэх боломжтой гаж буруу хөгжилт зэрэг өвчин эмгэгийг улс хотын холбогдох нарийн мэргэжлийн эмнэлэгт эмчлүүлэхээр, мэс заслын эмчилгээ шаардагдах төрөл бурийн евэрхий, мухар олгой, геморрой, фиброму, киста, гүйлсэн булчирхайн үрэвсэл, ходоодны шархлаа, элэгний цирроз, бөөрний үрэвсэл зэрэг өвчиний аймгийн нэгдсэн эмнэлэгт эмчлүүлэхээр тус тус заалт гаргав.

Судалгаанаас үзвэл сүм, орон нутагт хамгийн элбэг тохиолдож байгаа шүд, амны хөндийн үрэвсэл, гүйлсэн булчирхайн үрэвсэл, хүүхдийн хялгасан хорхой, эмэгтэйчүүдийн савны хүзүүний улайлт, төрөл бурийн гаралтай кольпит, чихний архаг идээт буглаа зэрэг өвчиний эмчлэх, холбогдох мэргэжлийн эмчийн бүрэлдэхүүнтэй эрүүлжүүлэх бригад үзлэгийн дараа аймгаас газар дээр ирэх нь чухал байна.

Хэнтii аймгийн Дархан (1981), Булган аймгийн Орхон суманд (1982) хийсэн эмч нарын бүрдмэл үзлэгээр өвчтэй илэрсэн хүмүүсийг эмчлэх талаар авсан арга хэмжээ, түүний үр дүнг газар дээр нь шалгаж үзэхэд (1983) Дархан суманд эмчлүүлэх хүмүүсийн 76% Орхон сумын хүмүүсийн 60 гаруй хувь нь эмчилгээнд орсон боловч, энэ хоёр сүмаас Улаанбаатар, аймаг явж эмчлүүлэх ёстой 145 хүнээс 56 нь яваагүй, мөн сумын эмнэлэгт эмчлүүлэх хүмүүс нь эмчилгээ хяналтанд бүрэн ороогүй байлаа. Энэ нь тухайн сум нэгдэл, эмнэлгээс өвчтэй хүмүүсийн ажил хөдөлмөрийг зохицуулан, туслалцаа үзүүлж зохион байгуулалттай явуулж эмчлүүлэх талаар арга хэмжээ аваагүйтэй холбоотой байв. Нөгөө талаар явж эмчлүүлсэн хүмүүсийн бүртгэл тооцоо, эдгэрэлтэнд тавих хяналт шалгарт хангальгүй байна. Хэнтii аймгийн эрүүлийг хамгаалах газар Дархан суманд 2 жилийн дотор нэг ч эрүүлжүүлэх эмч мэргэжилтэн явуулаагүй байна. Ийм байдлаар хүн амын эрүүл мэндэд хандаж болохгүй нь мэдээж билээ.

Бид бүрдмэл үзлэг хийсэн нарийн мэргэжлийн эмч бүрээр тухайн мэргэжлийн тусламжийг хэрхэн зохион байгуулах, хүн амыг эрүүлжүүлэх тухай албан ёсны зааварчилгаа бичүүлж сумдын эмч нарт өгсөн нь чухал ач холбогдолтой боллоо.

ДҮГНЭЛТ

1. Малчдын эмнэлэг үйлчилгээ эрүүл мэндийг онцгой анхаарч, өвчлөлийг бууруулах, эрүүлжүүлэх явдал чухал бийна.

2. Нарийн мэргэжлийн тусламжийн эмнэлэг мэргэжилтний хүрэлцээ, байршил, өвчин эмгэгийн байдлаас болж хүн амын өвчлөлийг эрүүлжүүлэх ажлыг сүм, аймаг, хотын эмнэлгийн хүрээнд гурван шатаар зохион байгуулав.

3. Хүн амыг ажил үйлдвэрлэлээс нь хөндийрүүлэхгүй, чирэгдэл зардлыг багасгахын тулд үзлэгээр өвчтэй илэрсэн хүн амыг газар дээр нь эмчлэн эрүүлжүүлэх, эмч мэргэжилтнийг аймгаас жилд 2-оос доошгүй явуулах шаардлагатай байна.

Эмч нарын үзлэгийн мөрөөр хүн амыг эрүүлжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг сүм нэгдэл, аймгийн эрүүлийг хамгаалах газар сумдын эмнэлэг хамтран 3-5 жилийн хугацаагаар хийж, жилээс дээш хугацаагаар эмчлүүлэх хүн бүрт „эмчлэн эрүүлжүүлэх төлөвлөгөө“ зохиож хяналт эмчилгээг заалтын дагуу чанартай хийж „эрүүлжилтийн тайланг“ жил бүр гарган үр дүнг тооцдог зорилтыг хэрэгжүүлэх нь чухал байна.

5. Сум бүр хүн амдаа бригадын бага эмч, сумын их эмч, аймгийн мэргэжлийн эмч нарын турван шатны үзлэгийг 1985 онд багтаан явуулж, өвчлөлийг тогтоон эмчилгээ хяналтыг зохион байгуулах нь зүйтэй.

АШИГЛАСАН ХЭВЛЭЛ

1. С. Х. Душманов. Особенности заболеваемости медицинское обслуживание населения района отгонного животноводства. М. 1979.

ВОПРОСЫ ЗАБОЛЕВАЕМОСТИ СКОТОВОДОВ И МЕРЫ ПО ОЗДРОВЛЕНИЮ

П. Янсан

Приведены некоторые данные изучения заболеваемости населения трех сомонов (5196 человек).

Результаты исследования показали, что общая заболеваемость по данным обращаемости населения сомона 576,0—710,0 на 1000 населения заболеваемость населения сомона по данным медицинских осмотров 1112,0—1482,6 на 1000 населения.

В статье изложены некоторые предложения по улучшению здоровья скотоводов, разработки оздоровительных мероприятий. Оздоровительные мероприятия проводятся по двум этапам за период комплексного медицинского осмотра и после осмотра.

З.МЭНДСАЙХАН, В.Р.ЗИЦ

ЗАЛУУ ХҮМҮҮСТ ТОХИОЛДОЖ БАЙГАА ШҮҮДЭСТ ПЛЕВРИТЫН ЗАРИМ ОНЦЛОГ ЦЭРГИЙН КЛИНИКИЙН ТӨВ ЭМНЭЛЭГ

Цээжний гялтангийн үрэвслийн эмгэг жам, үүсэх шалтгааны ту хай орчин үед эмч мэргэжилтнүүдийн мэдлэг өргөжсөн ч зарим нэг нь энэ өвчний нэлээд хувийг бие даасан өвчин мэтээр ойлгох буюу гялтангийн хуурай үрэвслийг төдийлөн анзаарагчийг өнгөрөөснөөс цаашдаа цээжний хөндийд наалдац үүсдэг.

Шүүдэст плевритын эмнэл зүйн зарим онцлог, үүсгэх шалтгааныг судлан улмаар уг өвчний зөв оношлох нь чухал.

Судлаачдын үзэж байгаагаар, шүүдэст плеврит нь халдварт, харшлын механизм бүхий хоёрдогч өвчин бөгөөд шалтгааны 70—80%-д нь сүрьеэ өвчин (ил далд хэлбэрээр), үлдсэн хувьд нь дотор эрхтний

янз бүрийн гаралтай эмгэгүүд тохиолдож байна. Манай орны нөхцөлд тохиолдож байгаа шүүдэст плевритын шалтгаан, эмнэл зүйн зарим онцлогийг судлахаар сурьеэ, дотор, гэмтлийн нарийн мэргэжлийн тасагт сүүлийн хэдэн жилд хэвтсэн 230 өвчтөний өвчний түүхэнд судалгаа хийлээ. Судалгаанд хамрагдсан өвчтөний 80% нь харьцангуйгаар ажил амьдралын ижил төстэй нөхцөлд байгаа 18—28 насны эрэгтэйчүүд, улдсэн 20%-д янз бүрийн ажил мэргэжил, насны хүмүүс байв.

Шүүдэст плеврит бүхий өвчтөний эзлэх хувь (тасгуудаар)

Xүснэгт 1

| Тасгууд | Судалгаа хамарсан он | Судалгаанд хамарсан өвчтөн | Үүнээс шүүдэст плеврит бүхий өвчтөн | |
|---------------------------|--|----------------------------|-------------------------------------|------------------------|
| | | | абсолют тоогоор | %-нар |
| Дотор Сурьеэ Гэмтэл | 1982, 1983 1980, 1982, 1983 1983 | 1624 724 190 | 72 157 1 | 4,4% 21,6% 0,52% |

Хүснэгтээс үзэхэд шүүдэст плеврит бүхий өвчтөнүүд голдуу сурьеэ дотрын тасагт эмчлүүлж байгаа ба сурьеэгийн өвчтөний 21,6%-ийг, дотрын өвчтөний 4,4%-ийг эзэлж байна. Гэвч уг өвчний илрэл бүхий нийт өвчтөнд рентген болон бусад нарийвчилсан шинжилгээ хийхэд илэрхий сурьеэ 24,7%, уушгины цочмог үрэвсэл 23,04%, амьсгалын замын архаг өвчнүүд 3,4%, уушги болон бусад эрхтний хавдар 0,86%, хэрлэг ба чоно яр зэрэг системийн өвчин 4,34%, улдсэн 42,6%-д нь өвчний тодорхой шалтгааныг илрүүлж чадалгүй “шүүдэст плеврит” оношоор эмчилсэн хүмүүс байлаа. Сүүлчийн энэ бүлэг хүмүүсийг голдуу сурьеэгийн эсрэг эмээр эмчлэв. Тухайн тохиолдолд эмчилээний тाकтик зөв гэж үзэж болох боловч сурьеэгийн эмээр эмчлүүлэгчдийн 1/2 нь бүрэн эдгэрч, улдсэн хүмүүсийн 2/3-д янз бүрийн хэмжээний наалдац үүсч, 1/3-д нь „ус“ бүрэн шимэгдээгүй гарсан нь эмчилгээний зарчмыг хангалтгүй баримталжээ гэж үзэхүйц байлаа. Ийнхүү „цэвэр“ шүүдэст плевритыг сурьеэгийн эмээр эмчлэхэд үр дүн нь харилцан адилгүй байна.

Өвчтөний нас болон эрхэлсэн ажил төрлийн онцлог өвчлөлд хэрхэн нөлөөлсөнийг судлахаар бүх өвчтөнийг 2 бүлэгт хуваасан юм. 1-р бүлэгт ажил, амьдралын ойролцоо нөхцөлд байгаа (18—28) насны эрэгтэй 185, 2-р бүлэгт—ажил, мэргэжил, амьдралын янз бүрийн нөхцөлд байсан 30—60 насны эрэгтэй 45.

Шүүдэст плевритэд хүргэсэн шалтгааныг бүлэг тус бүрээр ялгаж үзүүлбэл

Xүснэгт 2

| Бүлэг | Өвчтөний тоо | Сурьеэ | Уушгины цочмог Үрэвсэл | | Уушгины архаг Үрэвсэл | | Хавдар | | Системийн өвчинүүд | | Гэмтэл | | Шалтгаан тодорхойлогдоогүй | | |
|---------|--------------|--------|------------------------|----|-----------------------|---|--------|---|--------------------|----|--------|---|----------------------------|----|------|
| | | | тоо | % | тоо | % | тоо | % | тоо | % | тоо | % | тоо | % | |
| 1-БҮЛЭГ | 185 | 37 | 20 | 44 | 23 | 6 | 3,4 | — | — | 8 | 4,3 | 2 | 1,08 | 88 | 4,75 |
| 2-БҮЛЭГ | 45 | 20 | 44,4 | 9 | 20 | 2 | 4,4 | 2 | 4,4 | 2 | 4,4 | — | — | 10 | 2,22 |
| ДҮН | 230 | 57 | 24,7 | 53 | 23 | 8 | 4,4 | 2 | 0,86 | 10 | 4,3 | 2 | 0,86 | 98 | 4,26 |

Хүснэгтээс үзэхэд нийт 230 өвчтөнөэс „дотрын өвчинд хамааруулсан плеврит 30,8%, үлдсэн 70%-д сурьеэ болон шалтгаан нь тодорхой бус плеврит орж байна. „Дотрын“ плевритын зонхилох хэсгийг ушгины цочмог үрэвслийн үе дэх плеврит эзэлж байна. 1 бүлгийн өвчтөнд плеврит олонтоо тохиолдож, илэрхий сурьеэгийн үүсгэвэр бага, харин шалтгаан нь тодорхой биш шүүдэст плеврит хяналтын бүлгийнхээс их байгаа нь нас ахих тутам сурьеэгийн плеврит илүү тод илэрдэг болов уу гэлтэй байна. Залуу насны эрэгтэйчүүдэд энэ өвчин илүү (80%) тохиолдож байгаа, „дотрын“ гаралтай плеврит гадаадын судлаачдынхаас харьцангуй их байгаа нь судалгаа хийсэн эмнэлгийн үйлчлэх хүрээний онцлоогоор тайлбарлагдах боловч, яг сурьеэгийн гаралтай өвчин 24,7%, „шүүдэст плеврит“ оноштой өвчтөн 42,6% байна.

Судалгааны явцад, шалтгаан нь тодорхой бус, сунжуу явцтай плеврит бүхий 3 өвчтөний цээжний хөндийг анх удаа Японы „Олимпас“ фирмийн фибробронхоскопоор дурандаж шинжилгээ хийж, цээжний хөндийн гялтангийн үрэвслийн байдлыг тодорхойлон зураг авч мөн шингэнгийг соруулж, бололцоотой үед үүсч буй нарийн наалдуудыг салгаж, ихээхэн ёөрчлөлтэй хэсгээс гистологийн шинжилгээ авлаа.

Уг өвчтөнүүдэд шинжилгээтэй холбоотой ойрын болон цаашдын хүндрэлүүд ажиглагдаагүй, эмчилгээний үр дүн сайн байсан. Бид цээжний хөндийгөөс авсан „усны“ шинжилгээг үндэслэн 145 өвчтөний гялтангийн шингэнгийн байдлыг тодорхойлсон юм.

Хүснэгт 3

Янз бүрийн шалтгаан бүхий плевритуудын
гялтангийн шингэнгийн байдал (тохиолдлын тоогоор)

| Шингэнгийн шинж байдал ба байрлал | Сурьеэ | Ушгины цочмог үрэвсэл | Ушгины архаг Үрэвсэл | Хавдар | системийн өвчин | Гэмтэл | Шалтгаан тохирогийн тоо | Бүгд | |
|-----------------------------------|---------|-----------------------|----------------------|--------|-----------------|--------|-------------------------|------|------|
| | | | | | | | | тоо | % |
| Хуурай | 8 | 9 | 1 | — | 1 | — | 4 | 23 | 15,8 |
| Тунгалаг шар | 16 | 28 | 2 | — | 7 | 1 | 53 | 107 | 73,7 |
| Цусархаг | 2 | 1 | — | — | — | 1 | 5 | 9 | 6,1 |
| Булингартай | 1 | — | — | — | — | — | 1 | 2 | 1,3 |
| 2 талын (серозон) | 3 | — | — | — | 1 | — | — | 4 | 3,1 |
| ДҮН %-оор | 30/20,7 | /38/ 255 | /3/207 | — | 9/61% | 2/13% | 63/434% | 145 | 100% |

Хүснэгтээс үзэхэд плевритын шингэн голдуу сероз ба өнгөрт шинж бүхий байна. Цусархаг ба булингартай шингэн цөөн байв. Идээрхэг шингэн голдуу олон удаа „цээжнээс ус авахуулсан“ хүмүүст, цусархаг шингэн сурьеэ болон хавдрын үед, харин цээж 2 талдаа устах нь сурьеэ ба системийн өвчиний үед тохиолджээ. Харин 40 өвчтөн эмнэлэгт ирэхдээ плевритын хөндийд нь ямар нэг хэмжээний наалдац үүсэх үедээ байв.

ДҮГНЭЛТ:

1. Шүүдэст плеврит бүхий өвчтөнүүд харьцангуй элбэг тохиолдож сурьеэгийн тасгийн өвчтөнүүдийн 21%, дотрын 4,4%-ийг эзэлж байна.
2. Шалтгаан тодорхой плевритын эхний байранд сурьеэ (24,7%), хоёрдугаарг уушгины цочмог үрэвсэл (23%) орж байна.
3. Нийт плевритын бараг тал хувь нь (42,6%) анхдагч өвчин нь мэдэгдээгүй „шүүдэст плеврит“ оношообр, голцуу сурьеэгийн эсрэг бэлдмэлүүдээр эмчлүүлсэн байна.
4. Хөдөлмөр ахуйн ойролцоо нөхцөлд амьдарч байгаа идэр залуу эрэгтэйчүүдэд уг өвчний бараг тал хувь (47,5%) „цэвэр“ шүүдэст плеврит байдлаар, үлдсэн хувь нь уушгины цочмог үрэвсэл (23%), сурьеэгийн (20%) гаралтай байна.
5. Плевритээр голцуу залуучууд өвчилж байгаа нь янз бурийн халдварт харшилын үйлчилгээнд үзүүлж байгаа залуу бие махбодын урвалж чанарын онцлог бололтой.
6. Плеврийн шингэн ихэнхдээ тунгалаг шаравтар өнгөтэй, нэг талд байрласан байна. Нэлээд тохиолдолд плевритууд цээжний хөндийд ямар нэгэн хэмжээний наалдац үүсгэн эдгэрч байна.
7. Фибробронхоскопыг плевроскоп болгон ашиглах нь морфолог шинжилгээгээр онош батлах бололцоо олгож болох юм.
8. Дээрхээс үзэхэд шүүдэст плевритуудын онош, эмчилгээг улам боловсронгуй болгох, энэ талаар ңарийвчилсан судалгаа шаардлагатайг харуулж байна.

АШИГЛАСАН ХЭВЛЭЛ

1. М.Г.Алябина и соавт Журн. Сов. мед. 1971 № 8. 53—56
2. Г.И.Лукомский ба бусад „Бронхопульмонология“ 1982. 226—227

К ВОПРОСУ ИЗУЧЕНИЯ ЭКССУДАТИВНЫХ ПЛЕВРИТОВ У МОЛОДЫХ

З.Мэндсайхан, В.Р.Зиц

Авторами изучены частоты, этнологический структур и некоторые клинические особенности проявления экскусдативных плевритов у 230 больных, преимущественно молодого возраста, леченных в терапевтическом, туберкулезном и травматологическом отделениях. Отмечены, высокий удельный вес не уточненной этиологии плевритов а среди уточненных, главные места занимали туберкулезии острые плевральны и пр. Также авторами приведена сообщение об успешной проведении торакоскопия—фибробронхоскопом типа „Олимпас“ Японской фирмы.

Авторы пришли к выводу, что больные с экскусдативным плевритом в условиях МНР, по видимому встречаются довольно часто, а лечется они, не очень качественно. Ввиду чего предлагаются усовершенствование лечебно—диагностической работы и необходимость углубленного изучения в этом направлений.

ТАРХИ ТУЛГУУР ЭРХТЭНИЙ ХАВСАРСАН ХҮНД ГЭМТЛИЙН ҮЕД МЭС ЗАСАЛ ХИЙХ АСУУДАЛД

Орчин үед хүн төрөлхтөн шинжлэх ухаан техникийн хувьсгалын ирмүүн хөгжлийн үед амьдарч нийгмийн ахуй хангамж, ажлын нөхцөл нь тасралтгүй дээшилж байгаагийн зэрэгцээ хүн амын дунд осол гэмтлийн улмаас нас барах нь жилээс жилд өсөн нэмэгдсээр байна.

Гэмтэл согогийн эмнэлгийн сүүлийн жилүүдийн судалгаагаар төрөл бүрийн гэмтлийн тохиолдол буурахгүй байгаа нь үүний нотолгоо юм. Хүнд хэлбэрийн гэмтлүүдийн дотор гавал тархины гэмтэл дээгүүр байр эзэлж байна. 1979—1983 онд гэмтэл согогийн эмнэлгийн сэхээн амьдрзуулах, эрчимт эмчилгээнд бүгд 1312 өвчтөн ирснээс 623 буюу 47,5% нь гавал тархины гэмтэлтэй өвчтөн байсны 37,2% нь гавал тархи, хөдлөх тулах эрхтэний хавсарсан гэмтэл байлаа. Мөн хугацаанд хөдөө орон нутагт дуудлагаар нарийн мэргэжлийн тусламж үзүүлэхэд бүх өвчтөний 44,3% нь гавал тархины гэмтэлтэй байлаа. Ийм учраас гавал тархины хавсарсан хүнд гэмтлийн үед гавлын доцуур цус хуралдааж мэс заслын эмчилгээ зайлшгүй шаардагдах үед илрэх үндсэн шинж тэмдгүүд болон, нарийн мэргэжлийн эмч дуудах шаардлаыг бодолцон энэ зөвлөмжийг бичив.

Гавал тархины битүү гэмтлүүдийг уул гэмтлийн зэрэг явцыг харгалзан хуваана.

1. Тархи доргих 2. Тархины няцралын хөнгөн, хүндэвтэр, хүнд хэлбэр, 3. Тархи дарагдах.

Эдгээр гэмтлүүдийн дотроос тархи дарагдсан үед яаралтай мэс засал хийх шаардлага гардаг. Харин тархи дарагдаагүй цөөхөн тохиолдолд мэс заслын эмчилгээ хийнэ. Тухайлбал тархи нугасны шингэн зогсолтгүй гоожих, суурь ясны хугарлын улмаас цус айдах, тархи хавагнах үед хагалгаа хийдэг. Тархи дарагдах үед мэс заслын эмчилгээ доорхи үндсэн 4 тохиолдолд хийнэ.

1. Гавлын доторхи цус хуралт
2. Гавлын яс цөмөрч тархи дарах
3. Уураг тархины аль нэг хэсгийн хэт няцралт
4. Хатуу хальсны доор тархи нугасны шингэнний хязгаарлагдмал хуралдалт (гидром)

Хэвлэлийн тоймоос үзэхэд тархи дарагдалтын 64% цус хуралтаас, 15% нь гавлын яс цөмөрснөөс, 15% нь уураг тархины хэт няцралт, 6% нь нугасны шингэнний хуралтаас үүсч байна гэж үзсэн байна (3).

Эрдэмтдийн үзэж байгаагаар гэмтлийн улмаас гавлын доторхи цус хуралт нь эхний үед болдог. Цаашид тархины түрэгдэлт, хавагнашил давамгайлна. Ийм учраас 3 цагийн дотор мэс засал хийж хуралдсан цусыг авч, цус тогтоовол эмчилгээний сайн үр дүнд хүрнэ гэжээ. [1]

Гавлын доторхи цус хуралтыг оношлоход, мэдрэлийн иж бүрэн үзлэг хийхийн зэрэгцээ эхоэнцефалография (ЭхоЭг), гавал ясны ренген зураг нугасны шингэнний сорилт, шаардлагатай үед гүрээний артерт тодруулагч бодис хийж зураг авах (каротидная ангиография) зэрэг шинжилгээний аргуудыг хэрэглэнэ.

Гавлын ясны доторхи цус хуралтын үед хүүхэн хараа нь цус хуралттай талдаа өргөсөж, эсрэг талын биений мөчний саажилт үүсдэг. Мөн судасны лугшилт удааширч, голомтот таталдаг уналт илэрнэ.

Эхний 3 цагт дээрх шинжүүд ажиглагдвал гавлын доторхи цус хуралт гэж сэжиглэх хэрэгтэй. Харин тархины гэмтэлтэй өвчтөн гэмтэл авснаас хойш хэдэн цаг, хоногийн дараа, толгойн өвдөлт гэнэт ихсэж огиулж бөөлжих, хөдөлгөөн нь ихсэж ухаан нь балартан уналт татаалт өгч эхэлбэл гавал тархины доторхи хажуу цус хуралтын шинж гэж үзэх нь зүйтэй.

Нүдний хүүхэн хараа өргөсөх шинж нь нүдний болон цээж хэвлийн гэмтлийн үед илрэх ч байдаг. Нүдний алим гэмтсэнээс хүүхэн хараа өргөсөж болно. Ийм гэмтлийн үед нүдний алимд цус хуралдах хавагнах шинж ажиглагдаж, хараа муудна. Гэмтсэн нүдний хүүхэн хараа гэрлийн урвалгүй байхад, эруул талын нүдний гэрлийн урвал хэвээр байна. Гэмтлийн шок, цээж хэвлийн хүнд гэмтлийн үед нэг талын хүүхэн хараа өргөсөж болох боловч, өвчин намжаах, шокийн эсрэг арга хэмжээ авах явцад (анизокория) засардаг байна.

Ихэнх тохиолдолд оношийг батлах, тодруулах зорилгоор эхоэнцефалография (ЭхоЭг) ашигладаг юм. Энэ нь өндөр давтамжит долгион ашиглан онош тогтоодог аппарат бөгөөд, хийхэд хялбар, энгийн, ямар нэг хүндрэл өгдөггүй, хортой нөлөөгүйгээрээ сайн талтай.

Онош эргэлзээтэй үед гүрээний arterid тодруулагч бодис хийж рентген зургийг (каротидную ангиографию) авч болох юм. Гэвч ангиографийг гавал тархины хүнд хэлбэрийн няцралт дунд ба уртавтар тархи давамгайлан гэмтсэн, амьсгал, зүрх судасны дутагдлын үед хийж болохгүй. Онош эргэлзээтэй буюу хуралдсан цусны байрлалыг тодруулахын тулд гавлын ясиг цоолж оношлох аргыг хэрэглэнэ. Цоожлолтыг ихэвчлэн цус хуралт үүсдэг чамархайн хэсэгт хийдэг юм. Хэрэв шаардлагатай гэж үзвэл, тах хэлбэрээр байршуулсан 3—5 цэгт нүх гарган уул нүхнүүдийг холбон ясиг сөхөөд хуралдсан цусыг авах хагалгаа хийнэ. Хэрэв хатуу хальсны гадна цус хуралт үгүй бол хатуу хальсиг нээж хатуу хальсны доогуур шалган үзнэ. Тархины эд овойх хөөнгөтөн лугшилт нь мэдэгдэхгүй болсон тохиолдолд тархины доторхи цус хуралтыг тодруулах зорилгоор хатгалт хийх хэрэгтэй. Үүнийг тусгай (игла Кушинга) зүүгээр хийнэ. Тархи ихээр хавагнашсан үед нэг буюу хоёр талын чамархайн ясиг сөхөж, гавлын багтаамжийг ихэсгэнэ.

Гавлын яс хагарч цөмөрсөн сэжиг бүхий үед, рентген зургийг 2—4 чиглэлээр авна. Рентген зурагт гавлын яс 2 см-ээс илүү талбайд 1 см-ээс гүнзгий цөмөрсөн байвал мэс засал хийж, цөмөрсөн ясиг авна.

Харин гавлын яс нь бага хэмжээгээр хагарч, цөмөрсөн үед төв мэдрэлийн ерөнхий болон голомтот шинжүүд илрэхгүй бол мэс заслын эмчилгээ хийх шаардлагагүй юм.

Эмчилгээ ба оношлогоо зорилгоор нугасны ус авах шинжилгээг гавал тархины гэмтэл бүхий бүх хүнд хийнэ. Үүгээр хатуу хальсны доорхи цус харвалт, тархи нугасны шингэний даралтыг тодорхойлно. Тархины хэт няцарсан буюу дарагдсан тохиолдолд тархины доторхи даралтын их бага, тархины түрэгдэлтээс (дислокаци) хамаарахгүйгээр мэс засал хийх шаардлагатай байдаг. Тархины даралт ихсэх, тархи түрэгдэх үед эмийн эрчимт эмчилгээ хийгээд, үр дун өгөхгүй үед л мэс заслын эмчилгээ хийж даралтыг багасгах заалт байдаг. Тархины няцралтыг оношлохдоо, голомтод шинж тэмдгүүд, болон ЭхоЭг, гүрээний arterid тодруулагч бодис хийж зураг авах аргуудыг хэрэглэнэ. Тархины няцралтын үед, бусад гэмтлээс ялгах нэг онцлог шинж бол нугасны усан дахь уургийн хэмжээ эрс ихэсдэг юм.

Гэмтлийн улмаас хатуу хальсны доор шингэний хязгаарлагдмал хуралдалт нь тархины зөөлөн хальс хагарсны улмаас үүсдэг ба цус хуралтаас ялгаатай нь гэмтлийн дараа олон цаг, хоног өнгөрсний хойно үүсч бий. болдог. Үүнийг эрдэмтэд хавхалгийн (клапаны) механизмаар тайлбарладаг.

Гавал тархины шингэний хуралтын үед мэдрэлийн талаас гарах шинж тэмдгүүд ЭхоЭг ба ангиографийн шинжилгээнүүд нь цус хуралтай адилхай бөгөөд гарах өөрчлөлт, шинж тэмдгүүд нь аажмаар будэг илэрдэг. Эмчилгээний тактик нь цус хуралтыг эхний цагт авдаг бол шингэний хуралтыг аажимдаа, хэдэн хоногийн дараа мэс засал хийж болно.

Ийм учраас гавал тархины хавсарсан хүнд гэмтэлтэй өвчтөнд шо-
кийн эсрэг эрчимт эмчилгээг үргэлжлүүлэн хийх явцад артерийн да-
ралт 70 мм-ээс доош буурахгүй боловч сопор комын байдлаас гарах-
гүй, хүүхэн хараа өргөсөх (анизокория) шинж эрс илэрч, аажимдаа
ихсэх, нэг талын биеийн мөчний саажилт илрэх, голомтот таталтат
уналт байх судасны лугшилт удаашрах, рентген зурагт гавлын яс нь
1 см-ээс илүү цөмөрч ЭхоЭг-ийн бичлэгт шилжилт нь 6 мм-ээс их
байгаа үеүдэд яаралтай мэс засал хийх буюу нарийн мэргэжлийн эм-
цийг яаралтай, дуудах нь зүйтэй юм.

Дэд эрдэмтэн Г. ДЭМИД
Их эмч О. БАТСҮХ

АШИГЛАСАН ХЭВЛЭЛ

1. Вестник хирургии. 1983. №6, 1984. №7.

Б. ГОМБО

ХҮҮХДИЙН УУШГИ—ГУУРСАН ХООЛОЙН ӨВӨРМӨЦ БУС ЦОЧМОГ ҮРЭВСЛИЙН ШИНЭ АНГИЛЛЫН ПРАКТИК АЧ ХОЛЬГОГДОЛ

ЭХ НЯЛХСЫГ ХАМГААЛАХ ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ ХҮРЭЭЛЭН

Хүүхдийн уушги-гуурсан хоолойн өвөрмөц бус цочмог өвчний ан-
гилал олон бөгөөд удаа дараагийн ангиллууд цаг тухайдаа уул өвч-
ний эмгэг жам, эмнэл зүй, явц, эмчилгээ, хүндрэлийг шинжлэх ухааны
үндэстэйгээр шийдвэрлэж байсан билээ. Сүүлийн жилүүдэд хүүхдийн
амьсгалын, эрхтний цочмог өвчний үүсгэгчийн бүрэлдэхүүн, өвчний
илрэл явцад нэлээд өөрчлөлт гарсны дээр онш, эмчилгээнд шинэ
арга барил нэвтэрч буй байдлууд нь энэ өвчнийг нэгтгэн дүгнэхийг
хүүхдийн өвчин судлагчдаас зүй ёсоор шаардаж байгааг харгалзан
ХХУ-д шинээр ангилал боловсруулсан юм. Энэхүү шинэ ангиллыг ЗХУ-
ын хүүхдийн эмч нарын нийгэмлэгийн бүгд хурал ба анагаах ухааны
академийн тэргүүлэгчдийн дэргэдэх хүүхдийн өвчин судлалын эр-
дийн зөвлөлийн хурлаар 1978 онд баталжээ.

Иммунофлюоресцентийн аргаар үүсгэгчийг түргэн илрүүлэх бо-
ломжтой болсноос амьсгалын эрхтний цочмог үрэвслийн 70%-ийг гуур-
сан хоолойн вирусээр үүссэн үрэвсэл эзэлж байгааг нотолж байна.

Вирус ба нянгийн төрөл бүрийн омог, түүгээр ууссэн амьсгалын эрхтний өвчний хэлбэрийн хооронд эмгэг жам, эмнэл зүйн тодорхой шүтэлцээтэй тал ч байдаг.

Гуурсан хоолойн ба уушгинь үрэвслийн хэлбэрүүдийг нарийн ялгах нь эрчимт эмчилгээг зөв хийж эндэгдлийг багасгах онцгой ач холбогдолтой юм. Зөвхөн ганц баримтыг дурдахад гуурсан хоолойн цочмог үрэвслийн үед 15—20%-д цэрээр бөглөрснөөс амьсгалын дутагдалд орж эндсэн нь бидний судалгаагаар ажиглагдлаа. Цэрээр бөглөрсөн үед утлага, иллэг тогшилт, цэр соруулах, гуурсан хоолой угаах, хүүхдийг зөв байрлуулах нь эрчимт эмчилгээний гол арга хэмжээ юм.

Манай орны хот хөдөөгийн хүүхдийн эмнэлэг, урьдчилан сэргийлэх байгууллагын тайлангаар хүүхдийн амьсгалын эрхтний цочмог өвчний 75—80%-ийг „пневмония“ онош эзэлж байна. Гэтэл энэ өвчинд хандах хандлага бусад оронд нилээд өөр болсныг анхаарч 1983—1984 онд судалгааны түшиц эмнэлгүүдэд (Архангай аймгийн нэгдсэн эмнэлэг, хүүхдийн нэгдсэн II эмнэлэг) уушги-гуурсан хоолойн өвөрмөц бус цочмог өвчнийг 1978 оны ангиллын хүрээнд хамтын судалгааг явууллаа.

Юуны өмнө хэрэглэсэн ангилаал, оношилгооны критерийг дурдах нь зүйтэй.

Хүүхдийн уушги-гуурсан хоолойн өвөрмөц бус цочмог үрэвслийн ангилаал

Гуурсан хоолойн үрэвсэл:

1. Гуурсан хоолойн цочмог үрэвсэл
2. Гуурсан хоолойн бөглөрөөт цочмог үрэвсэл
3. Нарийн гуурсан хоолойн цочмог үрэвсэл

өвчний явц

цочмог
удааширсан

Уушгини үрэвсэл:

1. Голомтот (нэвчилтэт) үрэвсэл
2. Сегментийн үрэвсэл
3. Цусан хатгалгаа
4. Завсар эдийн үрэвсэл

Өвчний байдал нь: өвчний эмнэл зүйн илрэл буюу хүндрэлээр тодорхойлогдоно.

Хүндрэл: Амьсгалын дутагдал, уушгини авчилт, гуурсан хоолойн бөглөрөлт, хордлого (мэдрэл хордлого, зүрх судасны тогтолцооны хямрал, уушгини хаваншилт, хodoод гэдэсний өөрчлөлт) уушги-гялтангийн: (уушгини үхжил, буглаа, гялтангийн үрэвсэл, идээлэлт ба цооролт), уушгини бус хүндрэл: дунд чихний үрэвсэл, мэнэн, зүрхний булчингийн үрэвсэл г. м.

Энэ ангилаал нь эмнэл зүй, эмгэг анатомын шинжтэй бөгөөд уул өвчний үед зайлшгүй илрэх зарим шинжийг (амьсгалын дутагдал, гуурсан хоолойн бөглөрөлт, зүрх судасны хямрал, хордлого г. м.) хүндрэл гэж үзсэн нь амьсгалын эрхтний цочмог өвчнийг аль болохоор эрт оношилж эмчилж чадвал хүндрэл гаргахгүй байж болно гэсэн санааг агуулсан юм. Тус ангилалын хэлбэр бүр өөртөө үүсгэгч, эмгэг жам өвчний явц, байршил, хундрэлийн ба эмчилгээний онцлогийг хадгалж буй учир ангилалыг дэлгэрүүлэн нарийн судлах шаардлагатай юм. Энэхүү ангилалын дагууд уушги-гуурсан хоолойн цочмог өвчний хэлбэрүүдийг ялан оношлоход юуны өмнө хүүхдийн, гэрлийн, эмгэг анатомч эмч нарын хамтын ажиллагаа, нэг чигийн ойлголт чухал. Олон жил гуурсан хоолойн цочмог үрэвслийг уушгини үрэвслээр оношилж эмчилж байсан арга барилаас ангижрахад тийм ч хялбархан бус нь практикаас харагдаж байна.

Амьсгалын эрхтний өвөрмөц бус цочмог үрэвслийн хэлбэрүүдийг шинэ ангиллын дагууд ялган оношлоход дөхөм болгож тусгай критерийг боловсруулж (Б. Гомбо, С. Дуламсурэн) ажилласан нь оношийг тавихад тойм өгөх чухал ач холбогдолтой юм. Энэхүү критерийг ашиглахад өвчтөний өвчилсөн хугацаа, бодит үзлэгийг сайн хийх нь маш чухал. Жишээлбэл; гуурсан хоолойн ба уушгины голомтот үрэвсэл цөөн хоногийн урьдчилсан ханиалгат, нусгай шуухнаагүйгээр эхэлдэггүй байхад цусан хатгалгаа гэнэт үүсдэг онцлогтой. Гуурсан хоолойн ямар ч хэлбэрийн үрэвслийн үед өвчний 2—3 хоногт цусны нейтрофилийн бодит тоо хэвийн хэмжээнээс 2 дахин буюу түүнээс дээш нэмэгдэх нь хэвэр байдал. Гэтэл уушгины үрэвслийн үед өвчний эхний өдрууддэд 2-оос дээш дахин нэмэгдэнэ. Өөрөөр хэлбэл өвчилсөн хугацааг цусны шинжилгээний үзүүлэлттэй нягт уялдуулах хэрэгтэй. Тогшилтын дүлийн дуу, хэржигнуурний байршилсан (локализованные) хэлбэрийг өвчтөнийг ганц нэг үзсэнээр тогтоож тэр болгон болдоггүй учир хэд хэдэн удаа үзэж энэ шинж тэмдгийг гуурсан хоолойн буюу уушгины үрэвслийн алин болохыг нотлох нь ялган оношлоход ач холбогдолтой.

Xуснэгт I
**Уушги-гуурсан хоолойн өвөрмөц бус цочмог
үрэвслийг оюшилсон байдал**

(Хувиар 1984)

| № | Судалгаа явуулсан газар | Судалгаанд хамрагдсан хүүхдийн тоо | Гуурсан хоолойн бүх хэлбэрийн үрэвсэл | Уушгины бүх хэлбэрийн үрэвсэл |
|---|---|------------------------------------|---------------------------------------|-------------------------------|
| 1 | Улаанбаатар хотын хүүхдийн II нэгдсэн эмнэлэг | 4019 | 56,8 | 43,2 |
| 2 | Архангай аймгийн нэгдсэн эмнэлгийн хүүхдийн тасаг | 721 | 82,0 | 18,0 |
| 3 | ЭНХЭШ Хүрээлэнгийн хүүхдийн сектор | 148 | 57,5 | 42,5 |
| | ДҮН (дундаж) | 4888 | 65,5 | 34,5 |

Туршилтын хугацаанд түшиц эмнэлгүүдэд уушги-гуурсан хоолойн үрэвслийг ялган оношлох нь ихээхэн сайжирсан бөгөөд 1982 онд бүх хэлбэрийн гуурсан хоолойн үрэвслийн зөвхөн 8—27,2%-ийг зөв оношилж байсан бол одоо 3—4 дахин нэмэгдсэн юм. Үүний гол нөхцөлийн нэг нь уул өвчний ялган оношлолт, эмчилгээний талаар хичээл заасны дээр эмч нарын идэвхтэй ажиллагаа байв. Оношилгооны зөв эсэхийг эмнэл зүй, гэрлийн шинжилгээ, өвчний эдгэрэлтийн хугацаа болон эндсэн тохиолдолд эмгэг анатомын шинжилгээгээр нотолж байлаа.

Гуурсан хоолойн хүнд үрэвслийг гэрлийн ба эмгэг анатомын шинжилгээгээр уушгины үрэвсэл гэж ташаа дүгнэх явдал „пневмония“ оношийг хэтрүүлэн тавих томоохон шалтгааны нэг болж буйг анхаарах нь чухал.

Судалгаанаас үзэхэд ялангуяа гуурсан хоолойн бөглөрөөт үрэвслийн үед уушгины цусны эргэлтийн хямраалаас судас цусаар дүүрч

Эдэд хаван үүсэх, гуурсан хоолойн бөглөрөлт янз бүрийн хэмжээний авчилтын голомт үүссэнээс уушгины талбай бүдэгших буюу жижиг голомтот сүүдэр мэт зүйл гардгийг уушгины үрэвсэл гэж андуурах нь олонтой. Гуурсан хоолойн үрэвслийн үед уушгины угийн тунгалгийн булчирхай томрох мөн том судаснуудын цус дүүрэлтээс „прикорневая пневмония“ (одоо үед ийм хэлбэрийн үрэвсэл байдаггүй гэж үздэг) гэсэн дүгнэлтийг гэрлийн шинжилгээгээр хийж байгаа нь уушгины үрэвсэл оношийг „нэмэгдүүлэх“ нэг шалтгаан болж байна.

Түшиц эмнэлгүүдэд хийсэн судалгаагаар хүүхдийн уушги-гуурсан хоолойн цочмог үрэвслийн хэлбэрүүдийг эмнэл зүйгээр нь тогтоожээ.

Xүснэгт 2

Уушги-гуурсан хоолойн цочмог үрэвслийл хэлбэрүүд (%)

| Гуурсан хоолойн үрэвслийн хэлбэрүүд | | | | Уушгины үрэвслийн хэлбэрүүд | | | |
|-------------------------------------|-----------|----------------|----------|-------------------------------------|------------|---------------|--------------|
| Цочмог | Бөглөрөөт | Нарийн гуурсын | Дахилтаг | Голомтот (нэвчилтэг хэлбэрийн хамт) | Сегментийн | Цусан хаталга | Завсар эдийн |
| 33,0 | 13,6 | 8,9 | 5,0 | 27,3 | 5,8 | 3,4 | 3,0 |

Судалгаанаас үзэхэд хот хөдөөгийн эмнэлгийн салбаруудад энэхүү өвчний хэлбэрүүдийн эзлэх хувийг харилцан адилгүйгээр гаргаж байгаа нь юуны өмнө оношилгооны арга барилыг жигд эзэмшиж чадаагүйтэй холбоотой. Хүүхдийн эндэгдэлд уушги-гуурсан хоолойн үрэвслийн хэлбэрүүдийн эзлэх хувь адилгүйн дээр зонхилж буй хэлбэрийг эмгэг анатомын судалгаагаар гаралаа.

Xүснэгт 3

Эндэгдлийн шалтгаанд уушги-гуурсан хоолойн үрэвслийн хэлбэрүүдийн эзлэх хувь

| Гуурсан хоолойн цочмог үрэвсэл | Бөглөрөөт Үрэвсэл | Нарийн гуурсан хоолойн Үрэвсэл | Гуурсан хоолойн дахилтаг Үрэвсэл | Уушгины голомтот Үрэвсэл | Сегментийн Үрэвсэл | Цусан хаталгаа | Завсар эдийн Үрэвсэл |
|--------------------------------|-------------------|--------------------------------|----------------------------------|--------------------------|--------------------|----------------|----------------------|
| 3,0 | 6,0 | 18,1 | 3,9 | 60,0 | 6,0 | 3,0 | II |

Байдлаас үзэхэд амьсгалын эрхтний цочмог үрэвслээр эндэх нь бүх нас баралтын 70%-ийг эзэлж байгаагаас гуурсан хоолойн үрэвслийн шууд хүндрэл болсон уушгины голомтот үрэвслийн хүнд хэлбэрийн нэг нэвчилтэт үрэвсэл давамгайлж байна. Үнддүн шинжилгээ хийхэд голомтод үрэвслийн 60—70% нь больницийн дотоод халдварт буюу „стационарная пневмония“ байлаа. Сүүлчийн энэ хэлбэр их хувьтай байгаа нь гуурсан хоолойн үрэвсэлтэй хүүхдийг уушгины үрэвслээр оношилж эмнэлэгт удаан хугацаагаар хэвтүүлсэнтэй холбоотой. Хавсарсан өвчингүй, гуурсан хоолойн цочмог үрэвсэлтэй хүүхдийг бид 6—7 хонуулаад гэрийн эмчилгээнд гаргаснаар уушги үрэвсэж хүндрэхийг багасгалаа. Хүүхдийн биеийн онцлогоос шалтгаалж эмчил-

гээний ор хэнс хүрилцан адилгүй байх нь мэдээж. Гэвч гуурсан хоолойн үрэвсэлтэй хүүхдийг уушгины голомтот үрэвслээр хүндрэхээс сэргийлэх асуудал чухал байна.

Хүүхдийн уушги-гуурсан хоолойн өвөрмөц бус цочмог үрэвслийн энэхүү ангиллыг практик үйл ажиллагаанд нэвтрүүлснээр;

1. Хүүхдийн амьсгалын эрхтний өвөрмөц бус цочмог үрэвслийн хэлбэрүүдийг ялан оношилж эмчилгээг зөв хийх талаар хүүхдийн эмч нарын мэргэжил мэдлэгийг дээшлүүлэх.

2. Гуурсан хоолойн цочмог үрэвслийг ялан оношилсноор бэльчицод эмчлэх хугацааг зөв тогтоож улмаар больницын орны эргэлт хүрэлцээг нэмэгдүүлнэ.

3. Амьсгалын эрхтний цочмог өвчний үеийн сэхээн амьдруулах ба эрчимт эмчилгээний арга барил сайжирч (утах, гуурсан хоолой угаах, тогшилтот иллэг хийх, хүүхдийг зөв байрлуулах зэрэг) үр дунгээс өгч байна.

4. Уушги-гуурсан хоолойн үрэвслийн эмчилгээний зарим талын үргүй зардал багасаж төсвийн ба эмийн хүрэлцээнд сайн нөлөө үзүүлж байна.

5. Гуурсан хоолойн цочмог үрэвслийн эмчилгээний арга барилыг зөв хийж чадсанаар голомтот үрэвслээр хүндрэх явдлыг 40% хүртэл бууруулж байна.

ПОРФИРИНЫ ӨВЧИН

Порфирины өвчин гэдэг нь цусны гемоглобини порфирины солилцооны өөрчлөлтийн дунд үүсдэг эмгэг юм.
Порфирин-бор гэсэн утгатай үг.

Порфирины солилцоо нь цусны гемоглобиннд байдаг уургийн нэгдэл бүхий пигментийн солилцоо юм. Порфиринууд нь гемоглобин, миоглобилин, каталаз, цитохромуудын биосинтезийн дунд үүсч бий болдог. Геминпротейд, гемопротейдуудын завсрлын бодисуудыг порфирийн гэнэ. Порфирины солилцоо нь завсрлын буюу дагалдах шатаандадаа өөрчлөгддэг. Анхдагч нь (урьдал бодис) порфин юм. Сүүлийн үед дараах порфиринуудыг нээгээд байна. Протопорфирин-IX, мезопорфирин-IX, дейт-ропорфирин IX, копропорфирин I, III, уропорфирин-I, III зэргийг олжээ.

Протопорфирины урьдал бодис нь порфобилиноген бөгөөд өвчтэй хүний шээсэндэх уробилиногенээс олджээ. Хүний биеийн махбодын дотор олон янзын порфирины нийлмэг байдаг. Тэдгээр нь нөсөөний солилцоонд оролцдог байна. Порфирин нь цус, ялгадас, эд эсийн дотор ямар нэгэн хэмжээгээр байдаг. Тухайлбал, цусанд 12—15 мг/100 мл, цөсөнд 30 мг (хоногт, өтгөнд 300 мг шээсэнд 100 мг) тус тус байна.

Порфирин нь эрүүл хүний өтгөн болон шээсэнд маш бага хэмжээтэй байна. Цусан дахь порфириныг нийтэд нь гемотопорфирин гэж нэрлэжээ.

Порфирины өвчний гемоглобини биосинтез алдагдсанаас эд эрхтэнд порфирин хуралдаж үүсдэг. Бөөрний дутагдлын үед альбуминури болоход шээсэнд порфирин багасдаг. Шээсний порфирин нь хүчиллэг зүйл хэрэглэхэд ихсэж, шүлтлэг хоол унд хэрэглэхэд багасна.

Наранд удаан шарах, рентген туяанд шаруулах мөн өөх, тос архи хэрэглэсний дараа порфирин шээсэнд ихсэнэ. Мөн халдварт өвчин, арьс цусны зарим өвчин (хорт цус багадалт, цус задралын анемий)

элэгний өвчнүүд, гепатитууд, сорвижууд (вакцин, сывортик тарих, зарим эмийн бодист хордох (веронал, паральдегид, барьбитурат, мышьякийн төрөл, фосфор, хүнд металл) үед өвчин үүсч шээсэнд ихэсдэг. Порфирийн буй болохыг гемоглобини синтезтэй холбож үзэх бөгөөд чухам элэг, ясны чөмөг хэмэнд байдаг эритробластууд юм гэж үздэг байна. Порфирийн солилцоо алдсанаас уг өвчин үүсдэг бөгөөд тэр нь арьсны, хэвлэлийн, мэдрэлийн шинжээр болон порфирийн ихсэх байдлаар илэрдэг.

Порфирийн өөрчлөлт нь чөмөг хэмэнд (эритропоэзийн шатанд) түүний үүслийг тохишуулагч ферментын өөрчлөлтөөс хамаарна. Үүнд: Трикарбоксилийн цагираг идэвхтэй хувьсан, хүчлийн катализыг сайжруулж улмаар дельтоаминолевулины хүчлийг үүсгэдэг байна.

— Дельтоаминолевулины хүчил нь хувирч портопорфирийн болдог.

— Ферментийн нөлөөгөөр профобилиноген нь протопорфирийн болж хувирдаг.

Порфирийн өвчнийг төрөлхийн ба олдмол гэж 2 хуваадаг. Төрөлхийнх нь ховор тохиолддог, оношлоход ч хэцүү байдаг. Төрөлхийн порфирийн генээр дамжин уdamших шинжтэй. Төрөлхийн порфирийн Гюнтерийн өвчин гэдэг.

Олдмол порфирийн өвчнийг дараах хэлбэрт хуваана.

1. **Арьсны хэлбэр.** Нарны хэт ягаан туяаны нөлөөгөөр арьс нь улайж, жижиг цэврүүнүүд нүүр, гарын ил хэсгээр гарч, тэр нь амархан шалбарч, хоёрдогч халдварт орж болохын хамт эдгэрсний дараа арьс нөсөөдөх эсвэл нөлөөгүй байдлаар үлдэнэ. Шарх сорви ч тогтох явдал байдаг.

2. **Мэдрэлийн хэлбэр.** Төвийн ба захын мэдрэлийн шинжээр илэрнэ. Мэдрэл сэтгэлийн соготой, цочромтгой, аймтгай, эмзэгшил ихтэй, заримдаа дэмийрэх, истерийн шинж илрэх, өгсөх паралич Ландри болох, амьсгалын паралич үүсч болно. Зарим үед комд ч орж болно. Нурууны дагуу, давсаг цавины орчим хатгаж өвдөнө. Цөс бөөрний чулууны хатгалгаа гэж оношилох явдал ч байдаг.

3. **Хэвлэлийн хэлбэр-Хэвлэлийн хөндийн эрхтэний хатгалгаат хэлбэр гэдэг.** Хэвлэлийгээр хүчтэй хатгаж өвдөх бөгөөд энэ нь хэвлэлийн зөвлөн, дүүрэнг, булчингийн агшилтгүй, хатах, эсвэл үе үе суулгах, порфирийн (приступ) өвдөлтийн үед өвчтөн турж, булчин суларч хатангирших, гэдэс удаан хугацаагаар агших ба гэрэлд харахад 12 хуруу гэдэс нарийн гэдэсний дээд хэсгүүд тэлэгдсэн, чөлөөлөгдөх нь удааширсан байдаг. Шээсний дотор порфирийн гардагаас өнгө нь улаан болдог боловч заримдаа өнгөгүй тунгалааг байх нь ч бий. Шээсний удаан байлгахад өнгө нь хувирч улаан болдог. Шээсний бусад будагч бодисуудын үед өнгө нь хувирдгийг санах хэрэгтэй.

4. **Элэгний архаг буюу холимог хэлбэр-**Гепатитууд, цирроз, мөн түүнээс гадна элэгний эсийн гэмтэл цочмог атрофи, элэгний өмөн, механик шаралтын үед порфирийн шээсэнд ихэсдэг.

5. **Шалтгаан нь мэдэгдээгүй хүрц, хордлого бүхий хэлбэр.**

6. **Архаг хэлбэр-**Гол шинж нь наранд явсны дараа арьс улайж цэврүүтнэ. Гэдсээр хатгаж өвдөх, элэгний ажиллагаа алдагдах, энэ үед порфирийн цөсөөр гарах нь багассанаас болдог гэж Р. Хегглин үздэг. Уул архаг хэлбэр гол төлөв архи уусны дараа тохиолддог. Шээсний дотор гол төлөв уропорфирийн олдоно. Хоёрдогч порфирийн үед (сульфаниламидууд, цагаан тугалганы хордлого, хорт ба цус задралын анемий, механик шаралт, гемаррагийн дараа, элэгний өвчнүүд, зарим халдварт өвчин) шээсэнд зөвхөн копропорфирийн тодорхойлждана.

Порфирийн өвчин үүсгэдэг нэг гол зүйл бол этил бүхий бензин юм. Энэ өвчний лабораторийн шинж нь шээсэн дотор порфирийн нөсөө тодорхойлох явдал юм. Эрүүл хүний шээсэнд порфирийн 0,03—0,035 мг

байдаг бол энэ өвчний үед ихэнэ. Шээсэнд гемотопорфирийн буй болох нь энэ өвчинөөс гадна эмийн хордлого, тугалга, мөнгөн усны хордлого, хорт ба цус задралын анемий, элэгний өвчинүүдийн үед **ихэнэ**. Шээсэнд порфирийн тодорхойлоход Сальковскийн сорилыг хэрэглэнэ. Энэ нь уг өвчтөний шээсэнд боритов хольцыг тундас үүстэл нэмж дараа нь түүнийгээ шүүж, гарсан тундсаа усаар, спиртээр угааж дээр нь 5—8 дусал давсны хүчил нэмж, дахин шүүгээд уг уусмалаа спекторд оруулж судална.

Лавровский арга нь цусыг авч хүчтэй хүхрийн буюу давсны хүчлээр шингэлэхэд гемотопорфирийн үүсэх бөгөөд түүнийгээ спекраль шинжилгээнд оруулна. Төрэлхийн порфиринаас ялгаатай нь үргэлж порфобилиноген, уропорфирийн бүхий байдаг.

Порфобилиноген тодорхойлох (Watson-Schwartz)-ын арга:

Эрлих реактив (2 хувь аминобензальгиыг 20 хувийн давсны хүчлийн уусмалд) найруулан 5 дусал авч дээр нь 5 дусал шээс нэмэхэд улаан өнгөтэй болох ба 5 мл хлорформ нэмэхэд сэгсрэн тавихад хлорформд ууссан стерко ба уробилиноген хуруу шилний доод хэсэгт ялгаран улаан өнгө илэрнэ. Улаан өнгө дээд хэсэгт илрэх нь порфобилиноген юм. Энэ сорил янз бурийн порфириныг ялгана.

Элэгний хэлбэрийг элэгнээс биопси авч кварцын гэрэлд юмуу түяанд барихад улаан ягаан өнгөтэй болдгоор онош тогтоож болно. Арьсны хэлбэрийн үед хумс хөндийрөн нүүж унаж болдог. Порфирийн өвчний үед цусны ийлдэс, шээсийг нь наранд тавихад ягаан улаан өнгөтэй болдог байна. Өвчтөн өвлүүн цагт нартай өдөр цасан дээр шээхэд тод улаан ягаан өнгө үүсдэг байна.

Эмчилгээ:

1. Сэтгэл мэдрэлийн талаар тайван байлгах, химиин бодисын нөлөөнөөс хамгаалах, өвчтэй эрхтэн арьс, элэг зэргийг механик цочрол, хими, эмийн хорт нөлөөнөөс хамгаалах, төв мэдрэлийн системийг тайвшруулах, нойрыг уртасгах, (нойрны эмгүйгээр) барьбитурат бол энэ өвчинийг үүсгэх нэг шалтгаан тул хэрэглэхгүй, рефлексийн буюу цахилгаан нойрсуулалтыг хийх хэрэгтэй. Химиин цочрол өгөх бодис хэрэглэж болохгүй.

2. Эмийн эмчилгээнээс элэгний бэлдмэлүүд (сирепар, комполон, репазон) витамин эмчилгээ хийнэ. Харшлын эсрэг эм, мэдрэлийн хориг эмүүдээс хэрэглэнэ. АКТГ кортикостероидуудаас хэрэглэнэ. Өвдөлт ихтэй үед өвчин намдаах эм хэрэглэнэ. Цус авч, сэлбэж эмчлэх нь сайн үр дүнтэй ба үгдрэл, дахилтыг 3—5 жил, зарим өвчтөнд 10 жилээр ч бууруулж байна.

Цус авч эмчлэх арга нь өвчтөн хэвтсэний дараагийн 7 хоногт 500,0, хоёрдугаар долоо хоногт 500,0, гуравдугаар долоо хоногт 500,0, дөрөвдүгээр долоо хоногт 500,0, эхний сард бүгд 2000,0, дараагийн сард хоёр долоо хоногт 500,0, дөрөвдүгээр долоо хоногт 500,0, амбулаториор бүгд 1000,0, дараагийн 3-р сард эцэст нь 500,0 цус тус тус авах аргаар эмчилж бүгд 3500,0 цусыг авснаар нарны гэрээлд нэрвэгдсэн гемоглобин өөрчлөгдсөн эритроцитуудыг сольдог. Энэ нь сайн үр дүнтэй. Мөн өвчтөний байдлаас болж дахих юмуу цус багасах шинж илэрвэл цус сэлбэнэ,

СЭРГИЙЛЭХ АРГУУД:

1. Порфирины өвчин нь этил бүхий бензины нөлөөнөөс үүсдэг тул түүнийг амаар сорох, хамаагүй асгаж ууршуулахаас болгоомжлох хэрэгтэй. Энэ нь жолооч, техникийн мэргэжлийн хүмүүст их тохиолддог.

2. Архины зүйлийг хэрэглэхгүй байх.

3. Наранд удаан явснаас зарим хүмүүст үүсдэг учир нарны гэрлээс хамгаалж явах нь чухал (цагаан малгай, бээлий өмсөх, тос түрхэх г. м)

4. Хоол ундан хлорфил багатай ногооны зүйл цагаан идээ, витамин их хэрэглэх нь чухал.

5. Мах болон хүчил багатай хоол унд хэрэглэх нь энэ өвчинөөс сэргийлэх нэг гол арга юм.

Их эмч г. ГЭНДЭНЖАМЦ

Д. ЛУНТАН

БАГА НАСНЫ ХҮҮХДИЙН ЦОЧМОГ БРОНХИТЫН ЭМЧИЛГЭЭ

ЭХ НЯЛХЫГ ХАМГАЛАХ ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ ХҮРЭЭЛЭН

Одоогийн байдлаар манай хот хөдөөгийн эмч нарын практик ажиллагаанд амьсгалын замын өвөрмөц бус цочмог үрэвслийн шинж тэмдгийг дутуу үнэлэх, оношлогооны шалгуурыг бурэн сайн эзэмшээгүйн улмаас онош болоод эмчилгээнд ихээхэн дутагдал оршиж байна.

Энэ байдлыг арилган амьсгалын замын цочмог өвчний шинэ ангиллын дагуу зөв оношлох, эмчлэх, илэрч буй хам шинжийн дагуу оновчтой шуурхай арга хэмжээ авахад голлон анхаарах хэрэгтэй.

Бага насын хүүхдийн амьсгалын эрхтэний өвөрмөц бус цочмог халдвартын щалтгаан ихэнхдээ вирусын халдвартай учраас хүнд явцтай, хүндрэл ихтэй байдаг. Вирусын хоруу чанараас өвчний хэлбэр, эмнэлзүй, өвчний явц, хүндрэлийн байдал, эмчилгээ шалтгаална. Архаг халдвар (хамар, хоолойн) уул өвчнийг үүсгэх буюу үрэвсэлт процессыг даамжуулдаг.

Бронхитын энгийн хэлбэрийн үед хамар залгиурын архаг үрэвслийн эсрэг эмчилгээ хийхийн хамт гуурсан хоолойн салст бүрхэвчийн үрэвслийг намдаах, бронхын агшилтыг багасгах, шүүрэл салсыг ба хаванг бууруулах, хүчтэй ханиалгыг намдаах зорилгоор шинж тэмдгийн эмчилгээ-цэр шингэлэх ба зайлцуулах, тайвшруулах, ханиалгыг багасгах кальцийн бэлдмэл, салицилат, аскорбины хүчил В-группын витамин хэрэглэнэ.

Цэр ялгарахыг сайжруулах ба төвөнх нарийсах үед цэр хуурайшилтаас хамгаалж байрны чийглэгийг 90—100 % хүртэл байлгаж утлага хийнэ. Утлаганд ямар эмийн бэлдмэл хэрэглэхийг өвчтөний хувийн онцлог өвчний хэлбэрт тохиуулан сонгоно. (4-р зүйлд үз). Түүнчлэн зайдруулах эмчилгээ (гич, бумба тавих, гичтэй халуун усанд хөлийг нь дурэх) хийнэ. Хүүхдийн байрлалыг сольж хэвтүүлж байх, өрөө тасалгаандаа цэвэр агаар оруулж байх нь чухал. Хүүхдийг тайван унтуулахын тулд эмчилгээний ванни усны градусыг аажмаар нэмж 38°—40°C хүртэл усанд оруулах, 1 %-ийн натри бромын уусмал уулгана. Хуурай ханиаж цэр ховхоргүй байгаа үед цэр ховхлох (алтай, термопис, стеллериафитин, чигатуссин зэрэг) эмийг насын тунгаар зааврын дагуу хэрэглэнэ. Цэр их ялгарч буй тохиолдолд ханиалга намдаах бэлдмэл (ялангуяа кодеини төрлийн) хэрэглэх нь хориотой. Хүчтэй хуурай ханиалгаж байгаа үед өвчтөний шаналгааг хөнгөвчлөхийн тулд үүнийг хязгаартай хэрэглэнэ.

Биеийн байдал сайжирсан үед 3—4 дахь өдрөөс нь физик эмчилгээ УВЧ, солюкс, электрофорез, биеийн тамир, иллэг, амьсгалын дасгал хийнэ. Эдгээрийн хамт биеийн эсэргүүцлийг дээшлүүлэх, архаг

халдвартыг арилгах, чийрэгжүүлэх болон витамин засал хийнэ. Энгийн бронхитын үед өвчтөнийг гэрт нь хэвтрийн дэглэм сахиулах ба даарч хөрөхөөс болгоомжлон витамин элбэгтэй чанарлаг хоол өгч хүүхдийн асаргаа сувилгаанд голлон анхаарах бөгөөд антибиотик эмчилгээ хэрэглэхгүй. Харин хоёрдогч нянгаар өвчилсөн үед бие султай бага насын хүүхдэд антибиотик хэрэглэж болно.

Обструктивийн бронхит ба бронхиолитийн үед бронхийн бөглөрөлтийг арилгаж амьсгалын дугагдлаас гаргах эрчимт эмчилгээ чухал. Үүний тулд юуны өмнө:

1. Амьсгалын замын цэр салсыг соруулж чөлөөтэй амьсгалах боломжоор хангах. Цэр салсыг соруулах гуурсан хоолойг цэвэрлэх эмчилгээ хийнэ. Энд янз бүрийн арга хэрэглэж болно. Нарийн гуурсаар цахилгаан сорогчоор соруулах, резин баллон ашиглах, хэлийн угийг цочроож цэрээр бөөлжүүлэх зэрэг аргуудын аль боломжтойг хэрэглэнэ.

Хүүхдийг түрүүлгээ харуулж цээжин биенийг гүдайлган зөөлөн тогшилт хийж цэр ховхлох заслыг өдөр бүр ялангуяа өглөө хүүхэд сэргийн дараа хийх нь ашигтай. Дернажийн байрлалыг доргилтод (вибрационный массаж) иллэгтэй хослуулах эмчилгээний дасгал зэрэг нь уул өвчний эмчилгээний гол аргын нэг болно.

2. Хамрын амьсгалыг бийнга чөлөөтэй байлгахын тулд физиологийн уусмалаар цэвэрлэх, 2%-3%-ийн эфедрин болон содын уусмалтай дусалга, интерферон, 8% аминокапроновийн хүчлийн уусмалыг хамарт өдөрт 2-4 дусаана.

3. Хүчилтөрөгчийн 40%-ийн агаартай хольж чийглэж гуурсаар, амьсгалын аппаратаар өгнө. Хүчилтөрөгчийг 15-20 минутаас доoshгүй хугацаатайгаар хоногт 5-8 удаа өгөх ба уушги хаванших шинжтэй үед спирттэй холимгоор хүчилтөрөгчөө гүйлгэнэ.

4. Цэрийг шингэлэхийн тулд шүлтлэг, давслаг уусмалаар халуун бүлээн утлага хийх нь ашигтай. Утлага хийхэд цэрийг шингэлж зайлзуулахад бие махбодод гаж нөлөө үзүүлдэггүй эмийг сонгож авах нь зүйтэй. Орчин үед утлаганд өргөнөөр хэрэглэж байсан антибиотик, фермент, 0,9 %-ийн хлорт натрийн уусмалыг хэрэглэх явдлыг щүүмжлэлтэй ханддаг болсныг анхаарвал зохино. Харин 0,45 % хлорт натри (гипоточеский) уусмал, 1-2% сод, 8% аминокапроновийн хүчлийн уусмал, ацетилцистеин, шүлтлэг радикал давамгайлсан мениралын уусмалаар (брожом) утас нь илүү үр дүнтэй гэж үзэж байна. Цэр их ялгарч байгаа үед бронхийн салстын хэт шүүрлийг багасгах зорилгоор нэрмэл ус 50,0, демидрол 0,2; витамин С 5% - 2,0 зэргээр утас, бронхийн агшилт давамгайлж байгаа үед нэрмэл ус 50,0 эуфилиин 0,3; эфедрин 0,2-оор утас, цэр нь өтгөрсөн цэр ховхролт муу үед 0,45%-ийн натри хлоридын уусмал 5-10 мл, брожом буюу содын 2%-ийн 5-10 мл уусмалаар утна. Бронхийн салстын хавагнашил, бронхийн салстын хэт шүүрэл ба агшилт хавсран илэрч байгаа үед дээрх утлагын салаавчлан утна. Шаардлагатай үед мөгөөрсөн хоолойг дурандаж гуурс тавьж цэвэрлэж болох, боловч сүүлийн үед энэ аргыг хэрэглэх нь төдийлөн сайнгүй гэж үзэж байна. Цэр соруулах, цэвэрлэх ажиллагааг эхний үед цаг тутам 30 секундээс илүүгүй хугацаагаар дараа нь давтан 10-15 секундээр гэх мэт соруулах ба хүчилтөрөгчөөр амьсгалуулна. Утлагыг ердийн аргаар ч мөн утлагын аппаратаар ч утаж болох боловч чухам ямар хэмжээтэй гуурсан хоолойн хэсэгт бөглөрсөн зэргээс хамаарч хэрэглэх утлагын аппарат түүний үр дүн ялгаатай байна. Тухайлбал уушгинь захын жижиг гуурсан хоолой (бронхиол) бөглөрсөн үед ердийн утлагын аппарат үр дүн муутай бөгөөд эмийн бодисыг гүн хэсэгт хүргэхэд ультр утлагын аппарат (TUR-40, 50, 70) түүнтэй төстэй аппарат сайн үйлчилгээтэй байдгийг анхаарч ялгавартай хандах хэрэгтэй. Шаардлагатай бол утлагыг өдөрт 2-3 удаа давтаж болно.

5. Бронхийн агшилтыг багасгах, хаванг бууруулж, харшил ба салстын хэт шүүрлийг намдаахын тулд эуфиллин, эфедрин, димедрол оролцсон холимгийг тохирсон тунгаар өгнө. 2,4%-ийн эуфиллиныг глюкозтой хамт судсанд таривал түргэн үйлчилнэ. Тунг нэг хүртэлх насны хүүхдэд 1 мл, 1—3 насанд нас тутамд 1 мл-ээр бодож хоногт 3—4 удаа судсанд, дуслаар ч хийж болно. Харин харшил намдаах бэлдмэлүүдийг тун болгоомжтой хэрэглэх хэрэгтэй. Учир нь эдгээр эм нь салст бурхүүлийг хуурайшуулдаг учир зөвхөн цэр ялгарч байгаа үед хэрэглэх нь зохимжтой.

6. Дааврын бэлдмэл (преднизолон, гидрокортизон бусад) ба тайвшруулах (седуксин, проперидол, ГОМК) эмүүдийг хордлоготой хүнд үед зохих тунгаар тарина. Коллапс, шок, бөөрний дээд булчирхайн дутагдлын шийж илэрсэн үед дааврын бэлдмэлийг судсаар тарьж цөөн хоног хэрэглэж болно.

7. Амьсгал дутмагшин гүнзгийрч хүчил шүлтийн тэнцвэр алдагдаж хүчилжилтийн шинж илрэх үед 4%-ийн сод, 2%-ийн глутамины хүчил судсаар тарина. Мөн кокорбоксилааз, АТФ, витамин С, В бүлгийг хэрэглэнэ.

8. Амьсгал хэт олширсноос шингэнээ алддаг, шингэн алдалтын хордлого хавсарсан үед шингэннийг хоногт 50 мл-ээр биеийн жин тутамд бодож судсанд дуслаар хийх буюу давслаг, чихэр, шүлт агуулсан уусмал (оралит) уулгана. Найрлага нь: глюкоз 20,0; хлорт натри 3,5; хлорт кали 1,5; сод 2,5-ийг 1 литр усанд найруулна. Энэ тохиолдолд шээсний гарцыг анхаарах хэрэгтэй. Шээсний гарц бага, уушги, тархины хавагнашлын шинж илэрвэл хийх шингэнний хэмжээг багасгана.

9. Мэдрэл хордлогын үед таталт намдаах, халуун бууруулах, хэт амьсгаадалтын эсрэг, тархи, уушгины хаванг арилгах, микроциркуляцыг сайжруулах хам шийжийн дагуу арга хэмжээг зохих зааврын дагуу өвчтөний биеийн байдал, нас, өвчний онцлог байдалд тохицуулан авна. Таталтын үед люминал нас тутамд 0,01-ээр, седуксин нас тутамд 0,1-ээр физиологийн уусмалаар шингэлж судсанд юмуу булчинд тарина. Мөн проперидолыг 0,15—0,2 мл-ыг биеийн жингийн 1 кг тутамд бодож тарина. Хэрэв дээрх эмүүд үр дүн муутай байвал ГОМК 100 мг 1 кг жинд 10% глюкозтой судсанд, дуслаар ч тарьж болно. Эсвэл нугасны ус авна. Хүүхдийг аль болохоор тайван байлгахыг хичээх хэрэгтэй.

Хэт халуурах нь захын, төвийн холимог хэлбэрээр тохиолддог бөгөөд авах арга хэмжээ нь ялгаатай тул юуны өмнө хэт их халуурахын эсрэг эмчилгээ хийх нь чухал. Үүний тулд өвчтөний арьсны ба шулуун гэдэсний халууныг хэмжинэ. Хэвийн тохиолдолд арьсны халуунаас шулуун гэдэсний халуун нь 0,5°C-аас 1 градусаар их байдаг бөгөөд хэт их халуурах үед энэ харьцаа алдагдана. Шулуун гэдэсний ба арьсны халууны зөрөө багасах нь арьсны цусны эргэлт хямарсаны буюу захын судас нарийссанаас болж бие махбодын дулаан дамжуулах процесс алдагдсаныг нотолж байгаа тул үүнийг захын халууралт (цайрах халууралт) гэнэ. Энэ үед захын судсыг өргөсгөх дигабазол, эуфиллин, микроциркуляцыг сайжруулах гепарин, эписилон-капроновын хүчил, аминазин гэх мэт эм хэрэглэх буюу спиртийн арчилт хийх арга хэрэглэнэ. Захын гаралтай халууралтын үед механик эрчимт эмчилгээ хийх нь захын судсыг улам агщааж дулаан дамжуулах процессыг алдагдуулж хэт халуурах нь ихеэж улмаар бодисын солилцооны хямралыг даамжруулна. Хэрэв шулуун гэдэсний ба арьсны халууны зөрөө хэвийн хэмжээнээс ихэссэн байвал төвийн гаралтай (улайрах халууралт) гэж үзэж бие махбодын дулаан үүсэх процесс төв мэдрэлийн системийн цочирлоос болж алдагдаж хэвийн хэмжээнээс ихэссэн гэж үзэж дулаан зохицуулгын тэвд үйтчлэх,

аналгин, аминазин, амидоприны уусмалыг тохирох тунгаар тарихаас гадна механик хөргөлтийн аргыг хэрэглэнэ. Тархины хавагнাশлыг арилгахын тулд өтгөрүүлсэн сийвэнг 50—30 мл 10%-ийн глюкоз инсулинтэй, манитол (0,5 г-ийг кг биеийн жинд) лазикс (2—3 мг 1 кг) альбумин зэргийг судсанд тарих буюу диакарбыг 1 кг биеийн жинд 5—6 мг-аар бодож уулгана.

10. Зүрхний үйл ажиллагааны цочмог дутагдлын үед зурхний глюкозидыг хэрэглэнэ. 0,05% строфантины уусмалыг хүүхдийн биеийн 1 кг-д 0,01-ээс 0,015 эсвэл 0,06%-ийн коргликоныг биеийн 1 кг тутамд 0,015—0,02 мл-ээр бодож глюкозын уусмалтай хольж венийн судсанд аажим тарина. Глюкозид хэрэглэж байгаа үед тун ихдэж хордлогод орох, калийн давс дутагдах зэргээс сэргийлж калийн бэлдмэл уулгах буюу панангиныг хоногт биеийн жигийн нэг 1 кг-д 0,5—1 мл уулгах буюу тарина. Судасны цочмог дутагдлын үед цусны хэмжээг тохируулах зорилгоор сийвэн, түүний срлох шингэн, альбумин хийсний дараа 10—20%-ийн глюкозыг олон ионт уусмал, мөн рингер, физиологийн уусмал зэргийг хүүхдийн биеийн 1 кг-д 10—15 мл-ээр тооцож венийн судсанд дуслаар тарина. Зүрх судасны дутагдал хавсарсан үед артерийн даралтыг ихэсгэж хордлого арилгах, эрдсийн тэнцвэрт байдлыг хангах зорилгоор тайвшруулах хольцыг хэрэглэнэ. Мөн төвийн венийн даралт, артерийн даралт зурхний агшилтын тоо цусны зуурмаг, эргэлдэх цусны хэмжээний ёөрчлөлт зэрэг зурхний дутагдлыг ялгавартай сисшлж эмчлэх нь практикийн ач холбогдолтой.

11. Амьсгал зогсох, түүний хэм алдагдах, амьсгалд туслах булчин хүчтэй оролцож зурхний цохилт түргэсч тайван бус болох, татах, хөхрөх, ухаан алдах шинж илэрвэл зохиомол амьсгал хийнэ.

12. Цочмог бронхитын үед хам шинжийг зөв оношлож түүний дагуу арга хэмжээ авч чадвал уушгины үрэвсэл үүсээгүй үед 70% хуртэл антибиотикгүй эмчилж болно. [2].

Дараах тохиолдолд антибиотик хэрэглэнэ. Үүнд:

- Хүүхдийн нас бага, биеийн байдал хүнд, уушгины үрэвслээс ялгаж танихад бэрхтэй байвал,
- 3-аас дээш хоног халуурсан, хордлого ихтэй, тархины гипоксийн шинжтэй байвал.
- Уушгины үрэвсэл байгаа нь эргэлзээтэй байвал
- Дутуу төрсөн, ихэр хүүхэд, рисктэй тохиолдолд
- Бие сүлтай, суурь өвчтэй байвал
- Бие махбодод архаг үрэвслийн голомттой байвал

Уушгины үрэвсэлгүй бронхиттой хүүхэд бүрт антибиотик үр ашиггүй хэрэглэдэг буруу практикийг хянан үзэх нь зүйтэй. Илэрч буй эмнэлзүйн шинж, анамнэз, цусны ерөнхий шинжилгээ, гэрлийн шинжилгээ, бодит узлэгээр (тогших, чагнах) илэрч байгаа ёөрчлөлтөнд тулгуурлан уушгины үрэвслийг гуурс-мөгөөрсөн хоолойн үрэвслээс ялган оношлох боломжийг сайн ашиглавал зохино.

АШИГЛАСАН ХЭВЛЭЛ

1. Т. Н. Никонова. Пневмония у детей раннего возраста. Алма-Ата „Казахстан“ 1984.
2. В. К. Таточеко, С.В. Рачинский, О. А. Споров. Острые заболевания органов дыхания у детей Москва. 1981.

МЭДРЭЛИЙН ЭС

· Мэдрэлийн эс нь бусад эсийн адил бүрэлдэхүүн хэсэгтэй бөгөөд ген, биохимийн аппарат, бүтэц, зохион байгуулалтаараа өөр ямар ч эстэй адилгүй онцлог шинжтэй.

Хүннэхийн уураг тархийг 10^{11} мэдрэлийн эсээс бүтдэг гэж үздэг бол ойролцоогоор манай галактикт мөн төдий тооны од байна гэсэн тооцоодол байдаг.

Зөвхөн мэдрэлийн хоёр эсийг л харьцуулахад бүтэц үйл ажиллагаа нь яг адилгүй байдаг ба тэдгээрийн хэлбэрийг зарим бүтцийн онцлогоор нь гурван хэсэгт хуваадаг. Тэр нь, мэдрэлийн эсийн их бие, болино, урт сэргэнгүүд юм. Мэдрэлийн эс нь биё гүйцэн амьтдад солигдож өөрчлөгдөхгүй насан туршид нь хадгалагдана. Энэ нь мэдрэлийн эсийн хэсгүүдийг дахин сэргээж байх механизмыг зайлшгүй шаарддаг. Иймд эс нь фермент болон бусад нийлмэл молекулыг нийлэгжүүлэх ба тэр нь зөвхөн эсийн бөөм орчим, мэдрэлийн эсийн их биед явагдана.

Мэдрэлийн эсийн урт сэргэнд цэлцэгнүүр маягийн шингэн-аксоплазм байдаг. Энэ нь мэдрэлийн эсийн их бие түүний урт сэргэнгийн хооронд молекулын хөдөлгөөн хийх гол зам болж, уураг болон бусад бүрэлдэхүүн хэсгүүдийг дамжуулдаг. Мэдрэлийн сэрэл богино сэргэнгээр дамжин эсийн их биед очоод урт сэргэнгээр гадагшлах чиглэлээр явна.

Мэдрэлийн эс нь нэгээс нөгөөд синапсаар (эвцэл) мэдээллийг дамжуулдаг. Мэдрэлийн нэг эс нь 1000-аас 100000 хүртэл синаптай байж болох бөгөөд бусад 1000 мэдрэлийн эсээс мэдээллийг дамжуулах чадвартай. Синапсаар мэдээлэл дамжихдаа цахилгаан ба химийн хоёр дохиотой байна.

Нэг эсийн урт сэргэн нөгөө эсийн богино сэргэнд холбогдсон уулзвар газарт синапс үүсгэнэ. Мөн урт сэргэнгүүд, богино сэргэнгүүдийн хооронд, урт сэргэн эсийн их биетэй холбогдох синапс холбоо байдаг.

Синапс нь хоёр хэсгээс тогтоно. Үүнд: Урт сэргэнгийн төгсгөлд орших булцуу хэлбэрийн өргөсөлтэй хэсэг нь синапсийн өмнөх мембранаар тусгаарлагддаг. Нөгөө мэдрэлийн эсийн хүлээн авагч (рецептор) хэсэг нь синапсийн дараах мембранаар зааглагддаг. Энэ хоёр мембранны хооронд 200 ангстрем (сантиเมตรийг 200 сая хуваасны нэг нь, нэг ангстрем) зайд байгааг „синапсийн завсар“ гэнэ. Урт сэргэнгийн төгсгөл дэх булцуу хэлбэрийн зүйлийг „синапсийн цэврүү“ гэх ба 1000 орчим синапсийн цэврүү нэг ийм төгсгөлд оршдог.

Синапсийн цэврүү бүр 10000—100000 медиаторын молекулыг агуулдаг. Медиатор нь мэдрэлийн эсийн цахилгаан байдлыг өөрчилж, сэрэлтархалтыг ихэсгэх, баагасгах нөхцөлийг бурдуулдэг. Мэдрэлийн сэрэлүүсэхэд урт сэргээнгийн төгсгөлөөс „синапсийн завсарт“ олон тооны медиаторын молекул чөлөөлгөдөн ирдэг.

Медиаторын молекул нь синапсийн завсардах шингэнд орж ирснээр синапсийн дараах мембранны рецептортой харилцан үйлчилдэг. Эдгээр рецептор нь эсийн мембранд живсэн шингэсэн ургийн том молекуулуд юм.

Энэ бүх тохиолдолд рецепторын физиологийн өвөрмөц урвалд орж, медиаторын молекулын бүтцээр мэдээлэл дамжуулна. Медиато-

рууд нь үндсэн 2 рецептортой. Түргэн үйлчилдэг рецептор нь мэдээлэл дамжуулахыг нөхцөлдүүлж, эсийн мембрани ионы сувээр нэвтрэх чанарыг зохицуулдаг. Удаан нь хоёрдогч зохицуулагчийн үүргийг гүйцэтгэдэг. Mash сүл дохиогоор медиаторууд рецептортой харилцан үйлчилсний дүнд (циклатенозинмонофосфат) цАМФ-ийн үүсгэлүүд идэвхжин хүчтэй болдог. Ингэснээр цАМФ нь эсийн биохимиийн аппаратад үйлчилж, өгөгдсөн медиаторт физиологийн урвал өгнө. Олонхи медиатор хоёр болон түүнээс дээш рецепторын хэлбэртэй.

Медиаторын молекул нь зөвхөн өөрийн рецептортай холбогдож түргэн идэвхжих шаардлагатай бөгөөд үүнийг хянах системтэй. Синапсийн дараах мембрани өөрийн тайвны потенциалаа миллисекундыг хэд хувасан хугацаанд сэргээдэг. Энэ үед секундэд мэдрэлийн ширхэг хэдэн зуун сэргийг дамжуулах чадвартай юм.

Синапсийн завсарт зарим медиаторууд ферментүүдийг идэвхгүй болгодог. Жишээ нь: ацетилхолин-ацетилхолинэстраза ферментийг задлахдаа секундэд 25000 медиаторын молекулыг задалдаг.

Синапст норадреналин нь өөр механизмаар идэвхгүй болдог. Мэдрэлийн урт сэргээнгийн төгсгөлөөс ялгарч байгаа норадреналин эргээд энэ төгсгөлдөө шингэдэг. Ингэснээр катехол-о-метилтрансфераза (КОМТ) баmonoаминоксидаз (МАО) ферментийг задалдаг. Эсвэл синапсийн цэврүүнд буцаж ирнэ. Бусад медиаторууд-дофамин, серотонин ба ГАМК зэрэгт зориулагдан сүүлийн механизмыг нь буцаж цуглардаг. Ферментийг задлаад буцаж нь медиаторын мелекулын нэлээд хэдэн эргэлтийн турш хадгалагдан ялгарна.

Сүүн тэжээлтний мэдрэхийн системийг судалж үзсэн Д. Хьюбел, Т. Визель нарын бичсэнээр зэргэлдээ мэдрэлийн эсийн хооронд санаанд орохооргүй чухал ялгаа гарсан байна. Энэ баримттай холбоотой мэдрэлийн эс нь бие биеэсээ хамаарахгүй, бие даасан шинжтэй юу, эс хоорондын синапс холбоо нь өөр эсэд давтагдахгүй юу гэсэн асуудал зүй ёсоор тавигдана.

Физиологч нар сээр нуруугүй амьтны тодорхой ғэсүүдтэй харьцуулан судалж үнэхээр мэдрэлийн эс нь ямагт нэг янзын, мөн нэг хэлбэрээр бусад эстэй холбоо үүсгэдэг болох нь тодорчээ. Энэ нь зөвхөн эс хоорондын холбоонд байгаа онцлог төдийгүй, сэрэл саатлын ажиллагаанд мэдрэлийн нэг эс нөгөөгөөсөө ялгагдах „тэмдэг“ нь болж байна.

Энэ асуудлыг ул суурьтай судлах нь мэдрэлийн өсүүдийн „ялгах тэмдэг“ нь химийн ямар процесст болж байгааг тогтооно. Энэ нь их бэрхшээлтэй асуудал юм.

Гэвч энэ талаар 60-аад оны үед багагүй амжилт олсон байна. Энэ нь тархины эдийг сахорозын уусмалд хийж нэг төрлийн бодис гаргаж задлан „тусгаарласан мэдрэлийн эсийг“ гаргасан нь нейрохимичдэд синапсийн дамжуулах механизмыг хуруун шилэнд судлах боломжийг нээжээ. Тэдний нотолсноор медиатор нь тархины бүх эдэд нэвчин тархахгүй. Харин хязгаарлагдсан төв замуудад байрладаг гэжээ.

Медиаторууд нь тархины эсэд хуваарилагдаадаа мэдрэлийн эсийн онцлог хэсгүүдэд байрлан, тархины дээд төрөлжсөн хэсгүүдтэй урт сэргэнгүүдээр дамжин холбогддог. Одоогоор медиаторын төрлийн 30 орчим бодис мэдэгдээд байна.

Бүх медиатор нь нэг амингрuppээс бурддэг monoаминууд гэж нэрлэгдэх-норадреналин, дофамин, серотонин зэрэг нь нэлээд судлагдсан медиатор иж. Дээрх медиаторуудад формальдегид буюу глиоксилын хүчлээр үйлчлэхэд тэдгээр нь задрахдаа флуоресценц (гэрэлтэх үзэгдэл) ногоон буюу шар өнгийг өгч байв. Энэ ажиглалтаар тархины багана хэсэгт норадреналины эсийн хуримтлал их байгааг тодорхойлсон.

Энэ медиаторыг агуулсан мэдрэлийн эсийн урт сэргэнгүүд өмнөд тархи, гипоталамусын янз бүрийн хэсэгт их салаалжээ.

Сэргэлэн цовоо байдал, нойрсох, сэтгэл хөдлөл зэргийг мэдрэлийн эсийн норадреналин зохицуулдаг. Мэдрэлийн эсийн монааминофамины бүрэлдэхүүнтэй бүлэг эс, дунд тархинд хуримтлагдсаныг тогтоожээ. Сэтгэл хөдлөлийн урвалыг зохицуулахад хуралдсан бүлэг эсээс урт сэргэнгээр дофамин илгээгддэг. Дофамины өөр ширхгүүд стриатумын орчимд төгсдөг. Энд дофамин нийлмэл хөдөлгөөнийг зохицуулахад гол үүрэг гүйцэтгэдэг байна.

Энэ хэсгийн дофамины ширхэгт өөрчлөлт ороход шилэн хүзүүний булчин татах, салгалах зэрэг паркинсоны өвчний тодорхой шинжүүд илэрдэг. Сүүлийн үеийн мэдээгээр шизофрени өвчин нь дофамины илүүдэл хуримтлалаас буюу тархины тодорхой хэсэгт медиаторын хэтэрсэн урвалж чанар үүссэнээс болж байна гэжээ. Өөр нэг медиатор болох монаамин, серотонин нь тархины багана хэсэгт хуралддагийг тодорхойлжээ.

Серотониныг агуулсан мэдрэлийн эсийн энэ төв нь гипоталамус, таламус болон бусад олон хэсэгтэй холбогдсон дулаан зохицуулах, ойлгон мэдрэх, нойрсох зэрэгт оролцдог. Жишээ нь:

Глутамин ба аспаргин ихэнх мэдрэлийн эсэд сэрлийн үйлчилгээ үзүүлж байхад глицин нь нугасанд саатуулах медиатор болдог. Гэтэл уургийн бүрэлдэхүүнд ордоггүй ГАМК (гамма-амин-маслын хүчил) нь тархины эсийн хоорондох сэрлийн процессыг саатуулснаар тайвшируулах нөлөө үзүүлдэг медиаторын үүргийг гүйцэтгэнэ. Тооцоолсон баримтаас үзэхэд тархины гуравдагч синапс бүр ГАМК-медиаторыг хэрэглэдэг байна.

ГАМК-медиатороос химийн нэг группээр ялгагддаг глутамины хүчил сэргээх нөлөө үзүүлж байгаа нь медиаторуудын молекул бүтцийн энэ ялимгүй ялгаа маш олон янзын физиологийн үйлийг нөхцөлдүүлж болохыг харуулж байна. Нейрохимичид янз бүрийн медиатор тархины эсүүдэд хуваарилагдах молекулын бүтцийг тайлбарлаад зогсогч, синапсийн дамжуулалтанд оролцдог биохимийн процессын дүнд чухам юу үүсч буйг тогтооход их амжилт олж байна.

Олонх нейробиологуудын үзэж байгаагаар хүн бүрийн мэдрэх, бодох, санах чадварыг мэдрэлийн эсүүд холбогддог синапсийн торлосон холбооны нарийн зохион байгуулалттай, ажиллагаагаар тайлбарлах болов.

Орчин үед нейробиологийн шинжлэх ухааны (нейроанатом, нейрофизиолог, нейрохими, нейропсихолог) салбарууд нь мэдрэлийн эсийн нарийн бүтэц, үйл ажиллагааг улам гүнзгийрүүлэн тодруулсаар байна.

Эрдэм шинжилгээний ажилтан Б. БОЛДСАЙХАН

АШИГЛАСАН ХЭВЛЭЛ

1. П. Г. Костюк, О. А. Крышталь. Механизмы электрической возбудимости нервной клетки. М. 1981.
2. Д. Хьюбел, Ч. Стигенти др. Мозг. М. 1982.
3. Д. Ж. Шаде, Д. Форд. Основы неврологии М. 1976.

ПАНКИПСИНЫГ НАЙРУУЛАН БЭЛТГЭХ, ХЭРЭГЛЭХ

Мах комбинатын Энзимологи, микробиологийн үйлдвэрлэл, туршлага шинжилгээний төвийн үйлдвэрлэсэн „ПАНКИПСИН“ нь тулэнхий, идээт шархыг анагаах зориулалттай фермент юм. Харин маш бага тунгаар хэрэглэдэг.

Гэтэл үйлдвэрээс эмчилгээний 100—200 тунг нэг шилэнд савласан нь практикт нэг удаа хэрэглэхэд ферментийн ариун чанар алдагдаж улмаар хорогдол үрэгдэл гарах явдал их байна. Ийм учраас панкисиниг эмийн сан, эмнэлэг урьдчилан сэргийлэх байгууллага бүрт эмчилгээнд бүрэн хэрэглэж чадахгүй байна.

Ийнхүү панкисини жорыг найруулан бэлтгэх, хэрэглэх аргачлагыг гаргав.

НЭГ. ҮНЭ, САВЛАХ

Нэг шил панкисин нь 5 грамм бөгөөд 810 төгрөгийн үнэтэй. ЗХУ-д үйлдвэрлэсэн трипсин, химеотрипсин 5 грамм нь 2000 төгрөг бөгөөд манай үйлдвэрийн панкисин нь 2,4 дахин хямд байна. Тодруулбал ЗХУ-ын 10 мг химеотрипсин 4 төгрөгийн үнэтэй байхад панкисин 10 мг нь 1 төгрөг 62 мөнгө байна.

Энэ нь үнэ ихтэй гэдэг дутмаг ойлголтын буруу болохыг нотолж байгаа юм.

Эмийн санд 5 грамм панкисиниг эмчилгээний тунд шилжүүлэхдээ дараах журмыг баримтлана. Үүнд:

1. 100—200 ширхэг пенициллиний шил, бөглөөг шил угаах технологийн дагуу угааж, хатаах шүүгээнд хуурай болтол ариутгаж хатаана. Хэрэв шилний дотор талд чийгтэй байвал панкисин нь бөөгнөрч улмаар чанараа алдана.

2. Дараа нь тарилгын уусмал бэлтгэх өрөөнд буюу асептик нөхцөлд 25—50 мг-аар (0,025 0,05) түгнан 100—200 ширхэг ариутгасан пенициллиний хуурай шилэнд савлана. Шилний амыг пергаментын цаасаар даруулж боноо:

3. Савласан панкисини сигнатурт тухайн савласан панкисини серийн дугаар, хадгалах хугацаа, тун савласан сар өдөр, савласан найруулагчийн хувийн дугаар зэргийг бичиж хөргөгчийн хамгийн доод хэсэгт хадгална.

Панкисиниг эмчилгээний нэг удаагийн тунгаар савласнаар ферментийн ариун чанар алдагдах, хорогдол гарагчийн байх сайн талтай юм.

ХӨӨР. ХЭРЭГЛЭХ АРГА.

ЗХУ-д трипсин, химеотрипсинаар гадуур буюу судсаар тарьж хэрэглэхээр үйлдвэрлэдэг. Манай үйлдвэрийн панкисин нь зөвхөн гадуур хэрэглэхэд зориулагдсан байдгийг анхаарах хэрэгтэй.

Панкисиний цацах, угаах, утах зэрэг 3 аргаар хэрэглэнэ.

1. Цацаж хэрэглэх. Нэг удаагийн тун нь 10, 25, 50 мг (0.01 0,025 0.05) бөгөөд энэ нь шархны идээ. үхжлийн их, бага байгаагаас шалтгаална. Хуурайгаар цацахын өмнө шархыг цэвэрлээд панкисиниг жигд маш нимгэн цацна. Хэрэв шилэндээ бөөгнөрсөн байвал ариутгасан марль дээр цацаж няцлан сайтар нунтаг болгосны дараа шархандаа цацах буюу эм бүхий марлиа тавьж боноо.

2. Угааж хэрэглэхэд 25—50 мг панкисинийг 0.9%-ын натрийн хлоридын ариун уусмалд уусгаад гуурсаар шприцын тусламжтайгаар угаах ба эсвэл ариутгасан тампонд шингээгээд шархны гүн хэсэгт чихээс хийнэ. Чихээс хийхийн өмнө уг уусмалаар шархыг хэд дахин угаанаа. Харин угаах уусмалын эзлэхүүн нь шархны идээний их, багаас шалтгаалан 10—100 мл хүртэл янз бүр байна.

3. Уталганд хэрэглэх панкисинийг 10 мл 0,9%-ийн натрийн хлоридын уусмалд уусганаа. Уг уусмалыг уушгини цагаан мөгөөрсөн хоолойг дурандах дуран, уталгын аппаратын тусламжтайг аар утна.

Энэ аргаар өтгөн цэрийг шинжэрүүлэх, ховхлох зорилгоор мэс заслын дараа сэхээн амьдруулах практикт хэрэглэхэд тохиромжтой.

ГУРАВ. Жорыг найруулан бэлтгэх технологи

Панкисиныг уусмал, нунтаг, тосон түрхэц хэлбэрээр хэрэглэнэ. Эдгээр хэлбэрийн жорыг бичих журам, найруулан бэлтгэх технологийг тус бүрээр нь тайлбарлай.

| | |
|--------------------------|------|
| ЖОР №1 <i>Pancupsini</i> | 0.05 |
| <i>Anaesthesini</i> | 1,0 |
| <i>ol. Yaselini</i> | 3,0 |
| <i>Janolini</i> | 6,5 |
| <i>Aquaes destill</i> | 10,0 |
| <i>M. f. Ing.</i> | |

S түлэнхий, идээт шарханд өдөрт 1 удаа түрхэж хэрэглэнэ.

Энзимологи, микробиологийн үйлдвэрлэл шинжилгээний институттээ гаргасан зааварт панкисины тун, найруулан бэлтгэх технологийг буруу тооцсоныг энэ жоронд залруулан гаргав.

Эхлээд анестезин 1 граммыг хэмжиж аваад ууранд хийж нунтаглаад дээр нь 3 грамм шингэн вазелиныг бага багаар хийж анестезиньг уустал нухна. Мөн 50 мг панкисиныг 5 мл усанд уусгана. Уусгах үед хөөсрөх ба шилэн савхаар уустал нь хутгана. Дараа нь 6,5 грамм ланолиньг өөр нэгэн ууранд хийж панкисин уусгасан уусмалаас бага багаар хийж хутгуураар нэг тийш нь эргүүлэн хутгаж ланолинь суурийг гаргаж авна.

Ланолины суурь дээр анестезин уусгасан шингэн тосыг бага багаар хийж нэг төрлийн болтол хутгана. Хамгийн сүүлд үлдсэн 5 мл нэрмэл усаар панкисин уусгасан цилиндрээ зайлж зайлсан нэрмэл усыг бага багаар шингэтэл нь нэг тийш нь хутгана. Үүний эцэст шаргал өнгийн өтгөвөр тосон түрхэц үүснэ.

Хүрэн өнгийн шилэн банканд буюу пергаментын цаасанд боож олгоно. Тосон түрхцийг сэргүүн газар юм уу хөргөгчид хадгална. Тосон түрхцийг өдөр бүр дахин давтан хэрэглэхийн өмнө шархыг сайтар цэвэрлэсэн байх хэрэгтэй. Энэ тосон түрхэц нь нунтаг, уусмал байдлаар хэрэглэснээс илүү үр дүнтэй бөгөөд удаан хугацаагаар хадгалах, хэрэглэхэд чанараа алдахгүй байна.

ЖОР №2 *Ing Pancupsini*

0,25%—100,0

S. Идээт шарханд түрхэж хэрэглэнэ.

Үүнд ланолин, нэрмэл ус тус бүрийг тэнцүү хэмжээгээр авч (ланолин 50 гр, нэрмэл ус 50 мл) жор №1-ийн найруулан бэлтгэх технологийг баримтлана. Харин зууратгай чанарыг багасгахын тулд шингэн вазелин, загасан тосны аль нэгнээс бага зэргийг хийнэ.

ЖОР №3 *Sol Natrii chloridi*

0,9%—10,0

Pancupsini 0,025 (0,05)

S. Хамрын хөндийн идээт үрэвсэл-ясны идээт үрэвсэл, отгөрсөн ногоон цэрийг ховхлох, шингэлэх зэрэгт өдөрт 1 удаа угааж хэрэглэнэ.

Жорыг бэлтгэхдээ натрийн хлоридын 0,9%-ын 10 мл уусмалд панкисиныг уусгана. Уусмалыг шүүхгүй, сэргүүн газар хадгална. Уусмал нь цэхэр өнгөтэй байх бөгөөд хэрэглэхийн өмнө зайлна. Фермент нь усан уусмалд тогтворт мутай, чанараа амархан алддаг учир 3 хоногоос илүү хугацаагаар хадгалахыг хориглоно.

ЖОР №4 *Pancupsini* 0,025 (0,05)

D. t. d. №5 fl

S. Идээт шарханд цацаж хэрэглэнэ.

Уг жорыг асептик нөхцөлд урьдчилан савласнаас шууд бэлнээр олгоно. Уг жорыг уусмалаар хэрэглэх шаардлага тохиолдвол хамрын хөндий, нулимсны цорго угаахад 0,9%-ын натрийн хлоридын 10 мл уусмал хийж уусгаад хэрэглэж болно. Харин ил шарханд хэрэглэх бол 09%-ын натрийн хлоридын ариун уусмалаар найруулах нь зүйтэй.

Панкипсинаы жорыг дээр дурдсан байдлаар бичихээс гадна өвчтөнд антибиотикийн мэдрэг чанарыг тодорхойлсны дараа мэдрэмтгий антибиотикийн хамт хэрэглэх нь үр дүнтэй байна. Иймд эмч нар жорыг өөрчлөн бичиж болох бөгөөд панкипсина тун, орцын хэмжээг тооцож бичихээ мартуузай!

ДӨРӨВ. ХЭРЭГЛЭХ ҮЕД АНХААРАХ ЗҮЙЛ

1. Зөвхөн гадуур хэрэглэнэ.
2. Хэвллийн хөндийн гүн шарханд хэрэглэхэд тохиромжгүй.
3. Хэрэглэхийн өмнө шархыг сайтар цэвэрлэх шаардлагатай.
4. Цусны судсанд ойролцоо шарханд хэрэглэж болохгүй.
5. Панкипсийн нь онцгой наалдамтгай учир цацаж хэрэглэхэд бөөн бөөнөөөр унаж шархнаас цус алдах, тулэх зэрэг хүндрэл өгч болно. Иймд энэ үед маш болоомжтой хэрэглэх хэрэгтэй.

6. Панкипсинаыг хэрэглэж байх үед бага зэрэг цус гарах, хорсох, улайлх зэрэг шинж илрэх бөгөөд тун хэтэрвэл дээрх гаж нөлөөнүүд нэмэгдэж болно. Энэ үед хэрэглэхийг зогсоо буюу тунг багасгах хэрэгтэй.

Эм зүйч Б. НИНА

УРГИЙН УСНЫ ЭМБОЛИ

Эх барихын практикт өвчтөнийг шокод оруулдаг нэн аюултай шалтгааны нэг нь ургийн усны эмболи юм. Энэ өвчиний тухай анх 1926 онд Meusech бичжээ. Залуу эмэгтэй төрөхийн улмаас гэнэт нас барж задлан шинжилгээ хийхэд уушгины судаснаас ургийн гаралтай органик бодис олджээ. 1947 онд Steiner, Lushbangh нар ургийн усны эмболи болж эндсэн 8 эхийн тухай тодорхой бичээд, энэ өвчинийг бие даасан өвчин хэмээн үзжээ. Уг өвчин маш ховор буюу 1400—3700 төрөлтөнд 1 удаа тохиолдоно.

Ургийн усны эмболи өвчин маш цочмог эхлэнэ. Ихэвчлэн төрөлтийн I, II үед олон тохиолдох бөгөөд харин төрөлтийн III үе, төрсний дараах үед ховор тохиолдоно. Ургийн ус эхийн цусанд орж судас бөглөрөхөд дараах шинж тэмдэг илэрнэ. Үүнд: даарсан мэт чичирч дагжих, хүчтэй хөлрөх, нэн цочромтгой болох, ханиах, бөөлжих, татах гэх мэт шинж эхлэн мэдэгднэ. Дараа нь өвчиний үндсэн шинж болох өвчүүний цаана хүчтэй өвдөх, арьс хөхрөх, зүрх судасны цочмог дутагдал үүсэх, цус алдах, ухаан алдах гэх мэт шинж илэрнэ. Төвийн венийн даралт хэт ихсэж, зүрхний баруун хэсэгт цусны зогсонги байдал үүссэнээр согримонale-гийн шинж тэмдэг илэрч хүзүүний венийн судсууд чинэрч, цусны бага эргэлтэд зогсонги үүснэ. Эдгээр шинж нь уушгины arterийн судас ургийн усаар бөглөрч улмаар уушгины гаралтай даралт ихсэх, цочмог согримонale ба зүрхний баруун ховдлын дутагдалд орсныг гэрчилнэ. Зүрхний зүүн ховдолд орох цусны хэмжээ хомсдсоноос минутын эзлэхүүн багасаж шок үүснэ.

Хэрэв шокийг өвчтөн давж чадвал дараагийн 30 минут, зарим тохиолдолд 8—9 цагийн дараа цус бүлэгнэлтийн хямрал гарна. Энэ өөрчлөлт ихэвчлэн умайн хөндийг чөлөөлж, цэвэрлэсний дараа умайн

агшилтын суралтай хосолж гардаг. Ургийн усны эмболи өвчний энэ шатанд буйлнаас болон зүү хатгасан газраас цус гоожихын чацуу биенц цус хуралтын толбууд үүснэ.

Нэлээд тохиолдолд зүрхний хэм алдагдах, цус алдалтын шокоос өвчтөн 2—4 цагийн дотор нас барна.

Ийнхүү ургийн эмболийн үед судсуудад цус түгээмлээр бүлэгнэхийн механизм нь зүрх судасны дутагдал, хүчилтөрөгчийн дутмагшил, гемостазын тогтолцоонд ургийн усны тромбопластин нөлөөлсөнтэй холбоотой.

Энэ үед цус бүлэгнэлтийн хүчин зүйлс, эсүүдийн идэвхжил хурдсан их хэмжээний тромбин богино хугацаанд үүсэж фибриноген фибринд шилжинэ. Ингэж амин чухал эрхтэнүүдийн цусны фибринжих процесс нь хүчилтөрөгчийн дутмагшил, шокийн байдлыг улам гүнзгийрүүлнэ. Фибрин-фибриногенийг саармагжуулах бүтээгдэхүүний концентрац ихсэх нь фибриний нөх олшрох дарааллыг алдагдуулж тромбоцитийн агрегацаах (наалдах) чадавхийг бууруулна. Судсанд тромбоцит агрегацаах нь багасах, тромбоцитопати болох нь цус архаг эмзэгшил үүсэх нэн хүчтэй хүчин зүйлс мөн. Ил шарханд цус бүлэгнэх, коагулопати, тромбоцитопати үүсэх нь цус алдах, шокт орох өвчтөнг үхэлд хүргэх шалтгаан юм.

Маш нарийвчилсан аутопсийн шинжилгээгээр ургийн ус эхийн цусны урсгалд орсон замыг тогтооно. Ихэнх тохиолдолд эхэс ургийн ус нэвтрэх үүд хаалга болно. Ийм тохиолдол умай урагдах, эхэс түрүүлэх, уртаж ховхрох, заримдаа кесарев огтловын үед гарч болно. Ургийн ус эрг гарах болон төрөх хүч хямартсан үед умайн хүзүүний сувгийн венийн судасны бүтэн байдал өөрчлөгдөх нь эмболи үүсэх хүчин зүйлс болдог. Сав хэт хүчтэй базлах, окситоцины төрлийн эмэр төрөлтийг сэдээх, ургийн усанд зунгаг гарах, амниоцентез, ихэр ураг тээсэн, ураг эхийн хэвлэйд эндэх зэрэг нь ургийн усаар бөглөрөхөд хүргэж болох хүчин зүйл юм.

Ургийн усаар бөглөрөх хүндрэлийг умай урагдах, уушгини артерийн тромбоэмболи, манас таталт, ихэс уртаж ховхрох, цус их алдсанаас үүсэх шок, Мендельсоны хам шинж, зүрхний бүлчингийн шигдээс, үжлийн гаралтай шок, эмийн харшил, тос, хийн эмболи зэргээс ялгаж оношлоно.

Гагцхүү өвчний эмнэл зүйг нягтлан судалж, эмгэг-физиологийн өөрчлөлтөнд бодит үнэлгээ өгсний үндсэн дээр уг өвчинг оношлоно. Чээжийг гэрлээр шинжлэх, гемостазийн тогтолцооны өөрчлөлтөнд динамик үнэлгээ зайлшгүй өгнө.

Ургийн ус нь эмболийн үед туслах чанарын шинжилгээ, эрчимт эмчилгээг үр дүнтэй болгохын гол сурвалж бол гемостазийн тогтолцоог шинжлэх арга юм.

Ургийн усны эмболийн эмнэл зүйн эхний шинж идрэх мөчид гемостазийн тогтолцоог нарийвчлан шинжилж, гиперкоагуляци, тромбоцитын гиперагергаци, цус түгээмлээр бүлэгнэх хам шинжийн нэгдүгээр үеийг илрүүлж болно. Цусны бүлэгнэлтийн хугацааг Ли-Уайтын аргаар тодорхойлоход эсвэл богиноссон (5 минутаас бага) эсвэл нормдоо (5-10 минут), фибриногены төвшин (цусны бүлэгнэлтийн үндсэн субстрат) нэлээд ихэссэн (450мг %-иас их), тромбопластины хугацааны идэвхижил богиносох (25 секундээс бага) буюу VII ба XIII хүчин зүйлээс бусад цусны бүлэгнэлтийн үндсэн хүчин зүйлсийн байдлыг харуулна. Энэ үед чанарын сорилт тухайлбал этанол, протамин сульфатын сорил эзэрэг гарах нь цус түгээмлээр бүлэгнэхийн хам шинж үүсч байгааг илтгэнэ.

Нэгэн зэрэг фибрин-фибриногенийг саармагжуулах бүтээгдэхүүний хэмжээ ихэснэ.

Ургийн усны эмболийн эхний шатанд антитромбин III эрс багасаж харин тробоцитын урвал үүсгэх чанар ихэнэ. Тробоэластограммд гиперкоагуляцийн шинж илэрнэ. Энэ үед цус судсуудад түгээмлээр булэгнэх хам шинж маш цочмог илрэх учраас нэгдүгээр шатанд тэр бүр танин оношлох боломж багатай.

Цус харвах эмзэгшилийн эмнэл зүйн шинж илрэхээс өмнө коллапс шок болон эдгээрийг (коллапс, шок) таслан зогсоосны дараах тодорхой хугацаанд хэрэглээний коагулопати, тромбоцитопатитай холбоотойгоор гемостазын тогтолцоонд гиокоагуляцийн үзэгдлууд гарна. Ийнхүү ургийн усны эмболийн үеийн гипокоагуляцийн шинж тэмдэг нь фибринногенеми, тромбоцитопени, тромбопластины хугацааны идэвхжил уртсах, мөн цусны булэгнэлтийн хугацаа удаашрах байдлаар илрэнэ. Энэ бүхэн цусны булэгнэлтийн ийлдэсний хүчин зүйлс, эсийн доторхи бичил нөж их хэмжээгээр хэрэгцээнд зарцуулагдсантай холбоотой юм. Ийм тохиолдолд тромбоэластограммд хронометрийн болон бүтцийн гипокоагуляцийн шинж тод гарна. Ийм нөхцөлд Равугийн аргаар „шилжүүлэх сорил“ хийхэд тромбоэластографт хэрэглээний каогулопатийг тогтоож болно.

Цус булэгнэлтийн ийлдэсний бүтцийн өөрчлөлтийн сацуу гемостазийн тогтолцооны тромбоцит ба эсийн хэсэгт эмгэг буй болно. Далд хэлбэрийн гиперкоагуляци гиперагрегацийн үед эмчилгээнд гепарин, антиагрегант хэрэглэж болно.

Хэрэглээний коагулопати, „тромбоцитопати“-ийн шатанд антитромбин III, плазминоген хэмжээ эрс багадаж, фибрин-фибриногенийг саармагжуулах бүтээгдэхүүн (нормдоо 2 мкг) мл хуртэл байдаг бол 300 мкг (мл түүнээс дээш) хэмжээ нэн ихэнэ. Энэ бүхэн нь нэн их хэмжээний бичил булэгнэлт явагдаж, бичил эргэлт блокаданд орон амин чухал эрхтэнүүдэд гэмтэл үүссэнийг гэрчилнэ.

Орчин үед фибрин-фибриногенийг саармагжуулах бүтээгдэхүүн умайн агшигад дарангуйлах үйлчилгээ үзүүлдэг болох нь хөдөлбөр-гүй нотлогджээ. Энэ нь судсуудад цус түгээмлээр булэгнэх, умайн агшилт сулрах хоёр хоорондоо холбоотойг гэрчилж байна.

Ургийн усны эмболитой өвчтөнд хэрэглээний тромбоцитопати болон коагуляпати үүсэхээс өмнө цус түгээмлээр булэгнэх хам шинжийн эмнэл зүй улам гүнзгийрч цус харвах эмзэгшилд хүргэнэ. Ийнхүү ургийн усаар бөглөрөх үед цус алдах, цус гоожих нь цус түгээмлээр булэгнэх хам шинжтэй нягт уялдсан байдаг.

Гемостазийн тогтолцоо нь фибрин уусгах хэсгийн эрс идэвхжил нь их хэмжээтэй цус алдах, түгээмлээр цус харвахын шалтгаан болно. Энэ үед фибриний нөжөөс гадна эргэлтэнд байгаа цусны булэгнэлтийн хүчин зүйлс задарч уусна.

Ийнхүү ургийн усаар бөглөрөхд гемостазийн тогтолцоонд тодорхой өөрчлөлт гарах буюу тромбо уусалтын дэс дараалсан байдал үүснэ. Үүнд: Нэгдүгээр шатанд цус түгээмлээр булэгнэх хам шинжийн гиперкоагуляц, гиперагрегаци, II шатанд хэрэглээний коагулопати-тромбоцитопати, заримдаа III шатанд СЦТБ-ийн хам шинжийн гиперфибринолиз болох өөрчлөлт тус тус гарна.

Ургийн усны эмболийн СЦТБ-ийн хам шинжийн I шатанд их хэмжээний тромбо үүснэ. Харин II ба III шатанд бичил эргэлт дэх фибриний булэгнэлт, тромбоцитын агрегацийн зэрэгцээ цус алдах, цус харвах шинж илэрнэ. Ийм нөхцөлд юуны өмнө эмчилгээг эрт эхэлснээс эмчилгээний ур дүн хамаарна. Өвчтөний бие махбодын үйл

ажиллагааны мониторийн хяналт, эмнэл зүй-лабораторийн шинжилгээний үзүүлэлтүүдэд үндэслэн эмчилгээг хийнэ.

Өвчтөний мониторийн хяналтын үзүүлэлтэнд артери, төв венийн даралт, цагт ялгарч гарах шээс, гемотокрит, гемоглобин, гемостазийн үндсэн үзүүлэлтүүд, эргэлтэнд байгаа цусны эзлэхүүн, цусны минутын эзлэхүүн, хүчилтөрэгчийн шатлуур (градиент), цусны хүчил шүлтийн байдал хамарагдана.

Эмчилгээний үндсэн зорилт нь амьсгалын дутагдалтай тэмцэх шокоос гаргах, мөн цус алдалтын хүндрэлээс сэргийлэхэд оршино. Энд хүчилтөрөгч эмчилгээ чухал үүрэг гүйцэтгэнэ. Хүчилтөрөгч эмчилгээг хийх явцдаа цусны хийн найрлага, хүчил-шүлтийн байдлыг сайтар хянана. Ингэснээр интубац тавих эсвэл өвчтөнг зохиомлоор амьсгалуулах асуудлыг зөв шийдвэрлэх боломжтой юм.

Трахейд интубаци тавихдаа: 1) уушгины амьсгалын багтаамж 15 мл/кг-аас бага байх; 2) амьсгал авах хүч 25 мөнгөн усны баганы өндөрөөс багадах, 3) хүчилтөрөгчийн парциаль даралт (Pa) маскаар хүчилтөрөгч өгч амьсгалуулахад 70 мм мө. усны баганы өндөрөөс бага байх, 4) хүчилтөрөгчөөр 100 % амьсгалуулахад альвеол-артериацлын хүчилтөрөгчийн хүчдэлийн шатлуур 350 мм мө. усны баганы өндөрөөс дээш ихэсвэл, 5) Сээзын Ра 55 мм мө, усны баганы өндөрөөс дээш байвал, 6) үхмэл зайн вентиляци ихсэх-коэффициент V_d/V_t 0,6-аас их байгаа эсэхийг тус тус харгалзана. Эмчилгээний нэг чуулитын усмал реополиглюкиний төрлийн ийлдэс орлох бэлдмэл глюкоз, хлорт кали, инсулин, туйлшрах холимгууд, хатаасан ба консерволосон ийлдэс альбулины усмал зэрэг орно. Дээрх эмчилгээтэй зэрэгцүүлж агчлыг арилгах (но-шпа, папаверин, компламин, эуфилин), зүрхний ажиллагааг сайжруулах (кордиамин, камфор, сульфокамфокайн, коргликон) бэлдмэлүүд, стероид ындааврууд (преднизолон, гидрокортизон, дексаметазон) хэрэглэнэ. Гидрокортизон эсвэл преднизолоныг заавал мегатунгаар венийн судсанд (гидрокортизон 1000 мг, преднизолон 300—400 мг) тарина. Гематокритын хэмжээ 25—30 %-иас багасвал цус сэлбэх эмчилгээ хийнэ. Шинэхэн бэлдсэн ижил бүлгийн бүлээн цус сэлбэх нь нэн ашигтай.

Шокийн эхний штанд цус алдах, цус харвахаас өмнө венийн судсанд дуслаар гепарин 500—700 нэгж тунг цагийн турш аажим тарина. Гепарини геополиглюкин глюкозтой хамт тарьж болно. Хүндрэлийн үед гепарини арьсан дор тарихын хэрэггүй. Даамжрах явцтай цус түгээмлээр бүлэгнэх хам шинж, хэрэглээний коагулопати, тромбоцитопатийн үүсэлтэй цус алдах үед цус алдахын шалтгаан болж байгаа умайг авах мэс заслыг цус сэлбэх эмчилгээтэй хослуулж хийнэ.

Тромбоцит, фибриноген, VIII, V, VII, X, XIII хүчин зүйлс, антитромбин III, плазминоген гэх мэт цусны бүлэгнэлтэнд зайлшгүй хэрэгцээтэй цусны элементүүд хомесдсон байх учраас шинэхэн бэлдсэн донорын цус цитратжуулсан цус, хөргөөж бэлдсэн ийлдэс хэрэглэх нэн ашигтай.

Шархнаас цус алдах аюултай учир умайг авах мэс ажилбар хийхээс өмнө, хойно 3—4 цагт гепарин эмчилгээ хийж болохгүй. Цаашдаа мэс заслын дараах үед ялангуяа цус сэлбэх эмчилгээ хийх явцад хэрэв шокоос бүрэн гарсан бол гепарини (цагт 500 нэгж) венийн судсанд дуслаар 10 өдөр тарьж болно. Агчил арилгах эм, бага молекултай дексстрантай хамт гепарин хэрэглэхэд эмчилгээний үр нөлөө сайжирна. Гепарин эмчилгээг гагцхүү лабораторийн шинжилгээтэй хийнэ. Цусны бүлэгнэлтийн өөрчлөлтийн хүнд хэлбэрийн үед трасилэк эсвэл контрикал 250,000—500,000 нэгжийг венийн судсанд

нэг удаа тариад цаашид цагт 100 000—200 000 нэгжийг дараачийн цагуудад дуслаар тарина.

Фибрин уусгахын эсрэг үйлчилгээтэй нийллэг Е—аминокапрон хүчлийн төрлийн эмийг эмчилгээнд хэрэглэж болохгүй. Энэ эмийн нөлөөгөөр бичил цусны эргэлтэнд үүссэн өөрчлөлт гүнзгийрч судсан дахь тромбо батжих талтай. Хэрэв шок болон гемастазийн өөрчлөлтийн хүнд үеийг давж чадвал цаашид бөөрний цочмог дутагдал идээт үжлийн хүндрэл, тархины цусны эргэлтийн алдагдал зэргээс сэргийлэх арга хэмжээг авч хэрэгжүүлнэ.

Ургийн усны эмболийн үхлийн хувь нэн өндөр (80 % хүртэл). Бие барсан эхийн цогцост шинжилгээ хийхэд голдуу зурхний баруун ховдол өргөсөх, уушгинд хаван үүсч, цус харвасан байна. Бөглөрсөн тэр хэсэгт эс эдийн шинжилгээ хийхэд ургийн арьсны хавтгай хайрс, үр хөврелийн шар үс, өөхлөгийн хэсгүүд, зүнгаг салиа илэрнэ.

Анагаах ухааны дэд эрдэмтэн Б. ЖАВ

В. Е. ЛАПУШКИН

СУРГУУЛИЙН ХҮҮХДИЙГ ОЙРЫН ХАРАЛГАН, ТҮҮНИЙ ДААМЖРАЛААС СЭРГИЙЛЭХ

ДЭХБ-ын мэдээгээр ойрын харалган нь харааны эмгэгийн дотор хамгийн өргөн тархсан хэлбэр бөгөөд сүүлийн жилүүдэд өсөх хандлагатай байна. Ойрын харалган болох түүний даамжрахад нүдний харааг тохируулах аппаратын (аккомдацийн) чадвар ба харааны ачаалал хоёрын тохироо алдагдах явдал гол болохыг зөвлөлтийн судлаачдын бүтээлүүдэд тэмдэглэсэн байна. Нүдний хараа тохируулах аппаратын чадвар сулрахад архаг халдварт өвчинөөр өвчлөх, нүдний шингэний эргэлт хямрах, хөдөлгөөн, биеийн хүчний идэвх буурах зэрэг олон хүчин зүйл нөлөөлдөг.

Иймээс сургуулийн хүүхдийг ойрын харалган болохоос урьдчилан сэргийлэхэд хөдөлгөөний идэвхийг аль болох өндөр байлгах явдал онцгой ач холбогдолтой. Үүний тулд нүдний цусан хангамж, хараа тохируулах аппаратын чадварыг сайжруулахад чиглэсэн биеийн тамирын тусгай дасгалыг сургуулийн хичээлийн явц дунд хийлгэж байх журамд оруулах нь чухал юм. (А. С. Аветисов, 1982). Ойрын харалган болохоос урьдчилан сэргийлэхийн тулд харалган болж болзошгүй хүүхдүүдийг тусгайлан ялгаж авах хэрэгтэй бөгөөд үүнд нүдний харааг зохицуулах аппаратын чадвар нь буурсан, ойрын харалган эцэг, эхээс төрсөн, хуурамч харалган, астагматизм 1,0-ээс өндөр байгаа зэрэг хүүхдүүдийг оруулна.

Ийм хүүхдүүдийг тусгай анги болгон ялгаж, хөдөлгөөний идэвх биеийн тамирын өргөтгөсөн сургалтын аргаар хичээллүүлэх хэрэгтэй юм.

Энэ хэсгийн хүүхдүүдэд ойрын харалганыг нь эмчлэх үндсэн хэрэгсэл нь хараа зохицуулах аппаратын чадварыг сайжруулах дасгалыг системтэйгээр хийлгэх явдал болно. Түүнчлэн хараа сайжруулах ээлжийн шилийг ашиглан дасгал хийлгэх нь ойрын харалган болох түүний хүндрэлээс сэргийлэхэд өндөр үр дунтэй байгааг судлаачид (Э. С. Аветисов, К. М. Мац 1971) тогтоогоод байна.

Ойрын харалган болохоос хамгаалах эдгээр арга хэмжээний үр дүн нь харааг зохицуулах аппаратын чадвар боломж сайжрах, ойрын харалганы хүндрэл удаашрах буюу зогсооор үнэлэгдэнэ.

Хараа зохицуулах аппаратын чадвар нөлөөлөх хамгийн хялбар бөгөөд гэр орны нөхцөлд хийхэд боломжтой арга бол „Хараа тохируулах дасгал“ гэж үзэж байна. (Ю. З. Розенблюм, К. А. Мац, Н. И. Локтина 1975).

БНМАУ-д байгаа зөвлөлтийн сургуулийн сурагчдын дотор ойрын харалганыг хүндрэлээс сэргийлэх зорилгоор бид хараа тохируулах аппаратын чадварыг сайжруулан, тогтвортжуулах дасгалыг „Шилэн дээр тэмдэглэх“ гэж нэрлэгддэг аргаар гэрийн нөхцөлд хийсэн юм.

Ажиглалт хийхийн тулд 2—10 дугаар ангийн, сүл болоод дунд зэргийн ойрын харалган 377 хүүхдийг сонгон авав. Эдгээрийн 206 нь дасгалыг 1—3 жилийн туршид хийсэн ба үлдсэн 171 нь дасгалыг хийгээгүй юм.

Ажиглалтын дүнг хүснэгтэд үзүүлэв.

**Нүдний хараа тохируулах аппаратад нөлөөлөх дасгалыг
шилэн дээр тэмдэглэх аргаар хийсэн үр дүн**

| Бүлэг | ажиглалтын эхний жил | | ажиглалтын 2 дахь жил | | ажиглалтын 3 дахь жил | |
|-----------------------|----------------------|----------------------------------|-----------------------|----------------------------------|-----------------------|----------------------------------|
| | хүүхдийн тоо | ойрын харалганы даамжралт (длтр) | хүүхдийн тоо | ойрын харалганы даамжралт (длтр) | хүүхдийн тоо | ойрын харалганы даамжралт (длтр) |
| Туршилтын Хяналтын | 206 171 | 0,3 0,9 | 41 62 | 0,8 2,0 | 11 28 | 1,1 2,6 |

Хүснэгтээс үзэхэд дасгал хийсэн хүүхдүүдэд ойрын харалганы хүндрэл эхний 1 жилд дунджаар 0,3 длтр байхад хяналтын хэсгийн хүүхдэд 0,9 длтр, дасгалыг 2 жил хийсэн хүүхдэд 0,8, хяналтын хэсэгт 2,0, дасгалыг 3 жил хийсэн хүүхдэд 1,1 хяналтын бүлэгт 2,6 длтр тус тус байна.

Бидний судалгаа нь хараа тохируулах аппаратын тогтвортжуулах дасгалыг гэрээр хийх нь сургуулийн сурагчдад ойрын харалган нь нэмэгдэхээс сэргийлэхэд ихээхэн үр дүнтэй болохыг харуулж байна.

Ойрын харалган өвчний эмгэг жамд хараа тохируулах аппаратын чадвар сулрах явдал гол үүрэгтэй байдгийг харгалзан үзвэл сургуулийн сурагчдаас ойрын харалган болж болзошгүй урьдчилсан нөхцөл бүхий хүүхдүүдийг тусгай бүлэг болгон авч хараа тогтвортжуулах дасгалыг хийлгэх нь энэ өвчнөөс сэргийлэхэд тэргүүн зэргийн ач холбогдолтой төдийгүй нийт сургуулиудад хичээл дээр нүдний харааг хамгаалах тусгай дасгал хийж байх системийг боловсруулан нэвтрүүлж ч болох үндэстэй байна.

АШИГЛАСАН ХЭВЛЭЛ

1. Э.С. Аветисов, К. А. Мац Тренировка цилиарной мышцы. Метод. рекомендации.—М., 1974.
2. Э. С. Аветисов —О патогенезе миопии и некоторых новых возможностях её профилактики и лечения. В кн. Тезисы докладов III Всерос. съезда офтальмологов. —М. 1975. т. II, 5—16.
3. Э. С. Аветисов Об актуальных вопросах профилактики близорукости, её прогрессирования и осложнений.
- В кн. Охрана зрения детей и подростков. —М. 1984, 9—15.
4. Э. С. Аветисов, Ю. З. Розенблум, Н. Я. Зельцер, К. А. Мац и др. Профилактика нарушений зрения у школьников в районах Крайнего Севера: Метод. рекомендации. —М., 1984.
5. Н. И. Лохтина Тренировочные упражнения аккомодации у детей с начальной миопией, —В кн. Тезисы докладов III Всерос. съезда офтальмологов, —М. 1975, т. II, 72—73.
6. К. А. Мац, Н. И. Лохтина Результаты домашних тренировочных упражнений для цилиарной мышцы при слабой миопии. —В кн. Миопия: Сб. научн. работ. —М. 1974, 109—112.

ПРОФИЛАКТИКА МИОПИИ И ЕЁ ПРОГРЕССИРОВАНИЯ У ШКОЛЬНИКОВ

В. Е. Лапушкин

Работами советских офтальмологов в 70-х годах установлена ведущая роль ослабленной аккомодации в патогенезе миопии. С целью профилактики миопии её прогрессирования успешно применяются в практике физические методы воздействия на аккомодационный аппарат глаза. Существует несколько методик упражнений для тренировки аккомодации.

Наблюдения показывают, что применение в домашних условиях упражнений для цилиарной мышцы „метка на стекле“ является доступным и эффективным методом, позволяющим во многих случаях замедлить скорость прогрессирования близорукости у школьников.

ЭЛЭГНИЙ ЦИРРОЗ ӨВЧНИЙ ЛАБОРАТОРИИН ШИНЖ ТЭМДГҮҮД

АНАГААХ УХААНЫ ДЭЭД СУРГУУЛЬ

Элэгний цирроз өвчний лабораторийн шинж тэмдгийг бид клиник лабораторийн, биохимийн, иммунологийн шинж тэмдэг гэж хуваадаг.

Энэ өгүүлэлд бид элэгний циррозоор өвчилсөн 100 өвчтөний клиничийн өрөнхий шинжилгээний дүн, мөн биохимийн шинжилгээний дүнд ичэрээн шинж тэмдгүүдийг бичлээ.

1. Өвчтөний нас, хүйсний байдал:

| | | | | | | |
|--------|---------------|---|---------|----|------|-----|
| 16—20 | насны эрэгтэй | 1 | эмэгтэй | 1 | бүгд | 2 |
| 21—30 | ” | ” | ” | 1 | ” | 2 |
| 31—40 | ” | ” | ” | 8 | ” | 11 |
| 41—50 | ” | ” | ” | 21 | ” | 9 |
| 51—60 | ” | ” | ” | 23 | ” | 1 |
| 61—70 | ” | ” | ” | 14 | ” | 6 |
| 71-ээс | дээш | ” | ” | 3 | ” | 0 |
| | | | | | 29 | 100 |

2. Эмнэлэгт ирсэн улирлаар үзвэл: 1-р улиралд 25, 2-р улиралд 37, 3-р улиралд 30, 4-р улиралд 17 хүн иржээ.

20 хүртэл хоног хэвтсэн өвчтөн 40

30 ” ” ” ” ” ” 47

40 ” ” ” ” ” ” 11

50 ” ” ” ” ” ” 2 байв.

3. Субъектив зовиураас элэг өвдөх нь 66, бие суррах нь 65, гэдэс дүүрдэг 56, эцэж турах (жин буурах) 38, хамраас цус гоожих 31, хоолонд дургүй болох шинж 24 өвчтөнд тус тус илэрчээ.

4. 100 өвчтөнөөс 73 нь урьд өмнө элэгний халдварт үрэвслээр өвчилж байсан байна. Үүнээс 5 жилийн өмнө өвчилсөн 36 өвчтөн байснаас үзэхэд элэгний цирроз нь элэгний цочмог үрэвсэлтэй холбоотой нь харагдаж байна.

5. Объектив шинжүүдээс арьс харлах 86, судсан толбо 52, гарын алга улайх 52, нүд шарлах 37, арьс шарлах 28, асцит 33, венийн судас тэлэгдэх нь 23 өвчтөнд тус тус тохиолдажээ.

6. Элэг тэмтрэгдэх нь 64, элэг хатуурах 44, элэг өвчтэй байх нь 41, дэлүү томрох нь 21%-д тус тус байжээ.

1. Цусны өрөнхий шинжилгээний талаас илэрсэн шинжүүд:

а) Гемоглобины хэмжээ 62 өвчтөнд буурсан байв.

Үүнээс үзэхэд улаан бөөмийн тоо цөөрч, өнгө илтгэгч буурах шинжтэй болж цус багасана.

б) Улаан бөөмийн тундас 65 өвчтөнд хэвийн хэмжээнээс дээш болсон байв. Эритроцитийн тухай урвал өндөр болох нь олон шалтгаантай боловч элэгний циррозын үед уургийн солилцоо алдагдаж цусанд альбумин болон бусад уураг багассантай холбоотой.

в) Цагаан цогцсын буурах шинж 65 хүнд тохиолдажээ.

г) Цагаан цогцсын дүрсийн талаас хэсэг цөмт цөөрөх шинж 41 өвчтөнд, 39 хүнд хэвийн, 31 өвчтөнд савхан цөмт багассан, 33 өвчтөнд хэвийн, 12 өвчтөнд тус тус ихэссэн байна. Эозифил буурсан 17, ихэссэн 10, хэвийн 17 байв.

Моноцитын тоо буурсан 62, ихэссэн 9, хэвийн 9 хүн байлаа.

Лимфоцитын тоо ихэссэн 66, хэвийн 15, буурсан 12 өвчтөн байв. Тромбоцит 26 өвчтөнд буурчээ.

2. Шээсний ерөнхий шинжилгээгээр илэрсэн шинжүүд:

а) өөрчлөлтгүй 53, уураг ихтэй 6, цилиндр ихтэй 2, лейкоцит ихтэй 31 хүн тус тус байсан нь бөөрний талаас дагалдах өвчтэй байснаар тайлбарлагдана.

б) шээсэнд цөсний будаг буюу нөсөө 72 өвчтөнд нэмэх гарсан нь элэгний сорвижлын үед гипербилиурбинеми буюу цусанд цөсний нөсөө, цөсний хүчил хэвийн хэмжээнээс их байдгийг харуулж байна.

3. Биохимиийн шинжилгээгээр илэрсэн шинжүүд:

а) Цусанд билирубиний хэмжээ 67 өвчтөнд хэвийн, 15 өвчтөнд их, 2 өвчтөнд бага, 14 хүнд тодорхойлогоогүй байна.

б) Тимол сорил 75 өвчтөнд их, 19 өвчтөнд хэвийн, 6 өвчтөнд хийгдээгүй байв.

в) Цусны ерөнхий уураг 52 өвчтөнд хэвийн, 18 өвчтөнд их, 16 өвчтөнд бага, 14 өвчтөнд тодорхойлоогүй байна.

г) Альбумин 83 өвчтөнд бага, 17 өвчтөнд хэвийн байжээ.

д) Альф глобулин 52 өвчтөнд их, 35 өвчтөнд хэвийн, 13 өвчтөнд хийгдээгүй байв.

Бетта глобулин 65 өвчтөнд их, 37 өвчтөнд хэвийн хэмжээтэй.

Гамма-глобулин 60 өвчтөнд их, 33 өвчтөнд хэвийн хэмжээтэй байв.

е) холестерин цусанд 46 өвчтөнд хэвийн, 8 хүнд их байжээ. Ерөнхий липид 38 өвчтөнд хэвийн, 9 өвчтөнд их, 6 өвчтөнд бага байжээ.

ж) альфа-фета протейн 59 өвчтөнд хасах, 2 өвчтөнд нэмэх буюу их гарчээ.

з) австраль-антиген 58 өвчтөнд хасах, 6 өвчтөнд нэмэх буюу их гарсан байна.

Элэгний циррозтой 100 өвчтөнд хийсэн лабораторийн шинжилгээний дунд доорхи дүгнэлтийг хийж байна. Үүнд:

1. Элэгний цирроз өвчний үед гемоглобин 52 өвчтөнд буурсан нь цус багадах өвчний шинж юм.

2. Улаан бөөмийн тундас 65 өвчтөнд хэвийн хэмжээнээс дээш болсон нь уг өвчний нэг онцлог шинж мөн.

3. Цагаан цогцсын тоо 55 хүнд буурсан лейкопенийн шинж бол цирроз өвчний нэг шинж юм.

4. Лимфоцитын тоо 6 өвчтөнд их байсан нь уг өвчин иммунологийн үзэгдэл бүхий байдагтай холбоотой.

5. Моноцитын тоо 62 өвчтөнд буурсан нь бас онцлог байна.

6. Шээсний шинжилгээнд 53 өвчтөнд онцын өөрчлөлтгүй байжээ. Цөсний нөсөө 72 өвчтөнд нэмэх байлаа.

7. Биохимиийн талаас ерөнхий уураг 52%-д хэвийн, альбулин 83 өвчтөнд бага, альф глобулин 52%-д их, бетта глобулин 65%-д их гамма-глобулин 60%-д тус тус байсан нь уг өвчний онцлог шинжууд болж байна.

8. Холестерин 46% хэвийн хэмжээтэй байжээ.

9. Цирроз өвчний клиник лабораторийн болон биохимиийн лабораторийн шинжийг манай орны нөхцөлд тодорхой судлаагүй байгааг анхаарах нь чухал.

10. Элэгний эмгэг судлах эрдэм шинжилгээний байгууллагатай болох явдал ойрын үед шаардагдаж байна.

АШИГЛАСАН ХЭВЛЭЛ

1. А. Л. Мясников—Болезни печени. М. 1949.
2. З. А. Бондарь—Клиническая гематология. М. 1970
3. Е. В. Крутских—Цирроз печени. М. 1976.

МУХАР ОЛГОЙН ХУРЦ ҮРЭВСЛИЙГ ЭРТ ОНОШЛОХ ШИНЭ ШИНЖ ТЭМДЭГ

АНАГААХ УХААНЫ ДЭЭД СУРГУУЛЬ

Мухар олгойн хурц үрэвслийн клиник шинж их судлагдсан ч өвөрмөц хэлбэрээр болон хүндэрсэн тохиолдолд оношлоход төвөгтэй байдаг. Эмч нар олон жилийн турш энэ өвчний гол шинж тэмдгийг илрүүлэх оролдлого хийж байна. Одоогоор мухар олгойн хурц үрэвслийн 100 орчим шинж тэмдэг илэрсний (10) голлох байрыг өвдөлтийн шинж эзэлдэг.

Судлаачдын материалаас үзэхэд мухар олгойн үрэвслийн оношлолтонд голцуу өвчтөний зовиур, өвчний түүх, өвчний үед илэрч буй шинж, лаборатор болон бусад шинжилгээ, тэдгээрийн нийлбэр үзүүлэлтийг харгалздаг ажээ [1—9].

Манай судалгаагаар мухар олгойн хурц үрэвслийн үе дэх клиникин өвөрмөц илрэл нь үрэвслийн үе шат, үргэлжилсэн хугацаа, морфолог өөрчлөлт, мухар олгойн байрлал, хүндрэл зэргээс шалтгаалж байна.

Мухар олгойн хурц үрэвслийн клиник шинжууд (6, 12, 24, 48, 72 цагт) өвчлөлийн хугацаанаас хамаардгийг дараах хүснэгтээс үзэж болно.

Хүснэгтээс үзэхэд өвчний эрт үед (6 цаг хүртэл) судасны лугшилтын тоо олшрох нь өвчлөлийн хожуу үеийнхээс (24 цагаас дээш) илүү тод байна.

($t=16,7$; $P<0,001$). Ингээд бид мухар олгойн хурц үрэвслийг эрт оношлоход хамааралтай шинж тэмдэг шинээр илрүүллээ. Үүнд мухар олгойн байрлах хэвллийн баруун хэсэгт тэмтрэхэд сүдасны лугшилтын тоо хэвллийг тэмтрэхээс өмнөх үеийнхээс минутанд 10—15 ба түүнээс ч их нэмэгдэнэ. Бид энэ шинжийн үйлчлэлийг хэвллийн баруун хэсэгт гүнзгий тэмтрэхэд өвдөлтийн сэрэл висцерал мэдрүүлийг цочроосноор төв мэдрэлийн системд хүрч хариу эмгэг сэрглийг зүрх судасны системд өгч түр хугацааны судасны лугшилтын тоог ихэсгэдэг гэж үзэж байна. Энэ шинжийг мухар олгойн хурц үрэвсэлтэй 196 өвчтөнд илрүүлсний 86%-д улайж үрэвссэн, 15% нь идээлсэн өөрчлөлтэй мухар олгой байсныг хагалгааны дараа баталсан.

Бидний илрүүлсэн дээрх шинж тэмдэг мухар олгойн хурц, үрэвслийг эрт оношлоход нэмэр болно гэж үзэж байна. Мөн Меккелийн цүлхэн, мухар гэдэсний хавдар, Кройний өвчин зэргээс мухар олгойн хурц үрэвслийг ялган оношлоход тус дөхөм үзүүлнэ. Ер нь мухар олгойн хурц үрэвслийг өвчтөний зовиур, өвчний түүх, клиник шинжууд, лаборатор болон бусад шинжилгээний тусlamжтайгаар сая бүрэн гүйцэд оношлох юм.

ДҮГНЭЛТ Өвчтөнөөс бүрэн гүйцэд анамнез цуглуулж, анхааралтай үзсэнээр мухар олгойн хурц үрэвслийг эрт онцшлож, уул өвчний хүндрэлээс урьдчилан сэргийлэхэд бидний илрүүлсэн „Судасны лугшилтын тоо ихсэх“ шинж хамаарна.

Хүснэгт I

**Мухар олгойл хурц үрэвслийн клиник шинж
өвчлөлийн хугацаанаас хамаарсан байдал**

| Өвчлөлийн хугацаа (цаагаар) | 6 | | 12 | | 24 | | 48 | | 72 | | |
|--|-------------------------|--------------|----|-------------------------|-------|--------------|-------|-------------------------|-------|--------------|-------|
| | Нийт өвчтөний тоо | Бодит тоо | % | Нийт өвчтөний тоо | % | Бодит тоо | % | Нийт өвчтөний тоо | % | Бодит тоо | % |
| Клиник шинжүүд | 204 | 100,0 | | 146 | 100,0 | 108 | 100,0 | 86 | 100,0 | 68 | 100,0 |
| Хэвллийн өвдөлт | 176 | 86,3 | | 100 | 68,5 | 98 | 90,7 | 86 | 100,0 | 68 | 100,0 |
| Огих, бөөлжих | 24 | 11,8 | | 104 | 71,2 | 108 | 100,0 | 86 | 100,0 | 68 | 100,0 |
| Халуурах | 22 | 10,8 | | 29 | 19,9 | 38 | 35,2 | 72 | 83,7 | 68 | 100,0 |
| Тахикардия | 14 | 6,9 | | 48 | 32,9 | 64 | 59,3 | 74 | 86,0 | 56 | 82,3 |
| Хэл өнгөрдөх | — | — | | 4 | 2,7 | 8 | 7,4 | 81 | 94,2 | 62 | 91,1 |
| Хэл хуурайших | — | — | | 2 | 1,4 | 48 | 44,4 | 5 | 5,8 | 4 | 5,9 |
| Хэл хэвийн | 204 | 100,0 | | 140 | 95,9 | 52 | 48,1 | — | — | — | — |
| Хэвллийн баруун хэсэгт тэмтрэлтээр өвдөлт нэмэгдэх | 174 | 85,3 | | 126 | 86,3 | 99 | 91,7 | 86 | 100,0 | 68 | 100,0 |
| Коупын шинж | 49 | 24,0 | | 72 | 49,3 | 68 | 63,0 | 64 | 74,4 | 10 | 14,7 |
| Воскресенский шинж | 68 | 33,3 | | 69 | 47,3 | 89 | 82,4 | 71 | 82,5 | 2 | 3,0 |
| Ситковский шинж | 86 | 42,2 | | 82 | 56,2 | 101 | 98,5 | 74 | 86,0 | 4 | 5,9 |
| Хэвллийн булчин гийн чангараал | — | — | | 2 | 1,4 | 54 | 50,0 | 69 | 80,2 | 68 | 100,0 |
| Шеткин-Блюмбериин шинж | — | — | | 2 | 1,4 | 14 | 13,0 | 74 | 86,0 | 68 | 100,0 |
| Хэвллийн хэсэгт гэдэсний гүрвэлзэх хөдөлгөөн багасаж сонсогдохгүй болох шинж | — | — | | — | — | 2 | 1,9 | 6 | 7,0 | 62 | 91,1 |
| Судасны лугшилтын тоо ихсэх шинж | 196 | 96,0 | | 98 | 67,1 | 26 | 24,0 | — | — | — | — |

АШИГЛАСАН ХЭВЛЭЛ

1. С. С. Акперов оглы. Сравнительная оценка симптомов острого аппендицита. М., дисс. к.м.н 1983.
2. Б. И. Альперович, М. М. Соловьев. Острый аппендицит. В кн. Очерки неотложной хирургии живота. Томск, 1975, 5—25.
3. Т. Я. Арье, С. Б. Телета, Аппендицит. В кн. Острый аппендицит тромбофлебит и некоторые вопросы пластической хирургии. Куйбышев, 1956, 28.
4. В. Р. Брайцев Острый аппендицит. М., 1946, 14.
5. Ю. Ю. Джанелидзе, М. В. Красносельский и И. М. Рохкинд. О диагностике острых заболеваний органов брюшной полости в условиях внебольничной сети. Л., 1937, 29.
6. Д. И. Егоров, П. И. Харин, С. М. Маркова и др. К вопросу о снижении количества необоснованных хирургических вмешательств по поводу острого аппендицита. Пермь, 1969, 82—84.
7. В. И. Колесов. Острый аппендицит. Л., 1972, 112.
8. И. Д. Корабельников. Парадоксы острого аппендицита истинные и кажущиеся. Вестник хирургии, 1970, № 3, 46—48.
9. В. И. Русаков, В. Н. Черчов. Перспективы улучшения результатов лечения больных аппендицитом. Клиническая хирургия. 1973, № 5 12—16.
10. В. М. Удод, А. М. Антонов. К диагностике острого аппендицита у лиц старше 60 лет. Здравоохранение Белоруссии. 1970, № 6, 27—29.

НОВЫЙ СИМПТОМ РАННЕГО ДИАГНОСЦИРОВАНИЯ ОСТРОГО АППЕНДИЦИТА

В. ИЧИНХОРЛО, Б. ГООЩ, К. АНАРГУЛ

Клиническая картина острого аппендицита достаточно хорошо изучена, но нередко многообразная атипичная симптоматика в значительной степени усложняет диагностику. В настоящее время насчитывается более 100 описанных симптомов острого аппендицита, среди которых ведущее место занимает болевой симптом.

Нами разработан новый симптом острого аппендицита, который выявляется в анне стадии этого заболевания.

Суть этого симптома заключается в том, что при пальпации в правой подвздошной области выявляется учащение пульса по сравнению с проверкой до данного симптома ($t=16,7$; $P<0,001$).

Д. МАЛЧИНХҮҮ, Т. ОЮУНБИЛЭГ

МӨГӨӨРС ТӨЛЖИЛГҮЙДЭХ ӨВЧНИЙ НЭГЭН ТОХИОЛДОЛ

АНАГААХ УХААНЫ ДЭЭД СУРГУУЛЬ
УЛСЫН ХҮҮХДИЙН КЛИНИКИЙН ТӨВ ЭМНЭЛЭГ

Мөгөөрс төлжилгүйдэх өвчнийг анх Кауимана хондродистрофия гэдэг нэрээр бичжээ. Хондродистрофи нь ясны мөгөөрс төлжин өсөх процесс алдагдсанаас хэвийн ясжилт өөрчлөгддөг, ясны тогтолцооны удамшлын өвчин юм.

Үр хөврөлийн хөгжлийн яс үүсвэрийн үед ясны булуу хэсгийн мөгөөрс өсөлтийн бүсэд мөгөөрсний эсүүд эмх замбаараагүй байршин, түүний өсөлт saatсанаас юмуу зогссондоос яс уртаашаа өсөхөө болино. Харин ясны хальсан доорхи ясжилт, яс зузаан болох нь онц өөрчлөгддөггүй учраас мөчний яснууд будүүрэх процесс хэвийн байна. Иймээс хөл гарын яс богино, будүүн, нуруу баганы яс хэвийн өсөлттэй байна. Ингэж биеийн өсөлтийн харьцаа хэм алдагдах боловч хүүхдийн мэдрэл-сэтгэхүй, дотоод шүүрлийн булчирхайн хөгжилт хэвийн байдгаараа онцлог юм. Эмнэлзүйн онцлогийг дараах өвчиний түүхээс авч үзье.

Өвчтөн И. И. 15 настай, охин, хүүхдийн клиникийн төв эмнэлэгт 1982 оны 11 сард хэвтсэн.

Амьдралын түүх. 1967 оны 6 сарын 25-нд төрсөн. Хүүхэд бутэлтэй төрсөн ба төрөх үедээ хоёр хөл нь тэндийхгүй, атийсан байдал нь ойндоо хүртэл хэвээрээ байсан. Хүүхдийн бие бялдын хөгжилт удаан 6 сартай толгойгоо дааж, ой өнгөрөөд сууж, 3 нас орчимтойдоо явж эхэлсэн. Эцгийн гэрчилснээр, хүүхдийн өсөлт 8—12 насны хооронд нэлээд эрчимтэй байжээ. 12 настайгаас нь бэлгийн хоёрдогч шинжүүд илэрсэн. Ой ухааны хөгжилт хэвийн байсан. Мөчинүүд харьцангуй богино байснаас сургуульд ороход нь тусгай зориулалтын сандал, ширээ шаардагдсан. Хүүхэд сэргэлэн, ухаалаг, 7-р анги хүртлээ сайн суралцаж, богино хэмжээний шүлэг зохиодог.

Өвчлөлийн түүх. Эцгийн өгүүлснээр хүүхэд 5 нас хүртлээ амьсгалын эрхтний өвчнөөр жилд нэггээс хоёр удаа өвчилдөг байжээ. Улаанбурхан, хөхүүл ханиад, элэгний халдварт үрэвсэл, цусан суулга зэрэг халдварт өвчнөөр өвчилсөн байна.

Өвчтөнийг үзэхэд биеийн харьцаа зөв биш, толгой том, дүх хүнхэр, нуруу бүсэлхийн орчмоор их хотгор, мөчинүүд, богино, мөчний яснууд үзүүр хэсэг рүүгээ будүүрч өөрчлэгдсөн. Харин их биеийн урт хэвийн учраас хүүхэд гаралт үнжуулж зогсоход гарын хурууны үзүүр цавины нугалаас орчимд (эруул хүүхдэд гуяны дунд) байна.

Хүчингтээс үзэхэд хүүхдийн толгой харьцангуй том, нурууны урт, цээжний тойрог, биеийн жин бараг хэвийн хэмжээнд байхад гар, хөлийн урт 30—40 см-ээр, богино учраас хүүхдийн ерөнхий өндөр 38 см-ээр бага байна.

Ясны зурагт хөл гарын яс мурий, ясны өсөлтийн бүс хаагдсан, доод эрүү харьцангуй том, дагзны нүх хэмжээнээсээ жижиг байсан. Лабораторийн бусад шинжилгээнүүдэд эмгэг өөрчлөлт байгаагүй.

Хүүхдийн биеийн хэмжээ

| Хэмжээ | Байх ёстой хэмжээ | Өвчтөний үзүүлэлт | Хэлбийлт |
|--------|---------------------|-------------------|---------------|
| 1 | Биепийн өндөр | 153+6 см | -22—-38 см |
| 2 | Нуруу баганы урт | 81—80 см | -1—-2 см |
| 3 | Биепийн жинь | 45+6,8 кг | баралг хэвийн |
| 4 | Бугалга шууны урт | 66,2 см | -30 см дутуу |
| 5 | Гуя, ширлэбэний урт | 87,2 см | -40 см дутуу |
| 6 | Цээжний тойрого | 76,4—4 см | -2 см |
| 7 | Толгойн тойрого | 52—53 см | +1,5 см |

Энэ өвчнийг эрт оношлож, согог-заслын эмчилгээ хийх нь чухал юм.

АШИГЛАСАН ХЭВЛЭЛ

1. И. Аяндреев, И. Вапцаров. „Дифференциальная диагностика важнейших симптомов детских болезней“. Пловдив, 1977.
2. М. С. Маслов. Лекции по факультетской педиатрии, М. 1960.
3. Многотомное руководство по педиатрии. Том 11. М. 1961.

ОДИН СЛУЧАЙ АХОНДРОПЛАЗИИ У ДЕТЕЙ

Д. Малчинху, Т. Оюунбилэг

В работе сообщается об одном случае редкой наследственной болезни костной системы-ахондроплазии. У больной ахондроплазией отмечаются короткие ноги и руки при нормальном росте позвоночника, вследствие врожденного нарушения энходриальной пролиферации окостнения трубчатых костей. При этом не страдает нервно-психическое развитие ребенка.

ЧАЦАРХАЙН СУДАСНЫ ТҮГЖРЭЛ

Чацаархайн судас бөглөрөх нь гэдэсний цочмог түгжрэлийн хамгийн хүнд хэлбэр бөгөөд үхэл ихтэй байдаг.

Сүүлийн үед гадаадын нэлээд эрдэмтэд бие даасан өвчин гэж үзэж байна. [1, 3]

Чацаархайн артерийн бөглөрлийн шалтгааны 79,1% нь судас хатуурх, түүнчлэн даралт ихсэх өвчин, эндоартерийтэй холбоотой ба периартерийт, васкулит, рак, цирроз, спленомегалия болон гэмтэл, мөн мэс заслын дараа ч үүсдэг. [3]. Судасны бөглөрөл нь дан артерийн, венийн мөн хавсарсан, байдааар байна.

Артерийн судасны бөглөрөл—Энэ нь нэг ба хэд хэдэн газарт бөглөрөч болно. Байралааар нь: чацаархайн дээд артерийн ба доод артерийн гэж хуваана. Бөглөрөл нь артерийн 1-р сегментэд үүсвэл нарийн гэдэсний бүх гогцоо, бүдүүн гэдэсний баруун талын өгсөх ба муухар хэсгийг хамарна. Харин чацаархайн дээд артерийн салаанд байрлавал нарийн гэдсэнд хязгаарлагдмал өөрчлөлтүүд ажиглагдана. Чацаархайн доод артерийн салаа бөглөрсөн үед бүдүүн гэдэсний зүүн талд гэмтэл үүснэ.

Велийн судасны бөглөрөл. Энэ нь ховор тохиолдоно. Эхлээд захын жижиг вени-д үүсч улмаар том салаанд бөглөрдөг. Хаалган ба дэлүүний венийн тромбо уруудах замаар чацаархайн венийг бөглөдөг. Венийн бөглөрөл нь хэвлэйн хөндийн гэмтэл, мэс засал, цочмог идээт үрэвслийн дараа үүснэ. Чацаархайн венийн бөглөрлийн 85% нь дээд хэсэгт үүсдэг.

Шинж тэмдэг. Өвчин гэнэт эхлэн маш хүчтэй өвдөнө. Өвдөлтөөс өвчтөн шок-д ордог. Өвчтөний царай цонхигор, хүйтэн хөлс нь цутгана. Арьс нь цайвар, үнсэн саарал бэх хөхөвтөр туяатай байх нь олонтой. Өвчиний эхний үед огиж, бөөлжинө. Хэл чийглэг байснаа хожуу үед хуурайшин өнгөр сууж саарал өнгөтэй болно. Өвчин нь даамжирахад түгжрэл гялтангийн үрэвслийн шинж тодорхой болж, судасны бөглөрлийн үед цусны хольцтой өтгөнөөр юмуу цусаар суулгадаг. Гэрлийн тойм харалтаар клейборийн аяганцын шинж илэрнэ.

Лабораторийн шинжилгээгээр: лейкоцитын тоо нэмэгддэг. НВ-эхний үед нэмэгдэн $16,5 - 17$ г% хүрч аажмаар буурдаг. Тромбоцитын тоо нэмэгдэхээс гадна, протромбины индекс ихсэнэ. Нийт уураг өвчиний эхний үед $7,16 \pm 0,57$ -аас $8,28 \pm 0,21$ мг%, дунд үед $6,77 \pm 0,14$ г% хүрч, хожуу гялтангийн үрэвслийн үед $5,9 \pm 0,89$ г% болтлоо багасна.

Эмчилгээ— Өвчиний эхний үед цус бүлэгнэлтийн эсрэг (антикоагулянтная) эмчилгээг системтэй хийж үр дүн өгөхгүй буюу түгжрэлийн шинж илэрмэгц мэс засал хийх нь зүйтэй.

Нэгэн жишээ авъя:

Өвчтөн Д. 72 настай эмэгтэй. З-р эмнэлгийн дотрын З-р тасагт цусны даралт ихсэх өвчиний улмаас түргэн тусламжаар ирж З хоногийн өмнө хэвтсэн. Цусны даралт ихсэх өвчнөөр 10 жил өвчилсөн. Хэвтсэний маргаашаас нь гэдэс өвдэж, бөөлжис цутган, бие суларч, цусархаг зүйлээр нэг удаа гүйлгэлээ гэсэн зовиуртай байснаа шаналгаа нь даамжирч өвдөх нь улам хүчтэй болж эвгүй үнэртэй зүйлээр бөөлжин хий ба баас нь бүрэн хаагдсан. Үзлэгээр: царай нь цонхийн хордлогонд орж, гэдэсний механик түгжрэлийн шинж бүрэн илэрч, цусны шинжилгээнд, протромбины индекс 120%-д хүрч, хэвлэлиг гэрэлд харахад клейборийн аяганцуул олон тоотой байсан тул судасны түгжрэл оноштойгоор яаралтай хагалгаа хийв. Ерөнхий мэдээ алдуулалтын дор хагалгааг хийсэн. Хэвлэлиг нээхэд цусархаг, муухай үнэртэй шингэн гарсан. Нарийн гэдэсний гогцоонууд нийтдээ хар хүрэн өнгөтэй болж үхжин судас нь лугшихгүй болсон, чацаархайн дээд артерийн эхлэх хэсэгт 3 см хиртэй урт тромбо үүсч судасныхаа ханыг бүрэн бөглөсөн байв. Тромбыг авч хэвлэлийг угааж антибиотик хийв. Мэс заслын дараа 6 цаг болоод өвчтөн нас барсан.

Дүгнэлт:

- Судасны хатуурал, цусны даралт ихсэх өвчин нь чацаархайн судасны тромбо үүсгэх үндсэн щалтгаан болж байна.
- Чацаархайн судасны түгжрэлийг эрт оношлоход дээрх клиникээс гадна цусанд тромбоцит, протромбины индексийг тодорхойлох нь чухал ач холбогдолтой.
- Чацаархайн судасны түгжрэлийг хожуу оношлон, эмчлэхэд хүндэрч байна.

Анагаах ухааны дэд эрдэмтэн Н. БААСАНЖАВ
Их эмч Г. ДУЛМАА

АШИГЛАСАН ХЭВЛЭЛ

- А. С. Альтшуль „Механическая непроходимость кишечника“ 1962.
- Ю. М. Лубенский „Интенсивная терапия в неотложной авдоминальной хирургии“ 1981,
- В. С. Савельев, И. В. Спиридовон „Острые нарушения мезентериального кровообращения“ 1979,
- Д. П. Чухриенко „Непроходимость кишечника“ 1958
- Ю. Н. Шанин, Ю. Н. Волков „Послеоперационная интенсивная терапия“ 1978.

ШИНЖЛЭХ УХААН ЭРЭЛ ХАЙГУУЛАА ҮРГЭЛЖЛҮҮЛЖ БАЙНА

БИЕ МАХБОДОД НЭВТРЭН ОРСОН ГАДНЫН БИЕТИЙГ
ТАНИХАД ОРОЛЦДОГ ШИНЭ УУРАГ

Бидний бие организмыг гаднын биет-эсрэгтөрөгчөөс хамгаалагч цусны цагаан цогцсын хоёр үндсэн төрөл Т ба В лимфоцитын хооронд өвөрмөц онцлогтой хөдөлмөрийн хуваарь байдаг. Ямар ч В лимфоцит нь эсрэг бие нийлэгжүүлэгч аппаратаар зэвсэглэж, тодорхой дайсныг шууд устгах үүрэгтэй байлдагч юм. Т лимфоцитын ихэнх нь удирдагчийн үүрэг гүйцэтгэнэ. Тэд зөвхөн дайсныг ялган таньж В лимфоцит од ажиллаж эхлэх дохио өгдөг.

Т лимфоцитын эсрэгтөрөгчийг тэмтрэн ялгаж таньдаг рецепторыг олж илрүүлэх нь орчин үеийн дархал судлалын шинжлэх ухааны гол асуудлын нэг байлаа. В лимфоцит гадарга дээрээ байрласан эсрэг биеийн тусламжтайгаар дайснаа таньдаг. Харин Т лимфоцит нь эсрэг бие үүсгэдэггүй. Түүний гадарга дээрээс эсрэгбиетэй төстэй зүйлийг илрүүлэх оролдлого амжилтанд хүрдэггүй байв. Гэвч эсрэгбие бол эсрэгтөрөгчийг таньж чадах ганц боломжтой зүйл гэж үзсээр байлаа. Зөвхөн өнгөрсөн онд л судлаачдын 2 бүлэг бие биенээсээ үл хамааран нэгэн зэрэг нэг нь Торонтод, нөгөө нь Калифорнид тэр нууц рецептор болох 45 мянган дальтон молекуллаг жинтэй 2 хэлхээ уургийг тодорхойлж чаджээ. Үүний тулд молекуллаг биологийн сүүлийн жилүүдэд гарсан бараг бүх шинэхэн ололтыг ашиглахад хүрсэн байна.

Т лимфоцитэд үйлчлэн түүний идэвхийг сонгон саатуулж чадах моноклон эсрэгбиесийг гарган авч чадсан нь нэг бүлгийн амжилтын үндэс болжээ. Моноклон эсрэгбиетэй үйлчлэлцэж байсан молекул нь дээр дурдсан уураг байв. Судлаачдын нөгөө бүлэг нь генийн инженерчлэлийн аргыг хэрэглэсэн ховорхон туршилтаар энэ уургийн ач холбогдлыг баталж чаджээ.

Судлаачдын энэ бүлэг Т лимфоцитын удашлын материалаас мэдээллийн рибонуклейн хүчил РНХ-г ялгаж, түүнээсээ хуулбарлаж дезоксирибонуклейн ДНХ-г бий болгож чаджээ. Энэ ДНХ нийлэгшилийг нь нууцалбарлаж чадах уургийн молекуллаг жин нь таамаглаж байгаа, рецепторын молекуллаг жинтэй бараг адилхан байв. Таамаглаж байгаа рецептор уургийн нэг хэлхээнийх нь анхдагч бутэц эсрэгбиесийн пептидийн хэлхээний бутэцтэй ихээхэн төстэй байв. Гэвч яг адилхан биш. Энэ нь зөвхөн олон арван жил эрсэн уураг олдсон хэрэг биш бөгөөд эсрэгбиетэй төстэй боловч эволюц хөгжлийн хувьд түүнээс урьд үүссэн байж магадгүй, эсрэгтөрөгчийг таних урьд нь мэдэгдээгүй систем байгааг баталж өгчээ.

Ж. ОЮУНБИЛЭГ

ГЕРПЕСТ ХАЛДВАРТАЙ ТЭМЦЭЖ БАЙНА

Вирусын өвчнүүд дотроос герпест халдварт чухал байр эзэлдэг. Энэ нь ерийн герпесийн вирус элдэв замаар тархдагтай холбоотой. Герпест халдварууд тархины үрэвсэл (энцефалит), тархи нугасны үрэвсэл (энцефаламиелит) зэрэг төв мэдрэлийн системийн, нүдний эвэрлэг бүрхэвчийн үрэвсэл (кератит) эвэрлэг-салст бүрхэвчийн үрэвсэл (керато-коноюктиvit) зэрэг нүдний өвчин болон насанд хүрэгчдийн ба нярайн элэгний архаг үрэвсэл, экзем, цэврүүт туурдаас зэрэг арьсны эмгэг үүсгэнэ. Одоогоор умайн хүзүүний өмөнгийн эмгэг жамд ч герпесийн вирус үүрэгтэй болох нь магадтай боллоо. Дэлхийн эрүүлийг хамгаалах байгууллагын мэдээгээр герпест халдварын өвчнүүд үхлийн шалтгаач болох нь вирусын өвчний дотроос томуугийн дараа хоёрдугаарт орж байна.

Эх хүүхдийн эрүүл мэндэд үзүүлэх энэ өвчний хор уршгийн талаар өнөө үед нилээд судлаад байна.

Явут болон хэвтэж эмчлүүлж байгаа өвчтөний тоо ч их байна. Тухайлбал ганц жишээ авч үзэхэд эвэрлэг бүрхэвчийн эмгэгийн 60%-ийг нүдний болрын болон эвэрлэгийн герпест үрэвсэл өзэлж байна.

Энэ бүхнээс үзэхэд герпест өвчний дахилт, хүндрэлээс сэргийлэх нь чухал юм.

ЗХУ-ын Шинжлэх ухаачын академийн дэргэдэх Д. И. Ивановскийн нэрэмжит вирусологийн институт сүүлийн 20 жилид герпесийн вирус, нүд, арьс, амны хөндийн өвчний шалтгаан болох тухай бусад институттэй хамтран олон талт судалгаа хийсэн байна. Энэ ажлыг ЗХУ-ын Шинжлэх ухааны академийн сурвалжлагч гишүүн А. К. Шубладзе удирдаж, уул вирусын 300 гаруй омог (штамм) ялгаж, вирусын биологийн болон антигенны чанарыг судалж, түргэвчилсэн аргаар онош тогтоох серолог, иммуноморфологийн аргыг хэдэн юммын сийвэн бэлдэв. Герпест халдварт дахихаас сэргийлэх фармоминаар идэвхгүйжүүлсэн вакцин бэлтгэв. Вирусын эсрэг бие их байгаа нөхцөлд уг өвчин дахидалг нь мэдээж болсон юм. Өнөө үед герпест өвчний хүнд хэлбэрийн үед поливакцин хэрэглэх талаар нийлээд туршлагажжээ. Вакциныг арьсанд курсээр тарьдаг. Зөвлөлтийн судлаачид уг бэлдмэлийг өвчин дахихаас сэргийлж хурц бус үед нь хэрэглэж байна.

2—3 өдрийн зайдай 3 удаа арьсанд тарих нь нэг курс гэж үзэж, жилд 2-оос доошгүй удаа курс эмчилгээ хийхэд: нүдний өвчтөний 63% дахилтгүй, 27% тун цөөн дахиж, зөвхөн 6% нь хэвээр үлджээ. Арьсны өвчтөний 90 хувь нь вакцин сайн нөлөө үзүүлжээ. Бэлгийн замын герпест өвчинд хийсэн 10 жилийн ажиглалтаас үзэхэд тэдний 60% нь тогтвортой засал авч, 25% нь дахиагүй байна.

Уг вакцин харш нөлөө, хүндрэл өгөхгүй байна. Арьс, нүд амны хөндийн герпест өвчний хүнд хэлбэрийн үед уг вакциныг хэрэглэх зориулалттай. Энэ вакцин одоогоор хэрэглэж байгаа АНУ, ХБНГУ, Английн вакцинуудаас дутахгүй юм. Герпест өвчнүүдийг эмчлэх түүний хүндрэлээс сэргийлэхэд химиин бэлдмэлүүд чухал үүрэгтэй.

Нуклеозидийн бэлдмэлүүдийг нилээд сайнд тооцож байна. Гер-

песийн вирусын үрэвслийн механизмыг судалснаар уг эмүүдийг клиникийн нөхцөлд туршин хэрэглэх боломжтой болсон юм.

Гадаадын хэвлэлийн мэдээлж байгаагаар Керецид (5-йод-2 дезоксиуридин), трифторметилдез оксиуридин гэдэг 2 бэлдмэлийг нилээд хэрэглэж байгаа бөгөөд Эдгээрийг нүд, арьс, бэлгийн герпест өвчнүүдийн үед дуслаар хэрэглэдэг.

Герпесийн шалтгаантай энцефалитийг эмчлэхэд Видарабин (адениарабинозид)-ыг судсан. вирусын эсрэг нилээд өргөн хэрэгтэй үйлчлэх рибавирин (виразал)-ыг хэд хэдэн герпест өвчний үед ялангуяа бүслүүр үлдийг эмчлэхэд хэрэглэж байна.

Манай оронд синтез нуклеозидийн герпесийн эсрэг үйлчлэлийг системтэй судалж байна. Нуклеозидээс нүдний герпест өвчнүүдийг эмчлэх дусал, нүдний хучаас (пленок) бэлдмэл таргаж авлаа.

Флонераль, теброфен гэдэг эмүүдийг практикт хэрэглэж байна. Туршин судлаачид ба клиникийн эмч нар интерферон болон түүний индукторт их анхаарал тавьж байна.

Нүдний герпест өвчний хүнд хэлбэрийг эмчлэхэд байгалийн ба синтез интерфероны индуктор сайн үйлчилж байгааг тогтоолоо. Тэдгээрийг уг өвчний хурц үед хэрэглэхэд өвчтөний 60—70%, даамжирсан явцтай, архаг хэлбэрт хэрэглэхэд бараг тал хувь нь эдгэржээ.

ШИНЭ АРГА, ТҮҮНИЙ БОЛОМЖ

Клиникийн анагаах ухаанд цоо шинэ чиглэл бол рентгений тусалцаатай судас сэтгүүрдэх мэс ажилбар (рентгеноэндоваскулярная хирургия) юм.

Уг арга нь онош, эмчилгээний ач холбогдолтой. Энэ аргыг хэрэглэхэд өвчтөнд зовиур шаналгаа бага, эд эсийг бага гэмтээдэг зэрэг олон талын ашигтай. Өвчтөний хэвтэж эмчлүүлэх хугацааг хэмнэж, тэдний хөдөлмөрийн чадвар алдах цагийг богиносгон, эмчилгээний идэвх нь 70—80% хүрч байна.

Бүх холбоотын болон холбооны бүгд найрэмдах улс, муж хязгаарын ангиографийн төвүүдийг бэхжүүлсний үр дүнд уг аргыг өргөн хэрэглэх боломжтой болж, одоо ангиографийн 120 төвд жилд 100000 илүү шинжилгээ хийж, судас сэтгүүрдэх мэс ажилбарыг 40 гаруй эмнэлэгт хэрэглэж, жилд ойролцоогоор 2,500 хагалгаа хийж байна. Одоогоос 5 жилийн өмнө судас сэтгүүрдэх мэс ажилбарыг судас бөглөх эмболизаций зэрэгт хэрэглэж байсан бол одоо зүрхний титмийн болон доод мөч, бөөрний судас сэтгүүрдэхэд хэрэглэж байна.

Клиникийн практикт тодорхой тохиолдолд уг арга уламжлалт аргуудаас сайн талтай юм. Тухайлбал үүнийг, ходоодноос цус алдах үед цус тогтоох, зүрх судаснаас контраст бодисын гаралтай гадна биетийг авах зэрэгт хэрэглэнэ.

Мөн өвчтөний байдлаас хүнд хагалгаа хийх боломжгүй тохиолдолд өвчтөний зовиурыг багасгах, эд эрхтэнийг бага гэмтээх, цус бага гаргах мэс ажилбарыг хийхэд ашиглаж байна.

Цаашилбал уг аргыг эмчилгээний зорилгоор судас бөглөх, хуурчамч бүлэн (тромб) үүсгэх, электрокоагуляци хийх, судасны цүлхэнг (аневризм) эмчлэх, хорт хавдрын орчны цус хангамжийг зогсоох, бөөр, дэлүү зэрэг эрхтэний ажиллагааг сэдээх зэрэгт ашиглаж байна.

САНСАР ДАХЬ АНАГААХ УХААН

1963 оны сүүлээр ЗХУ-ын Эрүүлийг хамгаалах яамны дэргэд эмнэлэг-биологийн асуудал эрхэлсэн институт байгуулагдсан билээ. Уг институтийг байгуулж, хөгжүүлэх үйлсэд академич Н. М. Сикасян, В. Н. Черноговский, эрүүлийг хамгаалахын нэрт зохион байгуулагч А. Н. Бурнаев, мөн институтийн анхны захирал, академич А. В. Лебединский болон академич В. В. Парин нар үлээмжийг түрэг гүйцэтгэв.

Тус институтийг байгуулах үед ЗХУ-ын зургаан нисгэгч сансарт ниссэн бөгөөд тэдний нислэгийн хугацаа 5 хоногоос хэтрэхгүй байв. Өнөөдөр ЗХУ-ын анагаах ухаан нэг нь 2—3 удаа ниссэн 50 гаруй нисгэгч оролцсон 10 шахам нислэгийг бэлдсэн арвин туршлага хуримтуулжээ.

Нислэгийн үргэлжлэх хугацаа хагас жил түүнээс илүү болж уртаслаа. Тус институтийн олон лабораторт сансрын нислэг хүний бие махбодод хэрхэн нөлөөлөхийг судалж, нисгэгчдийн ажлын чадварыг зохих түвшинд байлгах, тэдний эрүүл мэндийг хамгаалах, аюулгүй байдлыг хангах зорилт тавьж байна.

Хүн сансарт ниссэн эхний үед эмнэлгийн хяналтыг гол нь хүний эрүүл мэнд, түүний орчны хувирлыг тогтоох, нислэгийг уртасгах боломжийг судалж байсан бол одоо урт хугацааны нислэгийн үед сансрын нисэгчдийн эрүүл мэндийн талаар мэдээлэл авах тэдний эрүүл мэндэд хяналт тавих, прогноз боловсруулах, евчлөлөөс сэргийлэх ажлууд хийж байна.

Хүлээж авсан мэдээллийн үндсэн дээр экипажийнхны газраас тасрах үеэс эх дэлхийд буцах хүртэлх хугацааны өдрийн болон, хоол хүнсний дэглэм биеийн тамирын дасгал хийх журам, эмчлэн эрүүлжүүлэх, сэргийлэх журам, ажлын чадвар, эрүүл мэндийн байдлын прогноз боловсруулдаг.

Нисгэгчдийн эрүүл мэндийн байдлыг судлах боломж улам бүр нээгдэж байна.

Өнөөдөр тойрог замын станцын бүхээгт хүний олон эрхтэн системийн үйл ажиллагааг судлах багаж хэрэгслүүд байрлуулж, зүрх судасны үйл ажиллагаа, харааны ба тэнцвэрийн эрхтнүүд, ус-давс, хүчилтөрөгчийн солилцоог судалж байна. Космос хэмээх биодагуул дээр явуулж байгаа иж бүрдмэл судалгааны ажилд биологийн олон объект ашиглаж, тэдний үржил хөгжлийг судалж байна.

Энэ био-дагуул дээрх судалгааны ажил нь сансрын экспедицийнхний эмнэлэг-биологийн нөхцөлийг боловсронгуй болгох арга зам боловсруулах боломж бий болгож байна. Өнөөдөр эрдэмтэд жингүйдлийн нөхцөлд хүний биед гарах өөрчлөлт, түүний учир шалтгааны талаар ихийг тайлж мэдлээ. Гэвч шийдэгдээгүй асуудал нэлээд байна.

Тэнцвэрийн эрхтний хямрал, ус-давсны баланс алдагдах, цусанд гарах өөрчлөлтийн учир шалтгааныг лавшуулж судлах ажил ургэлжилж байна.

Удаан хугацааны нислэгийг улам бүр бсэговсрынгүй болгохын тулд сансрын туяаны хүнд хэсгийн биологийн үйлчлэлийг бүрэн тайлах, сансарт хүн амьдрах боломжийг дээшлүүлэх, сэтгэл зүйн зарим бэрхшээлийг шийдэх явдал шаардлагатай байгаа учир тус институтийн хамт олон энэ зорилтуудыг шийдвэрлэхийн тулд шургуу хөдөлмөрлөж байна.

Сансрын анагаах ухааны ололтыг эрүүлийг хамгаалахын практикт өргөн хэрэглэж байна. Сансрын нисэгчдийг бэлдэх физиолог, психологиян аргыг эх дэлхий дээрх мэргэжлийн ажлын зарим хамт олныг бэлдэхэд туршилтын журмаар хэрэглэж байна.

Зүрх судасны болон тэнцвэрийн эрхтэн, ус давсны солицоог судлах аргыг клиникт өргөн ашиглаж байна. Сансын нисэгчдийн судалгааны багаж эмнэлгийн аппарат хэрэгсэл, тэдний ариун цэврийн баараа эх дэлхийн амьдралд нэвтэрч байна.

Медицина* сэтгүүлийн гуравдугаараас орчуулсан Г. ЦЭРЭНЖИГМЭД

ТОМОГРАФ

«Томограф» хэмээх тооцоолон бодох төхөөрөмж амьд бие махбод, түүн дотроос уураг тархины эд эсийг хөндөхгүйгээр судлах боломж олгож байна. ЗХУ-ын Киев хотын реле ба автоматик нэгдэл анхны томографыг одноор үйлдвэрлэн гаргаж эхэллээ. Энэ тухай тус нэгдлийн захирал ЗХУ-ын төрийн шагналт В. Пономарев «Тооцоолон бодох томографын бүтээх нөхцөлийг шинжлэх ухаан техникийн өнөөгийн хөгжил дэвшил олгож байгаа юм» гэж мэдэгдээд «Энэ багажийг электроник, нарийн механик, математик хангамж, онц тогтвортой рентген техник зэрэгт үндэслэн бүтээсэн юм» гэжээ.

Телевизийн дэлгэцнээ (дисплейн) гарах томограмм нь биетийг нарийн багц рентген цацрагаар шинжлэх явцад үүснэ. ЗХУ-ын хамгийн сүүлийн загварын энэхүү томограф нь ажиллагааныхаа хүрдаар зүй ёсоор дэлхийд хосгүйд тооцогдоно. Өөрөөр хэлбэл өвчтөнийг шинжлэснээс хойш секунд хүрэхгүй хугацаанд уураг тархины төлөв байдлын тухай мэдээлэл телевизийн дэлгэцнээ гардаг. Тэгвэл ЗХУ-ын хамгийн анхны загварын томографын хувьд энэ хугацаа 120 секунд байжээ. Киев хотын уураг тархины мэс заслын эрдэм шинжилгээний институтын захирал ЗХУ-ын анагаах ухааны академийн жинхэнэ гишүүн ЗХУ-ын социалист хөдөлмөрийн баатар А. Ромоданов «Тооцоолон бодох томограф ашиглаж байгаа нь анагаах ухааны хувьд нэг төрлийн хувьсгал юм. Хүний бие махбодод харш нөлөө үзүүлэхгүйгээр уураг тархины төлөв байдлын тухай мэдээлэл хүлээн авах боллоо.

Томограф нь эмч нарт мэс засал хийхээс өмнө ба хийсний дараа уураг тархин дахь үйлдлийг хянах дүгнэлт өгөх боломж олгож байна» гэж мэдэгджээ.

«Неделя» сэтгүүлийн 1985 оны 22-дугаараас орчуулсан Ж. ӨЛЗИЙТ

ДЭЛХИЙН ЭРҮҮЛИЙГ ХАМГААЛАХ БАЙГУУЛЛАГЫН XXXVIII ЧУУЛГАН

Энэ онд Дэлхийн Эрүүлийг Хамгаалах [Байгууллагын XXXVIII] чуулган Женевт болж өнгөрлөө.

Тус чуулганаар 34 сэдвийг хамарсан 40 гаруй асуудлыг хэлэлцэж холбогдох тогтоолууд гаргав.

БНМАУ-ын төлөөлөгчдийн тэргүүн, Эрүүлийг хамгаалах Яамны сайд Д. Ням-Осор тус чуулган дээр уг хэлж «XXXVIII чуулган, фашизм, милитаризмыг ялсны 40 жил, НҮБ-ын 40 жилийн ойн жил ялангуяа цөмийн дайны аюул заналыг сэрэмжлэн зайлзуулах эрхэм чухал асуудлыг шийдвэрлэх өндөр хариуцлага тулгарч буй уед болж байна гэдгийг цохон тэмдэглээд түүхийн ахар богино хугацаа болон энх тайвны 40 жилд хүн төрөлхтөн урьд өмнө, бүтээгээгүй ихийг бүтээсэн, энэ их ололт амжилтыг тодорхойлогч нэн чухал үзүүлэлтийн салшгүй хэсэг нь дэлхийн хүн амын эрүүл мэндийн өнөөгийн түвшин юм. Энэ зууны эцэст манай гаригийн нийт хүн ам, хүн бүр эрүүл байх үндсэн эрхээ бүрэн дүүрэн эдлэх, нийгэм улс төр, эдийн засгийн бодит бодлогоор хангагдсан байх ёстой гэдгийг тэмдэглэв. «ДЭХБ-д олон улсаас иргэдийг авч ажиллуулах тухай» асуудлыг хэлэлцэхэд манай төлөөлөгч уг хэлж БНМАУ-аас оруулж буй тогтоолын төсөл, түүний үндсэн ач холбогдлыг тайлбарлав.

Германы фашизм, японы милитаризмыг ялсны 40 жилийн ойтой холбогдуулан дайны хор уршиг, эрүүл мэндэд учруулах хохирлыг сурталчлах талаар социалист орнуудаас тавьсан зорилт амжилттай хэрэгжив.

Африк, Латин Америкийн зарим орнуудын талаар гарсан улс төрийн ач холбогдол бүхий тогтоолууд социалист лагерийн орнуудын баримталж буй бодлогын дагуу батлагдлаа.

Африкийн хөгжиж буй орнууд, Никарагуагийн талаар явуулж буй АНУ, Израилын бодлого ганцаардмал байдалд орж байгаа нь эдгээр орнуудын талаар гарсан тогтоолуудын санал хураалтаар тодорхой харагдав.

ЭМНЭЛГИЙН БАГАЖ, ТОНОГ ТӨХӨӨРӨМЖ, ЭМИЙН ҮЗЭСГЭЛЭН

Манай эх орны нийслэлд ЗСБНХУ-ын | Бух Холбоотын „Мед-экспорт“ нэгдэл эмнэлгийн багаж, тоног төхөөрөмж, эмийн үзэсгэлэн нээгдэв.

Улс хоорондын эдийн засгийн хамтын ажиллагааг хөгжүүлэн бэхжүүлэхэд оруулсан хувь нэмрийг нь өндрөөр үнэлж өлон улсын «Алтан меркурий» шагналаар тус нэгдлийг шагнажээ.

«Медэкспорт» нэгдэл нь дэлхийн 90 гаруй орны гадаад худалдааны 400 гаруй байгууллагатай холбоотой ажиллан тэдгээрт хамгийн орчин үеийн эм, эмнэлгийн багаж төхөөрөмжийг нийлүүлдэг. Манай орны хот, хөдөөний бүх эмнэлэг, урьдчилан сэргийлэх байгууллагад зөвлөлтийн орчин үеийн эмнэлгийн техник, тоног төхөөрөмж, багаж хэрэгсэл, эмийг өргөн хэрэглэж байна. Мөн ЗХУ-д үйлдвэрлэсэн эмчилгээний өндөр идэвхтэй эмүүдийг манай орны эмнэлгийн ажилтнууд хөдөлмөрчид өндөр үнэлдэг билээ.

Манай гадаадаас худалдан авч байгаа нийт эм, эмнэлгийн тоног төхөөрөмж багаж хэрэгслийн 70 гаруй хувийг «Медэксорт» нэгдэл нийлүүлэн хангаж байгаа юм.

«Медэксорт» нэгдэл нь жил бүр олон улсын үзэсгэлэн яармагт 6—8 удаа оролцож, 8—12 удаа төрөлжсөн үзэсгэлэн зохион байгуулдаг юм.

Тус үзэсгэлэнд тавигдсан нэг ортой барокамер, өвчтөний биеийн байдалд олон төрлийн шинжилгээ, бичлэг хийх полиграф, зөөврийн болон суурин рентген аппарат манай эмч мэргэжилтнүүдийн анхаарлыг ихэд татлаа. Мөн эх нялхсын болон бөөрний зэрэг нэлээд өвчнийг анагаах хэт авианы олон төрлийн аппарат, дотор эрхтэн дурандах эндоскопийн аппаратууд, мэс засал, чих, хамар, хоолойн төрөл бүрийн багажийг үзэгч олон өндөр үнэллээ. Орчин үеийн өндөр идэвхтэй эмүүд эмч, эм зүйчдийн сонирхлыг татлаа.

Үзэсгэлэнгийн үеэр зөвлөлтийн анагаах ухааны ололт амжилт, эмнэлгийн багаж, тоног төхөөрөмжийн тухай кино үзүүлж, монгол зөвлөлтийн эмч мэргэжилтнүүд уулзаж санал бодол, туршлагаа өргөн нөөр солилцов.

МАНАЙ СУРВАЛЖЛАГЧ

ЭМЧИЛГЭЭ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТЭРГҮҮН ТУРШЛАГА

Улсын нэгдсэн тусгай эмнэлгийн сэхээн амьдруулах тасгийн хамтодон, эмчилгээ, үйлчилгээндээ анагаах ухааны суулийн үеийн ололтыг ашиглан шинийг санаачлан ажиллаж байна.

Бронхийн багтраа өвчин болон бусад эмгэгийн байдлаас амьсгалын дутагдалд орсон өвчтөнүүдэд зохиомол амьсгалын аппаратаар эмчилгээ хийж, уушгины эмгэгийн үед бронхофиброскопийн тусламжтайгаар гуурсан хоолойг угаах буюу зурхний шигдээс өвчний үед кардиомонтор аппарат ажиглаж эмчилгээ хийх зэрэг орчин үеийн аргуудыг эмчилгээнд нэвтрүүлж үр дунд хүрч байна.

Сэхээн амьдруулахын ерөнхий эмч Д. Нэргүй болон их эмч Ухнаа, Ж. Адъяабазар нар нь олон хүний амь нас аварч, одны талархал хүлээж байна. Асрагч Ц. Должинг ачтан гэж ярих нь олонтой. Тэрхөнгөн шуурхай үйлчилгээ, зэлдэг зөөлөн аашаараа олны хайр хүлээн хүн юм.

Ө. Гүнд



ДОРЖИЙН РАВДАНДОРЖ

Анагаах ухааны дээд сургуулийн мэдрэл сэтгэц гэм судлалын тэнхимийн эрхлэгч, Монголын мэдрэлийн эмч нарын нийгэмлэгийн дарга, ерөнхий мэргэжилтэн, дэд эрдэмтэн доцент Доржийн Равдандорж хүндээр өвчилж байгаад 1985 оны 9 дүгээр сард нас нөгчiv.

Д. Равдандорж 1933 онд Архангай аймгийн Цэнхэр сумын нутагт ард Доржийн гэр бүлд төрж, бага, дунд сургууль болон Монгол улсын их сургуулийн хүн эмнэлгийн факультетэд суралцан, хүний их эмчийн мэргэжил эзэмшсэн бөгөөд 1956 оноос Хэнтий, Дорнод аймагт эмч, мэдфэлийн эмчээр ажилдаж, 1962 оноос Анагаах ухааны дээд

Сургуульд багш, тэнхимийн эрхийг зэрэг хариуцлагатай ажил хийж байв. Д. Равдандорж 1957 онд МАХН-ын гишүүнд элсчээ.

Д. Равдандорж 1971 онд „Тархины бүрхүүл судасны өвөрмөц үрэвслийн эмнэл-зүй, эмчилгээ“ сэдвээр анагаах ухааны дэд эрдэмтний зэргийг амжилттай хамгаалж, 1978 онд доцент цол хүртсэн бөгөөд эрдэм шинжилгээний 40 гаруй бүтээл түүрвисны дотор суралчихиг, сургалтын гарын авлага бичиж хэвлүүлсэн юм.

Д. Равдандорж эх орондоо эмнэлгийн дээд боловсролтой мэргэжилтэн бэлтгэх үйлсэд 20 гаруй жил хүчин зүтгэсэн бөгөөд түүний шууд удирдлага, оролцоотойгоор мэдрэлийн эмчийн нарийн мэргэжил эзэмшилэх болон дээшлүүлэх курсээр 100 гаруй нарийн мэргэжлийн эмч мэргэжилтнүүд төгсөн гарч, манай эх орны хот, хөдөөд амжилттай ажиллаж байна.

Д. Равдандорж өндөр мэргэжлийн зөвлөх эмч, эрдэмтэн, туршилагатай сурган хүмүүжүүлэгч төдийгүй, авьяаслаг зохион байгуулагч байв. Тэрээр Клиникийн нэгдсэн III эмнэлэг, Улсын клиникийн төв эмнэлэг, Клиникийн нэгдсэн II тусгай эмнэлэг зэрэг газруудад зөвлөх эмчээр ажиллаж байлаа.

Д. Равдандоржийн хөдөлмөрийг нам, засаг өндөр үнэлж, „Хөдөлмөрийн хүндэт медаль“, Ардын хувьсгалын 50 жилийн ойн медаль, „Эмнэлгийн сайчууд“ тэмдгээр шагнажээ.

Д. Равдандорж ажилч хичээнгүй, үнэнч шударга, энгийн даруул төлөв зантай, хамт олны дунд өндөр нэр хүндтэй, шилдэг сурган хүмүүжүүлэгч, коммунистын нэг байлаа.

Д. Равдандоржийн уйгагүй хөдөлмөрч, ажил хэрэгч, энгийн даруул төлөв зан чанар нь мэргэжил нэгт нөхөд, түүний хүмүүжүүлсэн мянга мянган шавь нарт эрхэм дууриал болсоор байх болно.

ЭРҮҮЛИЙГ ХАМГААЛАХ ЯАМ.
АНАГААХ УХААНЫ ДЭЭД СУРГУУЛЬ

ЭМНЭЛГИЙН ХЭВЛЭЛИЙН НЭГДСЭН РЕДАКЦЫН ЗӨВЛӨЛ

Ж. Раднаабазар (Эрхлэгч) Л. Буджав, Ш. Вайчаарай (Хариуцлагатай нарийн бичгийн дарга) Б. Гош, Б. Дэмбэрэл, Г. Даашээзэг, Ч. Долгор, Ш. Жигжидсүрэн, Т. Зориг, Ж. Купул, Э. Лувсаадагзаа, П. Нямдаваа, Б. Рагчaa, Г. Цагаанхүү, Б. Шижирбаатар, И. Шура


Техник редактор О. Тулгалаг, Хялагч Ж. Сосорбарам

Өрөлтөлд 1985 оны 9 сарын 25 ид орж 2203 ш хэвлэв.

Цаасны хэмжээ 70x108 1/16. Хэвлэлийн хуудас 5,0

х. и. х. 5,6 Зах №С—112

Д. Сүхбаатарын нэрэмжит Улсын хэвлэлийн комбинатад
хэвлэв. Д. Сүхбаатарын талбай—6



ШИНЭ М

ГЕМИТОН (БНАГУ-д үйлдвэрлэс)

Фармакологийн үйлдэл: Гемитон нь инфизики фентоламинттай адим адрен идэвхтэй системд нөлөөлөх боловч цусны дараалт бууруулдаг өвөрмөц онцлогтой. Бэлдмэлийг хэрэглэсний дараа альфи адрецирецептор сэргэснээс цусны дараалт түрүү ихсээд дараа нь тогтвортой бууриа.

Гемитон тархины торлог байгууламжийн нөлөөлсөнөөс тайвшруулах үйлдэл үзүүлнэ. Мөн нүдний даралтыг буурууна.

Хэрэглэх заавар: Гипертонийн яиз бүрийн хэлбэр ялангуяа бэөрүү архаг дутагдлаас шилтгаалсан гипертониы үед хэрэглэнэ. Бусад бэлдмэлүүдээс ялаатай нь тогтвортой гипертонийн үед үр нөлөө сайтай.

Хэрэглэх арга, тун: Гемитоны хэрэглэх тунг өвчтөний өвөрмөц байдлыг харгалзан тогтооюу. Ер нь хамгийн бага тун нь плүү нөлөөтэй. 0,075 мг-аар өдөрт 2—4 удаа ууна. Хэрэв дараалт бууруулах үр нөлөө хангалтгүй байвал иэг удаагийн тунг 1—2 өдөрт 0,0375 мг-аар (0,075 мг-ийн 1/2 шахмал) нэмэгдүүлэн 0,15—0,3 мг-д (өдөр 2—4 удаа) хүргэнэ. Хоногийн тун 0,3—0,45 мг заримдаа 1,2—1,3 мг байна. Хоногт 0,45—0,6 мг тунгаар хэрэглэхэд үр нөлөө хангалтгүй байвал шаас хөөх эм, резерпин, альфи, метиодифа октадин буюу бусад цусны дараалт бууруулах бэлдмэлтэй хамт хэрэглэнэ.

Дунд зэргийн буюу ахмад наасны ялангуяа тархины судасны хатуурлын илрэлтэй, энэ бэлдмэлд хэт мэдрэг хүмүүст эмчилгээг 0,0375 мг (1/2 шахмал)-аар эхэлнэ. Эзлжит эмчилгээг 1—2 стр хийх бөгөөд зайншгүй шаардлагатай үед 6—12 сар түүнээс дээш хугацаагаар үргэлжлүүлж болно.

Гемитоны эмчилгээний үед өвчтөний цусны дараалтыг хөвтээ, босоо байдала тогтмол хэмжиж бийх хэрэгтэй. Эмчилгээг гэвэл зогсоож болохгүй, тунг 7—10 өдрийн турш аажмын бууруулж эмчилгээг зогсоон.

Цээрлэх үе: Жолооч зэрэг нарийн анхаарал шаарддагдах ажилтай хүмүүс ажлын цэгээр хэрэглэж болохгүй. Эмчилгээний үед согтууруулах ундаа, нийр суулзах би нийролентийн бүлгийн эм хэрэглэхийг.

Гаж нөлөө: Ам ангах, өтгон хатах, ядрах, бие сулрах, сэтгэл хөөрөх, тайван бини болох, сүсанд тарих үед цусны дараалт ихсэх гаж нөлөө гарч болно.

Эмийн хэлбэр, савлах: 0,075 мг, 0,3 мг 0,015 мг шахмалыг 30 буюу 50 ширхгээр савласна.

СЕРПИН (Энэтхэг улсад үйлдвэрлэв)

Нийтлага: Нэг шахмалд раувольфи гэдэг ургамлыг ийллээр алкалонд 4 мг орсон байгаа.

Фармакологийн үйлдэл: Тайвшруулах, цусны дараалт бууруулах үйлчилгээний тундээнд агуулагдах 21 төрлийн алкалонд бүгд орсон тун цусны даралт бууруулахад резециниээс плүү юм. Серинийг шаас хөөх, вегетатив мэдрэлийн заигилзэл хориг үүсгэдэг бэлдмэлүүдтэй хамт хэрэглэхэд тэдгээрийн үйлдлийн хүчтэй нэмэгдүүлж хортой гаж нөлөө гарахыг багасгана. Энэ нь хорт явцтай гипертонийн өвчний эмчилгээд ашигтай.

Хэрэглэх заавар: Зүрх судас би баөрний гаралтай гипертони, цусны дараалт иххэсэнээс зүрхний ажиллагаа тасалдах, истери, наасанд хүрэгсэд ба хүхүүдийн мэдрэлийн хүчдэл, цочромтгой байдал, агинса, судас хатуурлын солиорол, бэлгийн дур буурах, психосомотик өөрчлөлт, тиреотоксинко зэргийн үед хэрэглэнэ. Мөн загатаат дерматозын үед хэрэглэж болно.

Хэрэглэх арга, тун: Гипертонийн хөнгөн хэлбэрийн үед өдөрт 1/2-ээс 1 шахмалаар 2—3 удаа, хүнд хэлбэрийн үед 2 шахмалаар 3 удаа тус тус ууна. Истерийн үед 1—3 шахмалаар өдөрт 3 удаа тайвшруулах зорилгоор хэрэглэнэ.

Гаж нөлөө: Серинийг удаан хугацаагаар хэрэглэхэд хамар битүүрэх, зүрхийн ритм удаашрах, ходоодны ажиллагаа хямрах, (бага зэрэг) нойрмоглох, бие сулрах зэрэг гаж нөлөөн гарч болно.

Эмийн хэлбэр, савлах: Шахмал хэлбэрээр үйлдвэрлэж 50 буюу 100 ширхэээр савласан байна.

**УЛСЫН ЭМ ХАНГАМЖ ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ГАЗРЫН
МЭДЭЭЛЭЛ ТЕХНОЛОГИЙН ТАСАГ**